



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага




Европын Холбоо
санхүүжүүлэв



АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх, үүрэг, оролцоо

Модуль 8. Хүчирхийлэл болон мансууруулах
бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх



Бусокорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхост



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Европын Холбоо
санхүүжүүлэв

АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх, үүрэг, оролцоо

Модуль 8. Хүчирхийлэл болон мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх

Бусакорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхорст

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2020
Анхны хэвлэл 2020

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцын 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХТ-ны Хэвлэл нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу. Олон улсын хөдөлмөрийн товчоо ийм хүсэлтийг таатай хүлээн авах болно.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

Амьдрах ухааны сургалтын багц: Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо, Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчоо — Бээжин: ОУХБ, 2020

ISBN:978-92-2-0325605 (хэвлэмэл) ISBN:978-92-2-0325612 (web pdf)

Мөн Англи хэлээр: 3-R Trainers' Kit: Rights, Responsibilities and Representation for Children, Youth and Families. ISBN:978-92-2-0325599 (web pdf), Ulaanbaatar, 2020

МЭДЭГДЭЛ: 2020 ОНЫ ШИНЭЧИЛСЭН ХЭВЛЭЛ (МОНГОЛ, АНГЛИ ХУВИЛБАР)
--

Энэхүү сургалтын багцыг Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат(MNG/17/50/EUR)”-ны хүрээнд зөвлөх Бусакорн Суриясарн, Х.Өлзийтунгалаг нар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран боловсруулав.

Энэхүү сургалтын багцын үндсэн мэдээллийг дараах эх үүсвэрээс авч, Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулав: Empowerment for Children, Youth and Families: 3-R Trainers' Kit on Rights, Responsibilities and Representation, ISBN: 92-2-117849-8 (print), 92-2-117850-1 (web pdf), 92-2-117851-X (CD-ROM), Bangkok (2006) болон the 2017 edition, ISBN 978-92-2-130249-0 (print); 978-92-2-130250-6 (web pdf).

Уг сургалтын багцыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр гаргав. Сургалтын багцад тусгагдсан үзэл бодол нь Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.
--

НҮБ-ын практикт нийцүүлэн гаргадаг ОУХБ-ын хэвлэл нийтлэлд ашиглагдсан тодорхойлолт, тусгагдсан материалууд нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс аливаа улс орон, бүс, газар нутаг, эрх барих байгууллагын эрх зүйн байдал эсвэл тэдгээрийн хил хязгаар тогтоохтой холбоотой ямарваа үзэл бодол илэрхийлээгүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа, бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчооноос хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг биш юм.

Байгууллагуудын болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүний нэр, үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой байгууллагын нэр, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь ч тэдгээрийг үгүйсгэсэн асуудал биш болно.

ОУХБ-ын хэвлэл, цахим бүтээгдэхүүний талаарх мэдээллийг www.ilo.org/publns хаягаар авах боломжтой.

Уг сургалтын багцын агуулга, түүнд илэрхийлэгдсэн үзэл бодлыг зохиогчид өөрсдөө хариуцах бөгөөд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.
--

Хавтасны болон дотор зургийг Ай Си Си Ди ХХК зурав.
Хэвлэлийн эх, график дизайныг Соёмбо принтинг ХХК-д бэлтгэж, Монгол Улсад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Сүүлийн 10 жилд Монгол Улсын Засгийн газраас Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-ын 1999 оны 182 дугаар конвенц болон Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенцыг хэрэгжүүлэх чиглэлд олон тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн билээ. Энэхүү хүчин чармайлт нь “Тогтвортой хөгжлийг хангах хөтөлбөр 2030”-ын хүрээнд дэвшүүлсэн 2030 он гэхэд албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэргийг, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах зорилтуудтай бүрэн нийцэж байгаа юм.

Тогтвортой хөгжлийн эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл дэх хүүхдийн болон албадан хөдөлмөрийн талаарх ойлголтыг дээшлүүлэх шаардлага зайлшгүй байгааг холбогдох талууд онцолж байна. Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, залуучууд, гэр бүлтэй ажиллах чиг үүрэг бүхий төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд ийм хэрэгцээ шаардлага бүр чухлаар тавигдаж байгаа юм.

“Амьдрах ухааны сургалт: Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо” сэдэвт сургагч багшид зориулсан сургалтын энэхүү багц нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх зорилготой. ОУХБ-аас анх 2006 онд боловсруулан гаргасан уг сургалтын багц гарын авлага олон оронд амжилттай хэрэглэгдэж байгаагийн дотор Монгол Улсад ОУХБ-АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд 2007 оноос хэрэглэж эхэлсэн юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) энэхүү сургалтын багц гарын авлагыг төрийн болон төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд хамгийн тохиромжтой, ач холбогдолтой хэмээн үзэж, Монголын нөхцөлд нийцүүлэн боловсруулахаар шийдвэрлэсэн билээ.

ОУХБ-аас Европын Холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төслийн¹ хүрээнд уг багц гарын авлагыг ийнхүү шинэчлэн боловсруулж, агуулгыг үндэсний сургагч багш нараар хэлэлцүүлэн баталгаажууллаа. Энэхүү сургалтын багцыг олон хүн ашиглаж, хамгийн хэрэгцээтэй зорилтот бүлэгтээ хүрч үр өгөөжөө өгнө гэж найдаж байна. Энэ цаг үед нүүрлээд буй КОВИД-19 цар тахал эмзэг бүлгийн, ялангуяа хүүхдийн аж байдалд хар сүүдрээ тусгаж, шинэ эрсдэл үүсгэж байна. Үүнээс үүдээд ирэх жилүүдэд эдийн засагт гарч болзошгүй таагүй өөрчлөлтийн нөхцөлд дэлхий даяар засгийн газар, төрийн байгууллагууд, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэлүүд болон иргэний нийгмийн байгууллагууд 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг, 2030 он гэхэд албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэргийг устгах зорилтуудыг хэрэгжүүлэх тун амаргүй сорилттой тулгарч байна. Энэхүү үйлсэд уг сургалтын багц бага ч болов хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Энэхүү багц гарын авлагыг шинэчлэн боловсруулж гаргах боломжийг бүрдүүлж, санхүүгийн харамгүй туслалцаа үзүүлсэн Европын Холбоонд ОУХБ, ГБХЗХГ гүн талархлаа илэрхийлье. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэнийг ч орхигдуулахгүй хамтдаа хөгжих зарчмыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болж, хүн амын эмзэг бүлгийг дэмжих чиглэлд бидний хамтын ажиллагаа үргэлжилнэ гэж найдаж байна.

Мижидсүрэнгийн Энх-Амар
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын дарга

Клэйр Куртье-Мюлдэр

ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг
хариуцсан товчооны захирал

¹ Төслийн бүтэн нэр: “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат” (MNG/17/50/EUR)

АГУУЛГА

Өмнөх үг	iii
Талархал	vii
Модулийн агуулга	v
Сэдэв 8.1 Хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ	3
Дасгал 8.1.1 Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн хэлбэрүүд	5
СХ. 8.1.1 А Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн түүхүүд	10
Нэмэлт мэдээлэл: Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийг хэрхэн даван туулах вэ	11
Дасгал 8.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл	13
СХ. 8.1.2 А: Гэр бүлийн хүчирхийллийн түүхүүд	19
Нэмэлт мэдээлэл: Гэр бүлийн хүчирхийлэл	22
Дасгал 8.1.3 Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл	24
СХ. 8.1.3 А: Дүрүүдийн тодорхойлолт	29
Нэмэлт мэдээлэл: Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл	30
Дасгал 8.1.4 Бэлгийн хүчирхийлэл	34
СХ. 8.1.4 А: Бэлгийн хүчирхийллийн түүхүүд	39
Нэмэлт мэдээлэл: Бэлгийн хүчирхийлэл	42
Дасгал 8.1.5 Бэлгийн хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ	54
СХ. 8.1.5 А: Бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлж, хэрхэн даван туулах вэ	59
Сэдэв 8.2 Согтууруулах ундаа болон мансууруулах бодисод хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?	61
Дасгал 8.2.1 Тойрог эргэлт: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөө	62
СХ. 8.2.1 А: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын үйлчилгээ	67
СХ. 8.2.1 Б: Согтууруулах ундаа, тамхи болон мансууруулах бодисын тухай өгөгдлүүд	68
СХ. 8.2.1 В: Хариултын хуудас: Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	70
Дасгал 8.2.2 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний талаар шийдвэр гаргах нь	72
СХ. 8.2.2 А: Үзүүлбэрийн өгөгдөл	76
СХ. 8.2.2 Б: Жишиг түүхүүд	77
Дасгал 8.2.3 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын эсрэг нөлөөллийн ажил	79
Унших материал	81

ТАЛАРХАЛ

Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулсан энэхүү багц гарын авлага нь ГБХЗХГ, ОУХБ-ын хамтын ажиллагаа, тууштай хүчин чармайлтын үр дүн юм.

Энэхүү ажилд олон улсын зөвлөх Бусакорн Суриясарн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч үнэтэй хувь нэмэр оруулсныг талархан тэмдэглэж байна.

Мөн ГБХЗХГ-аас байгуулсан сургалтын багцыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн дараах гишүүдэд талархлаа илэрхийлье. Үүнд:

- Пүрэвсүрэнгийн Алгирмаа (Модуль 4, 9, 10)
- Гомбын Ариунчимэг (Модуль 11)
- Жанцандоржийн Азжаргал (Модуль 2, 4, 9)
- Батсүхийн Батсайхан (Модуль 1, 3)
- Цанлигийн Баттуяа (Модуль 4)
- Сосорбурамын Болорцэцэг (Модуль 10, 11)
- Шархүүгийн Галбадрах (Модуль 6, 7)
- ЛГБТ Төв (Модуль 6)
- Баянбаатарын Оюундарь (Модуль 5, 8)
- Борбандийн Санжид (Модуль 3)
- Хуажингийн Өлзийтунгалаг (Сургагч багшийн гарын авлага).

Түүнчлэн энэхүү ажлыг санаачлан эхлүүлж, дэмжсэн ГБХЗХГ-ын дарга асан Очирбатын Алтансүхэд талархаж байна. Сургалтын багцыг үндэсний нөхцөлд тохируулан боловсруулахад шаардагдах мэдээллээр хангаж, монгол орчуулгыг хянан дэлгэрэнгүй санал, зөвлөмж өгч хувь нэмрээ оруулахын зэрэгцээ уг ажлыг уялдуулан зохицуулах үүрэг гүйцэтгэсэн ГБХЗХГ-ын Гэр бүл, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Жанцандоржийн Азжаргал, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш Хуажингийн Өлзийтунгалаг нарт талархлаа илэрхийлье. Мөн орчуулагчаар ажилласан Ванжилын Бэрцэцэг, Баттулгын Нармандах, монгол хэлээрх хувилбарыг хянан тохиолдуулсан Балчиндоржийн Туяа нарт талархаж байна.

ОУХБ-ын зүгээс уг ажилд Амгалангийн Лхагвадэмбэрэл, Баярсайханы Баярцэцэг, Бээжин дэх товчооны Париссара Льюкийт, Бангкок дахь Зохистой хөдөлмөрийг дэмжих багийн Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Барати Флюг нар хөтөлбөрийн, захиргааны болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан болно.

МОДУЛЬ 8. ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛОН МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Модулийн ерөнхий агуулга

Энэхүү модулийн хүрээнд бэлгийн дарамт болон дээрэлхэлт, бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэл зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг авч үзэхээс гадна мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой асуудлыг ярилцах болно. Гэр бүл, ажлын байр болон боловсролын орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх, мансууруулах бодис, согтууруулах ундааны хэрэглээнээс сэргийлэх асуудалд гол анхаарлаа хандуулах болно. Дасгалууд нь дарамт, дээрэлхэлттэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, түүнээс сэргийлэх арга замаа олох, түүнчлэн мансууруулах бодис болон согтууруулах ундаа хэрэглэхийг тулгах, албадах тохиолдолд “Үгүй” гэж хэлж сурахад оролцогчдод туслах зорилготой.

Энэ модуль 2 сэдвээс бүрдэнэ:

Сэдэв 8.1 Хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ

Сэдэв 8.2 Согтууруулах ундаа болон мансууруулах бодисод хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?

Сэдэв 8.1 Хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ	Зорилго	Хугацаа
Дасгал 8.1.1 Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн хэлбэрүүд	- Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн хэлбэрүүдийг тодорхойлох - Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн үр дагаврыг ойлгох - Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн эсрэг авч болох арга хэмжээг тодорхойлох	60 минут
Дасгал 8.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл	“Гэр бүлийн хүчирхийлэл” ойлголттой танилцаж, гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг мэдэж авах - Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, үүссэн асуудал бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох - Гэр бүлийн гишүүдээ гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нь хүн бүрийн үүрэг хариуцлага болохыг ойлгох	90-120 минут
Дасгал 8.1.3 Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл	- Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, түүний шалтгааныг тодорхойлох - Ажлын байранд дарамт, хүчирхийлэл үүсэх эрсдэлтэй нөхцөлийг тодорхойлох - Ажлын байран дахь дарамт, хүчирхийллээс сэргийлэх арга хэмжээг тодорхойлох	90 минут

Дасгал 8.1.4 Бэлгийн хүчирхийлэл	- Бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар мэдэх - Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой бодит баримт болон ташаа ойлголттой танилцах - Бэлгийн хүчирхийллийн эсрэг ямар арга хэмжээ авч болохыг мэдэх	120-145 минут
Дасгал 8.1.5 Бэлгийн хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ	- Бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийг мэдэж авах - Бэлгийн хүчирхийллийн үр дагаврыг ойлгох - Бэлгийн хүчирхийлээс сэргийлэх арга замуудтай танилцах - Хүчингийн гэмт хэрэг болон бэлгийн халдлагыг мэдээлэхдээ юу хийх ёстой тухай мэдэж авах	90-105 минут
Сэдэв 8.2 Согтууруулах ундаа болон мансууруулах бодисод хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?		
	Зорилго	Хугацаа
Дасгал 8.2.1 Тойрог эргэлт: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөө	- Тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хүний бие болон ухаанд ямар сөрөг нөлөө үзүүлдгийг ойлгох - Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний талаарх ташаа ойлголт болон бодит баримтыг ялгаж сурах - Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хэрэглээтэй холбогдон гардаг аюултай бэлгийн харилцаа, бэлгийн мөлжлөг болон хүчирхийллийн эрсдэлийг ойлгох	60 минут
Дасгал 8.2.2 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний талаар шийдвэр гаргах нь	- Нөхцөл байдалд шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх, ухаалаг шийдвэр гаргах, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой үе тэнгийнхний дарамтыг зохистой давж гарах - Үндэслэлтэйгээр татгалзах чадварыг эзэмших дасгал хийх - Согтууруулах ундаа, мансууруулах бодисоос татгалзах нь сул доройн шинж бус харин хүч чадалтайн шинж болохыг ойлгох	60 минут
Дасгал 8.2.3 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын эсрэг нөлөөллийн ажил	Согтууруулах ундаа, мансууруулах бодисын эсрэг нөлөөлөгч байх	45 минут
Нийт хугацаа 10 цаг 5 минут – 11 цаг 35 минут		

Сэдэв 8.1 Хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?



Агуулга

Энэ сэдвийн дасгалууд нь бэлгийн дарамт болон дээрэлхэлт, гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байран дахь хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн асуудалтай холбоотой. Хүчирхийллийн шалтгаан болон үр дагавар, хүчирхийллээс хамгаалах асуудлыг хэлэлцэнэ. Хүүхэд, эмэгтэйчүүд ихэнхдээ чимээгүй шаналж үлддэг нь хүчирхийллийг улам өөгшүүлдэг. Иймд энэхүү сэдвээр хүчирхийллийн эсрэг дуугарч, бусдад мэдээлж, гэр бүл, ажлын газрынхан, олон нийт болон шийдвэр гаргах түвшнийхэнтэй хамтран хүчээ нэгтгэж тэмцэхийн чухлыг таниулна.



Үндсэн мэдээлэл

- Дарамт, дээрэлхэлт болон бэлгийн хүчирхийлэл төрөл бүрийн хэлбэрээр илэрдэг ба сургууль, гэр бүл, ажлын байр, олон нийтийн газар гээд хаана ч тохиолдож болдог.
- Бэлгийн дарамт, дээрэлхэлт, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл нь хохирогч, түүний гэр бүл, хамт олон, нийгэмд бүхэлд нь сөрөг үр дагавартай.
- Бие махбодын болон бэлгийн хүчирхийллийг олон улс оронд гэмт хэрэгт тооцдог бөгөөд хатуу ял шийтгэлтэй байдаг. Харин үг хэлээр доромжлон гутаах, сэтгэл санаагаар дарамтлах, бэлгийн дарамт зэрэг нь гэмт хэрэгт барагтай тооцогддоггүй ч гэр бүл салах, мөн эцэг эх байх, хүүхдээ асран хамгаалах эрхийг нь цуцлах үндсэн шалтгааны нэгд зүй ёсоор тооцогддог.
- Гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхийн өнцөг булан бүрд тохиолддог, төрөл бүрийн хэлбэрээр илэрдэг билээ. Үүнд: бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн гэсэн 4 хэлбэртэй байх бөгөөд хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны ихээхэн хэсэг нь, заримдаа эрчүүд ч гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг.
- Ажлын байран дахь хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн зэргээр ямар ч хэлбэртэй байж болох бөгөөд ажлын байранд эсвэл ажил хөдөлмөртэй холбоотой нөхцөлд үгээр доромжлох, бэлгийн дарамт үзүүлэхээс эхлээд биед халдах хүртэлх бүх үйлдлийг хамарна.
- Бэлгийн хүчирхийлэл нь бэлгийн дур хүсэл гэхээсээ илүүтэй хүч чадлаа буруугаар ашиглахтай холбоотой. Өөрөөр хэлбэл хэн нэгэнд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн дарамт учруулж хохироодог, хэний ч хүлээн зөвшөөрч боломгүй үйлдэл, зан үйлийг хэлнэ.
- Хүүхэд, ялангуяа бага насны охид, заримдаа хөвгүүд, эмэгтэйчүүд ч бүх төрлийн хүчирхийллийн хохирогч болдог. Ихэнх эрчүүд хүчирхийлэл үйлддэггүй ч хүчирхийлэгчдийн дийлэнх нь нөгөө тал хүссэн хүсээгүй бэлгийн хавьталд орох эрхтэй гэж үздэг эрчүүд байдаг.
- Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг ихэнх тохиолдолд бүртгэгддэггүй, нууцлагдан үлдэж, хэрэгтнийг шийтгэлгүй өнгөрөөж, харин хохирогчид өөрсдийгөө буруутгаж үлддэг нь гэмт хэрэгтнүүдийг улам өөгшүүлж, нөхцөл байдлыг улам дордуулдаг.
- Насанд хүрэгчид нь хүүхэд залуучуудыг төрөл бүрийн хүчирхийллээс, түүний дотор бэлгийн дарамт хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй.
- Гэр бүл, хамт олон, ажлын байр, боловсролын байгууллагууд зэрэг бүхий л талууд гэр бүлийн, ажлын байрны, сургуулийн орчинд ямар нэгэн, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, гэмт хэрэгтнийг шийтгэх талаар зохих арга хэмжээнүүдийг авах үүрэгтэй.

- Хэрэв та бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртөхөөр нөхцөлд орсон бол амиа алдана гэж айлгүйгээр хүсэхгүй байгаагаа илэрхийлэх хэрэгтэй. Бусдаас тусламж хүсэх хэрэгтэй. Чимээгүй өнгөрч огт болохгүй.
- Хүчин болон бусад төрлийн бэлгийн халдлагыг цаг тухайд мэдэгдэж байх нь чухал юм. Энэ бол ноцтой гэмт хэрэг бөгөөд буруутан ял шийтгэлээ хүлээх ёстой. Хүчирхийллийн тухай мэдээлэхдээ хамгийн итгэлтэй хүн, боломжтой бол хүчирхийлэл үйлдэгдэх үед гэрч байсан хүнийг хамт авч явах хэрэгтэй.
- Хөвгүүд болон эрчүүдэд охид эмэгтэйчүүдийг сексийн хэрэгсэл бус, хүн гэсэн утгаар нь үнэлж, хүндэтгэж байхыг сургаж, харин охид эмэгтэйчүүдийг өөртөө итгэлтэй байж, нийгэм эдийн засгийн болон бэлгийн халдашгүй, бие даасан байдлаа хангаж сурахад нь туслах хэрэгтэй.



Дасгалууд

Дасгал 8.1.1 Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн хэлбэрүүд

Дасгал 8.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл

Дасгал 8.1.3 Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл

Дасгал 8.1.4 Бэлгийн хүчирхийлэл

Дасгал 8.1.5 Бэлгийн хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ



Холбогдох сэдвүүд

5.4. Нийгмийн болон харилцааны ур чадварууд

8.2 Согтууруулах ундаа болон мансууруулах бодист хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?

10.2 Ухаалаг шилжин суурьшигч

11.2 Хөдөлмөрлөх эрх



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

8.1.1-ээс 8.1.4 хүртэлх дасгалуудаас нэг ба түүнээс дээш дасгалыг зорилтот бүлэгтээ тохируулан сонгоорой. Зарим нь давхцаж болох ч ямар ч дарааллаар ажиллах боломжтой. Дасгал 8.1.5 нь хамгийн сүүлд ажиллахад тохиромжтой.

Хүчирхийллийн хохирогч болж байсан зарим оролцогчдын хувьд энэхүү сэдэв эмзэг тусаж магад. Хэрэв та сургалтыг бие даан явуулж чадна гэдэгтээ эргэлзэж байгаа бол энэхүү эмзэг асуудлын талаар хэрхэн ярилцах талаар хүчирхийллийн хохирогчтой ажиллаж байсан туршлагатай мэргэжлийн хүнээс зөвлөгөө аваарай. Боломжтой бол тэднийг зөвлөхөөр оролцуулаарай.

Дасгалуудыг ажиллах үедээ оролцогчдыг ажиглаарай. Хэн нэг нь таагүй байх, уурлах, дуугаа хураах зэрэг тохиолдолд тусад нь уулзаж, тайвшруулах хэрэгтэй. Шаардлагатай бол мэргэжлийн хүмүүстэй холбож өгөх хэрэгтэй.

Дасгал 8.1.1 Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн хэлбэрүүд



Зорилго

- Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн хэлбэрүүдийг тодорхойлох
- Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн үр дагаврыг ойлгох
- Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн эсрэг авч болох арга хэмжээг тодорхойлох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

Өрөөний голд хангалттай зайтайгаар том тойрог болон суух



Ашиглах материал

Самбарын цаас, самбарын үзэг, скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

8.1.1 А: Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн түүхүүд

Нэмэлт мэдээлэл: Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийг хэрхэн даван туулах вэ ?



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Жишиг түүх: Сээтэгнэл үү эсвэл бэлгийн дарамт уу? -15 минут
2. Дарамт болон дээрэлхэлт - 20 минут
3. Дарамт болон дээрэлхэлтийн үр дагавар - 20 минут
4. Дүгнэлт - 5 минут

Бэлтгэл

Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.1 А-н хоёр түүхээс оролцогчдод хамгийн тохиромжтой нэгийг сонгоно. Сургалт эхлэхийн өмнө зарим оролцогчдыг Алхам 1-н үед үзүүлбэрийн дүрд тоглохыг хүсэж, бэлдүүлнэ (Ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтын тухай Дасгал 8.1.3-д дэлгэрэнгүй үзнэ гэдгийг анхаараарай).

Алхам 1. Түүх: Сээтэгнэл үү эсвэл бэлгийн дарамт уу? – 15 минут

Сургалтын үеэр оролцогчид хэзээ ч тохиолдож болох таагүй нөхцөлүүдийн тухай мэдэж авах бөгөөд тийм тохиолдолд яах ёстой талаар суралцах болно гэдгийг тайлбарлана. Үзүүлбэр бэлдсэн оролцогчдыг үзүүлбэрээ үзүүлэхийг хүснэ (Үзүүлбэр 5 минутад багтах ёстой).

Дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ:

1-р түүх: Ажлын байран дахь бэлгийн дарамт

- Туяад ямар асуудал тохиолдсон бэ?
- Туяагийн даргад ийм үйлдэл хийх эрх бий юу?
- Туяагийн хариу үйлдэлтэй санал нийлж байна уу?
- Ийм нөхцөлд чи яах байсан бэ?
- Туяагийн даргын энэ үйлдлийг чи юу гэж тодорхойлох вэ?
- Энэ сээтэгнэл үү эсвэл бэлгийн дарамт уу?
- Ялгааг нь тайлбарлаж чадах уу?

2-р түүх: Сургууль дээрх дээрэлхэлт

- Энэ түүхэд ямар үйл явдал гарч байна вэ?
- Болдын асуудал юунд оршиж байна вэ?
- Ахлах ангийн эрэгтэй хүүхдүүд ямар учраас Болдтой ийм байдлаар харьцаж байна вэ? Чи энэ талаар юу гэж бодож байна вэ?
- Ахлах ангийн эрэгтэй хүүхдүүдийн зан үйлийг чи хүлээн зөвшөөрч байна уу? Яагаад?
- Болдын хариу үйлдэлтэй чи санал нийлж байна уу? Яагаад?
- Ийм нөхцөлд чи яах байсан бэ?
- Чиний бодлоор энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой юу?

Оролцогчдын хариултыг самбар/самбарын цаасан дээр жагсааж бичнэ.

Зарим гол санааг онцолж, "бэлгийн дарамт" болон "дээрэлхэлт" гэдэг ойлголтыг тайлбарлана.

- о **Сээтэгнэл** бол аль аль талд нь таалагдаж, аль аль талын хүсэж байгаа үйлдэл.
- о **Бэлгийн дарамт** бол аль нэг тал нь хүсээгүй байхад гаргаж байгаа бэлгийн сэдэл бүхий үйлдэл юм.
- о **Дээрэлхэлт** бол олон давтамжтай, байнга тохиолддог, нэг ба нэг хэсэг хүмүүс болон тэдний ажил гүйцэтгэлд чиглэсэн сөрөг халдлага юм.

- о **Бэлгийн дарамт болон дээрэлхэлт** нь сургууль, ажлын байр, олон нийтийн газар, гэр бүлд г.м. хаана ч тохиолдож болдог онцлогтой. Ажилтай холбоотой тохиолдолд ажил олгогч, хамт ажиллагч, дарга, үйлчлүүлэгч эсвэл ажлын шугамаар харилцаж байгаа хэнээс ч ийм үйлдэл гарч болно.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Нэмэлт мэдээллээс Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн тодорхойлолт болон Монгол дахь дарамт, дээрэлхэлтийн нөхцөл байдлын талаар уншиж танилцаарай. Зорилтот бүлгээс тэдний орон нутаг, ажлын байр эсвэл сургуулийн орчинд гардаг дарамт дээрэлхэлтийн нийтлэг хэлбэрийн талаар асууж мэдээрэй. Тэдний туршлагад тохируулж асуултаа асууж эсвэл асуултуудаа өөрчлөөрэй. Магадгүй, цахим орчин, нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцдог залуучуудын дунд ихэд тархаж буй цахим дээрэлхэлтийн талаар хэлэлцэх шаардлага гарч болно (Модуль 5 "Асуудлыг шийдвэрлэх болон нийгмийн ур чадварууд", Дасгал 5.4.3 "Цахим орчин, нийгмийн сүлжээний зохистой хэрэглээ"-г харах).

1-р түүх: Заримдаа эрчүүд, хөвгүүдийн гаргаж байгаа бэлгийн сэдэл бүхий зохисгүй үйлдлүүдийг нуун хаацайлж, охид эмэгтэйчүүдийг эмзэглэх хэрэггүй хэмээн үздэг гэдгийг тайлбарлаж удиртгал хэсгийг дуусгана. Мөн эрчүүд, хөвгүүд төрөлхөөсөө бэлгийн дур хүсэл ихтэй тул эмэгтэйчүүдийн биеэ авч явах байдал, хувцаслалт зэргээс шалтгаалж амархан өдөөгддөг хэмээн хаацайлах ташаа ойлголт, үзэгдэл их гардаг. Энэ бүхэн буруу ойлголт, буруу хандлага юм. Учир нь бодит баримтад суурилаагүй байдаг. Бодит үнэн гэвэл:

- Хэсэгхэн эрчүүд л дарамт хүчирхийлэл үйлддэг, бүгд биш. Өөрийн бэлгийн дур хүслийнхээ хохирогч болж байгаа гэдэг нь бусад хүмүүст хийж байгаа муу зүйлээ хаацайлах гэсэн өрөвдөм, ичгүүртэй шалтаг юм. Харин өөрийн дур хүслээ хазаарлаж, охид эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандаж чаддаг хөвгүүд/эрэгтэйчүүд бусдын дунд илүү нэр хүндтэй байдаг.
- Охид эмэгтэйчүүд задгай, секси биш хувцасласан байсан ч бэлгийн хүчирхийллийн хохирогч болдог.
- Бусдаас "өөр" харагддаг хөвгүүд, эрэгтэйчүүд ч мөн бэлгийн хүчирхийлэл дарамтын хохирогч болдог тохиолдол бий.
- Бэлгийн дарамт бол бэлгийн таашаал авч байгаа бус, харин хүч чадлаа буруугаар ашиглаж байгаа хэрэг юм.

Алхам 2. Дарамт болон дээрэлхэлт – 20 минут

Оролцогчдоос Туяа, Болд хоёрынх шиг нөхцөлд орж байсан эсэх эсвэл ийм нөхцөл харж ажигласан эсэхийг асууна. Тэдний дурдсан санааг самбар/самбарын цаасан дээр жагсааж бичнэ.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Сургагч багш оролцогчдыг жижиг багуудад хувааж, бэлгийн дарамт, дээрэлхэлтийн тухай жишээнүүдийг гарган ирж, бусдадаа танилцуулахыг хүсэж болно. Багуудын дундуур явж (жишээ давтагдахаас сэргийлж), ямар жишээ гаргаж болохыг зөвлөж болно. Сургагч багш мөн ямар хүмүүс энэ бүхэнд илүү өртдөгийг тайлбарлаж болох ба бусдаас "өөр" харагддаг, тэр дундаа хэт намхан, хэт туранхай, хэт тарган, хэт өндөр, бэлгийн цөөнх, трансжендэр, гадаадын иргэн эсвэл үндэстний цөөнхөд хамаардаг, өөр аялгаар ярьдаг хүмүүс байж болохыг дурдаж болно.

Дараах асуултуудаар хэлэлцүүлгийг хөтөлж болно:

- Бэлгийн дарамт, дээрэлхэлтэд өртөж байсан хүн байна уу? Хэрэв тийм бол яг юу тохиолдсон, хариуд нь ямар арга хэмжээ авснаа хуваалцаж болох уу?
- Ямар нөхцөл байдалд эсвэл ямар газар бэлгийн дарамт, дээрэлхэлт их тохиолддог вэ?
- Үүнд хамгийн их өртдөг хохирогчид ямар хүмүүс байдаг вэ? Яагаад?
- Хүүхэд бас бэлгийн дарамтад өртдөг үү?, Насанд хүрэгчид дээрэлхэлтэд өртдөг үү?
- Хэрэв тийм бол эрэгтэйчүүд/хөвгүүд, эмэгтэйчүүд/охид адилхан өртдөг үү? Гол төлөв ямар нөхцөлд?
- Эрэгтэй хүн/хүүхэд бэлгийн дарамтад өртдөг үү? Эмэгтэй хүн дээрэлхэгч байж болох уу?
- Монгол дахь дарамт, дээрэлхэлтийн нөхцөл байдал ямар байна вэ? (Нэмэлт мэдээллээс зарим санааг хуваалцаж, оролцогчдоос сургууль, ажил, орон нутгийнх нь нөхцөл байдлын талаар асуугаарай)
- Яагаад зарим хүмүүс бусдыг дарамталж, дээрэлхдэг гэж бодож байна вэ?

Дараах ойлголтыг тайлбарлаж өгөөрэй:

- **Дарамт** нь олон хэлбэрээр илэрч болно, тухайлбал:
 - о Бие махбодын – хүсээгүй байхад биед хүрэх
 - о Үг хэлээр – гоочилж, дайрч, доромжилсон үг хэрэглэн харьцах, шоглох, тохуурхах
 - о Үгэн бус – ширтэх, хялайх, шүгэлдэх, айлгах, бэлгийн сэдэл бүхий дохио үзүүлэх, цочоох г.м.
- **Бэлгийн дарамт** гэдэг нь аль нэг тал нь хүсээгүй байхад үзүүлж байгаа бэлгийн сэдэл бүхий үйлдэл юм. Дарамтын өөр нэг хэлбэр нь дээрэлхэлт бөгөөд олон давтамжтай, байнга тохиолддог, нэг ба нэг хэсэг хүмүүс, тэдний ажил гүйцэтгэлд чиглэсэн сөрөг халдлага юм.
- **Дарамт болон дээрэлхэлт** нь сургууль, ажлын байр, олон нийтийн газар, тэрбайтугай орон гэрт ч тохиолдож болно. Үүнд ялангуяа охид, эмэгтэйчүүд, бусдаас “өөр” харагддаг хүмүүс, өөр аялгаар ярьдаг, үндэсний цөөнх, нийгмийн байдлаараа ялгаатай, бэлгийн өөр чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүс илүү өртдөг. Эрэгтэйчүүд болон хөвгүүд бусад эрчүүдийн зүгээс бэлгийн дарамтад өртөх нь ч бий.
- Дарамт, хүчирхийлэл үйлдэж явдаг хүмүүс хохирогчдод хайртай дуртайдаа бус, харин ч өөрсдийгөө тэднээс илүү эрх мэдэлтэй, хүч чадалтай хэмээн итгэж, үүнийгээ илэрхийлэх гэж ялгаварлан харьцдаг байна.
- Бэлгийн дарамт нь сээтэгнэл ч биш, дотно харилцаа ч биш, бэлгийн таашаал ч биш, харин **хүч чадал, эрх мэдлээ буруугаар ашиглаж байгаа хэрэг** юм. Дарамт болон дээрэлхэлтийн бусад хэлбэр ч хүч чадал, эрх мэдлээ буруугаар ашиглаж байгаа хэрэг юм.

Алхам 3. Дарамт болон дээрэлхэлтийн үр дагавар – 20 минут

Дараах асуултуудын дагуу бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн үр дагавар, үүнтэй хэрхэн тэмцэх тухай хэлэлцүүлэг өрнүүлээрэй:

- Бэлгийн дарамт, дээрэлхэлтэд өртсөн хохирогчид ямар мэдрэмж төрдөг гэж бодож байна?
- Хэрэв чамд таалагдахгүй зүйлийг хэн нэгэн чамд зориуд хийгээд байвал чи яах вэ?

- Хэрэв чиний хошигнол хэн нэгэнд таалагдахгүй байгааг мэдсэн тохиолдолд түүнийгээ үргэлжлүүлэх үү? Тэр хүнийг үргэлжлүүлэн даажигнасаар байх уу? Яагаад?
- Дарамт, дээрэлхэлтийн эсрэг хамгийн зохистой хариу үйлдэл нь юу вэ?
- Өөрөө дарамт, дээрэлхэлтийн хохирогч болбол юу хийж болох вэ?
- Хэн нэгэн дарамт, дээрэлхэлтийн хохирогч болж байгааг харвал юу хийж болох вэ?
- Өөрсдөө ийм нөхцөл байдалд орж байсан оролцогчдоос юу мэдэрч байсныг нь асуухын зэрэгцээ өөр хохирогчдын жишээг авч, ийм тохиолдолд яг ямар арга хэмжээ авах хэрэгтэй талаар тайлбарлаж өгнө (Нэмэлт мэдээлэл: “Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийг хэрхэн даван туулах вэ”: мэдээлэл, зааварчилгаа уншаарай)
- Дарамт, дээрэлхэлтийн эсрэг ямар арга хэмжээ авах, түүний хохирогчдод хэрхэн туслах талаар онцгойлон зааварчилгаа өгөөрэй.

Алхам 4. Дүгнэлт – 5 минут

Дараах санааг онцолж хэлэлцүүлгээ төгсгөөрэй:

- Бэлгийн дарамт бол сээтэгнэл биш. Энэ бол эрх мэдэл, хүч чадлаа буруугаар ашиглаж байгаа явдал бөгөөд хүсэшгүй, хүлээн зөвшөөршгүй үйлдэл юм.
- Бэлгийн дарамт хаана ч хэнд ч тохиолдож болно. Тодруулбал сургууль, ажил, олон нийтийн газар, гэр бүл, хувийн орон зайд ч тохиолддог.
- Бэлгийн дарамтын хохирогчдын ихэнх нь охид эмэгтэйчүүд байдаг ч хөвгүүд, эрэгтэйчүүд ч мөн хохирогч болох тохиолдол бий. Ихэнх тохиолдолд хүүхдүүд, залуучууд эсвэл бусдаас арай “өөр” хэмээн тооцогддог, хамгаалалтгүй, ажил, гэр бүл, сургуульд эсвэл гудамжинд эмзэг нөхцөлд байдаг хүмүүс өртдөг.
- Тань руу хэн нэгэн халдсан тохиолдолд өөрт чинь таалагдахгүй байгааг зоригтой илэрхийлж, шаардлагатай бол тусламж дуудахаас бүү ай.
- Бусдыг бүү дарамтал, бүү дээрэлх. “Үгүй” л гэсэн бол “үгүй” гэсэн үг болохыг ойлго. Бусдыг эвгүй байдалд оруулж, хүндлэхгүй байх нь эрүүл үзэгдэл яав ч биш. Харин ч хүний эрхийн зөрчилд тооцогдоно.
- Дарамт, дээрэлхэлт нь хохирогчийн аж амьдрал болон ажил хөдөлмөрт нь ноцтой сөрөг үр дагавартай.
- Дарамт, дээрэлхэлтийн хохирогчдод туслах талаар боломжтой бүхнийг хийх хэрэгтэй.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.1 А: Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн түүхүүд

Зааварчилгаа: Алхам 1-т дараах хоёр түүхийн нэгийг сонгож хэрэглэнэ. Зорилтот бүлэг нь ажил эрхлэх насныхан байвал 1-р түүхийг, хүүхэд, залуучууд байвал 2-р түүхийг сонгоно.

Түүх 1: Ажлын байран дахь бэлгийн дарамт

Туяа үйлдвэрт ажилладаг, 18 настай бүсгүй. Тэрээр ажилдаа ч дур сонирхолтой, хамт олонтойгоо ч нийцтэй. Долоо хоногийн 6 өдөр нь ажилладаг тэрээр хичээж ажилласныхаа дүнд гэр рүүгээ хангалттай мөнгө явуулдагтаа сэтгэл хангалуун байдаг байв. Хэд хоногийн өмнө тэдний үйлдвэрт шинэ дарга ирснээр түүний амьдрал өөрчлөгдөв. Ажлыг нь шалгах нэрээр биед нь байнга хүрэх нь бүсгүйд таалагдахгүй байв. Анх удаа хүрэхэд нь санаандгүй хүрлээ гэж бодож байтал энэ байдал олон давтагдах болсноор үүнийг санаатай үйлдэл гэдэгт бүсгүй баттай итгэх болжээ. Тэрээр уурлаж, болихыг шаардсан ч ажлыг нь элдвээр өөлж гоочлох болов. Улмаар цалинг нь хасна хэмээн сүрдүүлж эхэллээ. Энэ мэтээр шинэ дарга улам даврах болсон тул бүсгүй ажилгүй болохоос эмээн, дуугүй байхыг хичээх болжээ. Одоо Туяа ажилдаа явах дургүй болсон ч мөнгө хэрэгтэй тул тэсэх хэрэгтэй. Гэхдээ тэр яасан нь дээр вэ?

Түүх 2: Сургуулийн орчин дахь дээрэлхэлт

Болд, 13 настай, нэгэн дүүргийн ерөнхий боловсролын сургуульд шинээр шилжин ирж суралцаж байгаа. Түүнд шинэ сургууль нь таалагдаж, шинэ найзуудтай болсон. Тэр ангийнхантайгаа хамт гадаа сагс тоглодог болсон. Нэг өдөр сагс тогложихоод гэртээ харих гээд явж байтал дээд ангийн ах нар ирж мөнгө нэхэн, тамхинд яваад ир гэж хэлжээ. Болд үүнд нь дургүйлхэж, шударга бус санагдаж байлаа. Гэхдээ дээд ангийнхан нь түүнээс том биетэй, хэрэв түүнийг эсэргүүцэх юм бол дээд ангийнхнаа хүндлээгүй гэж зодно гэж сүрдүүлжээ. Болд зодуулахыг хүсэхгүй байсан учраас хэлснээр нь хийсэн. Болд шинэ найзууддаа дээд ангийнхны тухай хэлэхэд тэднээс аль болох хол байхыг сануулжээ. Болд аль болох хол байхыг хичээсэн ч дахиад л тааралдлаа. Өөрт нь мөнгө байхгүй гэж Болд хэлэхийг хичээсэн боловч тэд Болдын үгийг сонсолгүй, түүнийг зодлоо. Шинэ сургуульдаа асуудалгүй байхыг хүсвэл тэдний хэлснийг хийж байхыг тэд Болдод сануулсан. Болдод одоо шинэ сургууль нь хөгжилтэй биш болсон, мөн дээд ангийн дээрэлхэгч нар түүний мөнгийг авах гэж байнга ирдэг болсон учраас тэр сургуульдаа явах дургүй болсон. Болд одоо юу хийж болох вэ?



Нэмэлт мэдээлэл: Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийг хэрхэн даван туулах вэ?

Бэлгийн дарамт гэдэг нь хүсээгүй байхад нь, хүлээн зөвшөөрч боломгүй байдлаар бэлгийн сэдэлтэй үйлдлүүд болох үгээр (гоочилж, дайрч, доромжилсон үг хэрэглэн харьцах, шоглох дооглох г.м.), үгэн бус хэлбэрээр (ширтэх, хялайх, шүгэлдэх, айлгах, бэлгийн сэдэл бүхий дохио үзүүлэх, цочоох), үйлдлээр (хүсээгүй байхад биед хүрэх) дарамтлах явдал юм.

Дээрэлхэлт гэдэг нь ямар нэгэн бодит эсвэл хийсвэр байдлаар хүчний тэнцвэргүй байдал үүсгэж, тухайн хохирогчид өөрийгөө хамгаалах боломжгүй, дорой гэдэг мэдрэмж үүсгэх байдлаар байнгын давтамжтайгаар дайрч доромжлох үйлдэл юм. Иймэрхүү хүсэмгүй үйлдлүүд нь хохирогчийг дарамтлах зорилготой байдаг ба үүнд: цохих, өшиглөх, хувийн өмчийг нь эвдэх, устгах зэрэг биет үйлдлүүд, шоолох, доромжлох, сүрдүүлэх зэрэг үгэн халдлагууд, хов тараах, гадуурхах зэрэг харилцааны үйлдлүүд багтдаг. Дээрэлхэлт нь гол төлөв гэнэгүй байхад нь эхэлдэг. Ажлын байран дээр хувь хүн рүү халдлага хийх, хувь хүн эсвэл хэсэг бүлэг хүний ажил бүтээмжийг нь гоочлох зэргээр илэрдэг. Сургууль болон цахим орчинд үе тэнгийнхний дарамт хэлбэрээр илрэх нь түгээмэл байдаг.

Цахим орчин дахь дээрэлхэлт нь хэн нэгнийг айлган, дарамтлах агуулга бүхий янз бүрийн зураг бичлэг, зурвас илгээх, мөн хувь хүний амьдралын толь болсон цахим хуудсанд нь янз бүрийн мэдээлэл тараах хэлбэрээр илэрдэг.

Бэлгийн дарамт болон дээрэлхэлт нь сургууль, ажил, олон нийтийн газар, гэр бүл, хувийн орон зай зэргээр хаана ч тохиолдож болдог. Ажилтай холбоотой тохиолдолд ажил олгогч, хамт ажиллагч, дарга, үйлчлүүлэгч эсвэл ажлын шугамаар харилцаж байгаа хэнээс ч ийм үйлдэл гарч болно. Харин сургуулийн орчинд үе тэнгийнхэн болон эрх мэдэл бүхий багш, албан тушаалтнуудын зүгээс үйлдэгдэх нь бий.

Монгол дахь нөхцөл байдал

- Ажлын байран дахь бэлгийн дарамт Монголд нэлээд дэлгэрсэн байдаг ч үүний эсрэг тодорхой хууль эрх зүйн заалт байхгүй. Хүний эрхийн үндэсний комиссын 2017 оны судалгаагаар түүнд хамрагдагчдын 2/3 буюу 63% нь удирдах ажилтнуудынхаа зүгээс бэлгийн дарамтад өртөж байснаа илэрхийлсэн байна. Хүний эрхийн комиссын мэдээлснээр яг энэ асуудалд хандсан системчилсэн хандлага үгүйлэгдсээр байгаа аж.
- Хүүхдийг Ивээх Сангийн 2017 оны судалгаагаар Монголд 10 хүүхэд тутмын 4 нь (38%) дарамт, дээрэлхэлтийн ямар нэгэн хэлбэрт өртсөн байдаг ба 41% нь өөр хүүхэд хүчирхийлэлд өртөж байхыг харж байсан гэж гарсан байна. Тэдний ихэнх нь буюу 10 хүүхэд тутмын 8 (84%) нь яг хэнд хандаж тусламж хүсэхээ мэдэхгүй байснаас гадна 10 хүүхэд тутмын 6 (62%) нь удаан хугацаанд (долоо хоногоос дээш хугацаагаар) сэтгэлээр унаж байсан гэж хариулсан байна.
- Охид эмэгтэйчүүдийн хувьд хөвгүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад ойр орчиндоо аюулгүй байдлаа мэдрэх тал дээр харьцангуй доогуур үзүүлэлттэй байна. 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар өсвөр насны буюу 15-19 насны хөвгүүдийн 15%, охидын 17% нь сүүлийн 12 сарын хугацаанд ялгаварлан гадуурхалт амссан гэжээ. Мөн өсвөр насны охидын 46%, хөвгүүдийн 87% нь өөрийн амьдардаг дүүрэгт харанхуйд ганцаар явахаас айдаггүй гэжээ. 15-49 насны эрэгтэйчүүдтэй харьцуулахад хот хөдөө амьдардгаас үл хамаараад, эмэгтэйчүүд

¹ Эх сурвалж: *Action against Sexual Harassment at Work in Asia and the Pacific* by Haspels et al (ILO: Bangkok, 2001), pp.17 & 147; UN Special Representative of the Secretary-General on Violence Against Children, *Bullying and Cyberbullying*, <https://violenceagainstchildren.un.org/content/bullying-and-cyberbullying-0>; *Chanel News Asia*, "Mongolian women fight for law against widespread sexual harassment," 25 November 2019, <https://www.channelnewsasia.com/news/asia/mongolia-women-fight-for-law-against-sexual-harassment-me-too-12123736>; Save the Children, "Young Voices" *Survey Report Mongolia*, 2017; National Statistical Office, *Mongolia: Social Indicator Sample Survey 2018*.

харанхуй болсон хойно гадуур ганцаараа явахаас эмээдэг гэсэн байна. Тодруулбал, хотод амьдардаг эмэгтэйчүүдийн 50%, хөдөө амьдардаг эмэгтэйчүүдийн 66% нь гадуур явахдаа аюулгүй байдлыг мэдэрдэг гэсэн бол эрчүүдийн хувьд 79% болон 93% гэсэн үзүүлэлт байна

Бэлгийн дарамт болон дээрэлхэлтийн үр дагавар

- Ичиж зовох, гутрах, өөрийгөө дорд үзэх, жигших зэрэг сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүд
- Өс авахаас айх
- Хувийн амьдралд нь сөргөөр нөлөөлөх: гэр бүл болон найз нөхдийн хүрээнд харилцааны бэрхшээл үүсэх, эрүүл мэндийн асуудал үүсэх
- Ажлын орчинд: бүтээмж буурах, ажилтны идэвх муудах, ажил таслах, өвчний чөлөө авах, ажилд хандах хандлага өөрчлөгдөх
- Сургуулийн орчинд: харилцааны бэрхшээл үүсэх, хичээл таслах, сурлагадаа муудах

Бэлгийн дарамт эсвэл дээрэлхэлтэд өртвөл яах вэ:

- “Үгүй” гэж зоригтойгоор хэл. Өөрт таалагдахгүй байгаагаа илэрхийлж бай. Хэрэв “Үгүй” гэж хэлэхгүй бол асуудал улам дордох болно.
- Өөрийгөө буруутгаж, зөвхөн надад хамаатай, надаас болсон зүйл гэж бодож болохгүй.
- Найз нөхөд, гэр бүлийнхэн, багш нар, сэтгэл зүйч зэрэг итгэлтэй хүмүүсээс зөвлөгөө ав
- Өөр шиг чинь ийм байдалд орж байсан өөр хүн байгаа эсэхийг олж мэд
- Бичгээр гомдол гарга
- Хуулийн дагуу арга хэмжээ авах
- Сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэх эсвэл итгэлтэй насанд хүрсэн хүнд (эцэг, эх эсвэл багш) хандах

Ажлын байранд бэлгийн дарамт/дээрэлхэлтийн гэрч болсон бол юу хийх вэ:

- Энэ нь ажилтнууд төдийгүй ажил олгогчид, байгууллага, нийгэмд сөрөг нөлөө үзүүлдэг хүний эрхийн зөрчил гэдгийг санах
- Асуудлыг үл ойшоож болохгүй, бусад ажилтан болон удирдлагадаа мэдэгдэж, тэдэнтэй нэгдэж, арга хэмжээ авах хэрэгтэй.
- Мөрдөн шалгах ажиллагаанд боломжоороо тусалж, шударга ёс тогтоож, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтнийг шийтгэхэд нэмэр болох хэрэгтэй.
- Хохирогчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүл.
- Байгууллагаасаа энэ асуудлыг ноцтой авч үзэн, бодлого журамдаа тусгах талаар арга хэмжээ авахыг шаардана.

Асуудлыг үе тэнгийнхэн, багш, хамтран ажиллагч нартайгаа ярилцах нь маш чухал. Мэдрэмжээ хуваалцах нь сэтгэлээ онгойлгоход тустай. Сонсож байгаа хүн ч асуудлыг ноцтой болохыг ойлгон, хүлээн зөвшөөрөх нь чухал. Дарамт, дээрэлхэлт үйлдэж байгаа хүн ч өөрийн үйлдлээ буруу, байж боломгүй зүйл гэдгийг ухаарч, тухайн үйлдлээ зогсоохгүй бол арга хэмжээ авахуулах болно гэдгийг мэдэх нь чухал. Өөрийнх нь үйлдлийг бүх хүн мэдэж байгаа, өөрийнх нь үйлдлийг хэн ч хүлээн зөвшөөрөхгүй, эсэргүүцэх болно гэдгийг гэмт этгээд мэдсэн тохиолдолд бэлгийн дарамт эсвэл дээрэлхэлт зогсох болно.

Дасгал 8.1.2 Гэр бүлийн хүчирхийлэл



Зорилго

- "Гэр бүлийн хүчирхийлэл" ойлголттой танилцаж, гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг мэдэж авах
- Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, үүссэн асуудал бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох
- Гэр бүлийн гишүүдээ гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нь хүн бүрийн үүрэг хариуцлага болохыг ойлгох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

90 -120 минут



Суудал зохион байгуулалт

Тойрог эсвэл хагас тойргоор сууна



Ашиглах материал

- Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.2 А-г хувилах
- Самбарын цаас, самбарын үзэг, скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

8.1.2 А: Гэр бүлийн хүчирхийллийн түүхүүд

Нэмэлт мэдээлэл: Гэр бүлийн хүчирхийлэл



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Танилцуулга: Гэр бүл дэх зөрчил ба хүчирхийлэл – 15-20 минут
2. Жирийн маргаан болон гэр бүлийн хүчирхийлэл – 15-20 минут
3. Багийн ажил – 30-50 минут

4. Гэр бүлийн хүчирхийллийн ноцтой үр дагавар – 5 минут
5. Хэрхэн тусламж авах вэ – 20 минут
6. Дүгнэлт – 5 минут



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Энэ дасгал нь зөвхөн гэр бүл дэх бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийллийн тухай бөгөөд гэр бүл дэх бэлгийн хүчирхийллийн тухай Дасгал 8.1.4.-д үзэх болно гэдгийг анхаараарай.

Бэлтгэл

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх тодорхойлолт болон Монгол дахь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдалтай танилцах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэл” нэмэлт мэдээллийг уншиж танилцаарай. Гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэгт тооцогддог. Эхлээд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг заавал цуглуулаарай. Үүний тулд хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар ажилладаг ТББ эсвэл энэ асуудлаар хуулийн зөвлөгөө өгдөг төвүүдэд хандах нь хамгийн сайн арга юм.

Дасгалаа анхааралтай уншаад, Алхам 1-н удирдамж асуултууд ба Алхам 3-н түүхүүдээс сонгоно. Оролцогчдын хэрэгцээнд тохируулан өөрчлөлт оруулж болно.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Гэр бүлээсээ хол байгаа залуу шилжин суурьшигчид хамаатан садныдаа эсвэл хамт ажилладаг/хамт сурдаг үеийнхэнтэйгээ дотуур байранд “шинэ гэр бүл”-д амьдардаг бөгөөд хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг. Хоёр түүх нь ийм нөхцөл байдалд байгаа залуу шилжин суурьшигчдад зориулсан болно. Сургалтад оролцогчид нь залуу шилжин суурьшигчид байгаа бол нэг түүхийг нь сонгоорой.

Алхам 1. Танилцуулга: Гэр бүл дэх зөрчил ба хүчирхийлэл – 15-20 минут

Энэхүү дасгал нь гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл үйлдэгдэхээс сэргийлэх, хүчирхийлэлтэй хэрхэн тэмцэх тухай танилцуулах болно. Эхлээд дараах асуултуудыг тавьж, ярилцлага өрнүүлнэ:

- Хүүхдүүдийн хооронд гардаг хамгийн түгээмэл зөрчил юу вэ? Тэд зодолдоод эхэлбэл юу болох вэ?
- Өсвөр насныхан яагаад муудалцдаг вэ? Тэд уурласан үедээ ямар авир гаргадаг вэ?
- Эцэг эхчүүд хүүхдэдээ уурлахаараа яадаг вэ?
- Эцэг эхчүүд нэг нэгэндээ уурлахаараа яадаг вэ?
- Гэр бүлд байнга хэрүүл зодоон гардаг бол юу болох бол?

Оролцогчдын иш татсан жишээг ашиглаж гэр бүл бүрд үе үе маргаан зөрчилдөөн гардаг болохыг тайлбарлана. Гэр бүлийн гишүүдийн сонирхол, үзэл бодол нь өөр өөр байдгаас үл ойлголцол үүсдэг. Ялангуяа хүүхдүүдийн хооронд иймэрхүү зүйлс олонтаа гардаг. Хамгийн гоёыг нь өөртөө авах гэж хүүхэд бүр хүсдэг тул тэд хоорондоо маргалддаг. Хүүхдүүд бусадтай хуваалцаж сурах нь чухал юм. Ядуу гэр бүлд иймэрхүү зөрчил илүү давтамжтай гардаг нь хүн бүрийн хэрэгцээг хангахуйц хангалттай хүнс хоол, бусад зүйлс байдаггүйтэй холбоотой.

Хэрэв хүмүүс сэтгэл дундуур байгаа асуудлын талаар ярилцаж чадахгүй бол хэрэлдэж, маргалдаж эхэлдэг. Хэрэв ийм зүйл байнга биш, цөөн тохиолддог бол энэ нь тийм ч хортой үзэгдэл биш. Өөрийн санал бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлж хуваалцах нь нөхцөл байдлыг сайжруулж, харилцааг сэргээж болно. Хайр халамж дүүрэн гэр бүлд бие биеэ уучлах, энгийн эерэг харилцаагаа сэргээхэд хялбар байдаг. Гэвч иймэрхүү үл ойлголцол, таагүй байдал даамжирч, хүмүүс бие биедээ үгээр болон үйлдлээр хүч хэрэглэж эхэлбэл тухайн гэр бүлд ноцтой асуудал тулгарчээ гэсэн үг.

Алхам 2. Жирийн маргаан болон гэр бүлийн хүчирхийлэл – 15-20 минут

Гэр бүлийн жирийн маргаан болон байнгын үгээр хэмлэх, биеэр дарамтлахын хооронд ялгаа (дэлгэрэнгүйг Нэмэлт мэдээлэл: Гэр бүлийн хүчирхийлэл) байдаг тухай, хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар нарийн тайлбарыг хийнэ. Самбарын хоёр цаасан дээр: "Хүчирхийллийн ноцтой хэлбэрүүд", "Хүчирхийллийн ноцтой бус хэлбэрүүд" хэмээн гарчиг тавьж, ханан дээр наагаад дараах асуултуудыг асууна:

- Хүчирхийллийн ямар хэлбэрүүд санаанд чинь орж байна вэ?
- "Хүчирхийллийн ноцтой хэлбэрүүд" гэж юу байж болох вэ?
- "Хүчирхийллийн ноцтой бус хэлбэрүүд" гэж юу байж болох вэ?

Хариултуудыг самбар дээр жагсаан бичиж, товч ярилцана. Эрчүүд/хөвгүүдийн болон охид/эмэгтэйчүүдийн түрэмгий авир ялгаатай эсэхийг асууж, самбарт тэмдэглэнэ. Ихэнх оролцогчид эрчүүд/хөвгүүд бие махбодын хүчирхийлэл илүүтэй үйлддэг гэж хариулах байх. Харин охид, эмэгтэйчүүд биеийн хүчирхийллээс айдаг тул илүү нууцлагдмал хүчирхийлэл үйлддэг байх талтай. Гэхдээ эмэгтэйчүүд ч бас хүүхдэдээ бие махбодын хүчирхийлэл үзүүлдэг, охид хөвгүүд адилхан л дүү нараа зодож дээрэлхэх явдал байдгийг тайлбарлаарай. Харамсалтай нь ихэнх нийгэмд хөвгүүдийг дотоод сэтгэлээ нээн ярилцахаас илүүтэй илүү түрэмгий байж, бусдад халдан дээрэлхэхийг буруушаахгүй, харин ч өөгшүүлдэг байх нь элбэг. Эр хүн бие махбодын хувьд илүү хүчирхэг тул сул дорой хүүхэд эмэгтэйчүүд бие махбодын хүчирхийллийн хохирогч болох нь түгээмэл байдаг.

Алхам 3. Багийн ажил – 30- 50 минут

Оролцогчдыг 4- 5 багт (сонгож авсан түүхийн тооноос шалтгаалж) хувааж, тус бүр нэг түүх (Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.2 А) оноож өгөөд, түүхийг уншиж, хоорондоо ярилцахад нь зориулж 10-15 минут өгнө. Дараа нь баг бүрээс өөрсдийн түүхийг товч танилцуулж, хэн хэнийг ямар учраас ямар байдлаар хүчирхийлсэн тухай ярихыг хүснэ.

Мөн дараах асуултуудаар түүхийг улам дэлгэрүүлж ярилцана:

- Жагсаалтад дурдагдсан (Алхам 2-т) хүчирхийллийн хэлбэрүүд бүгд түүхүүд дээр гарсан уу?
- Түүхүүдэд дурдагдсан хүчирхийллийн хэлбэрийг ноцтой хэлбэрээс ноцтой бус руу нь эсвэл эсрэгээр нь өөрчлөхийг хүсэж байна уу?
- Ийм нөхцөл байдал чамд тохиолдвол чи яах байсан бэ?
- Хэрэв чи өөрөө догшин ширүүн авирлаж, бусдыг гэмтээсэн бол ямар санагдах бол?
- Ийм нөхцөлд орсон хүүхдэд /найздаа/ хамаатандаа яаж тусалж чадах вэ?

Алхам 4. Гэр бүлийн хүчирхийллийн ноцтой үр дагавар – 5 минут

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн нууцлагдмал байдаг нийгмийн маш ноцтой сөрөг үзэгдэл болохыг тайлбарлаарай. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг гэр бүлийн гишүүд ихэд ичиж бүгж, хохирогчид нь өөрсдийн нөхцөл байдлаа, гэмтэл бэртлээ бусдаас нуухыг оролддог. Зарим нэг хүчирхийлэгчид өөрсдийгөө гэр бүлийн гишүүддээ хүч хэрэглэх эрхтэй гэж итгэсэн, мөн гэр бүлийн гишүүд, хохирогчид ч үүнийг хүлээн зөвшөөрсөн байх нь ч бий. Олон тохиолдолд хүчирхийлэгч нь хэсэг хугацаанд хийсэн үйлдэлдээ гэмшдэг ч дахин дахин хүчирхийлэл үйлдсээр байдаг.

Монгол улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийн тодорхойлолтыг анх удаа 2004 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд² тусгасан ба улмаар шинэчилсэн найруулгад (ГБХТТХ, 2016) олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэр, үйлдэл зэргийг тодорхойлолтодоо тусгасан юм.

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн (ГБХТТХ) 2 дугаар зүйлийн хуулийн нэр томьёоны тодорхойлолтод “гэр бүлийн хүчирхийлэл гэж гэр бүлийн хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ” гэж тодорхойлсон. Гэр бүлийн хүчирхийлэл нь Монголын нийгэм дэх эмзэг асуудлуудын нэг бөгөөд олон хүний хувьд, ялангуяа эмэгтэйчүүд болон эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувьд эмзэг асуудал болдог. Эмэгтэйчүүд, хүүхдүүд, настай хүмүүс гэр бүлийн хүчирхийллийн янз бүрийн хэлбэрт өртдөг. Энэхүү асуудлыг илүү хувийн шинжтэй хэмээн үзэж хүмүүс нээлттэйгээр ярилцах дургүй хэвээр байна. Гэвч чимээгүй өнгөрөх нь яагаад ч сайн арга биш бөгөөд иймэрхүү догшин авирыг хүлцэн, юу ч хийхгүй байх нь хүчирхийллийг улам даамжруулах нэг зам болдог. Үүнээс шалтгаалан гэр бүлд гарах сөрөг үр дагавар нь хэмжээлшгүй их билээ. Гэр бүлийн гишүүд бие биедээ итгэхээ байж, үргэлж айдас түгшүүр дунд байснаас болж хүүхдүүд нь хичээл сурлагадаа муудахаас гадна бусдаас хүртэл айж түгших болно. Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд өөрсдөө том болоод хүчирхийлэгч болох магадлал нэмэгддэг.

Алхам 5. Хэрхэн тусламж авах вэ – 20 минут

Гэр бүлийн хүчирхийллийн үед хаана хандах талаар оролцогчдод мэдээлэл өгөөрэй. Хүчирхийллийн ноцтой хэлбэрүүд, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэгт тооцогддог тул олон оронд, түүний дотор Монгол улсад ч гэр бүлийн хүчирхийллийг хуулиар хориглосон байдаг.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Залуучууд, насанд хүрэгчидтэй энэ дасгалыг ажиллах үедээ 2016 онд батлагдсан Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу гэр бүл дэх хүчирхийлэлд ямар арга хэмжээ шийтгэл оногдуулдаг талаар ярилцана. Уг хууль нь гэр бүлийн дотор бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг хориглосон заалтыг агуулсан байдаг. Үүнээс гадна тус улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн заалтаар гэр бүлийн хүчирхийлэгчийн эсрэг аргагүй хамгаалалт хэрэглэх тохиолдолд хэрхэн шийтгэхийг ч тусган оруулсан байна. Мөн эцэг эх, асран хамгаалагчийн буруутай үйлдлээс болж хүүхдийн эрх зөрчигдөх үед хэрхэн шийтгэхийг ч тусгасан байна (Нэмэлт мэдээлэл хэсгийг харна уу).

² 2016 оны 12 сарын 22-ны өдөр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай” Төрийн мэдээлэл эмхтгэл No 5, (2017)

Хэрэв гэр бүлийн хүчирхийлэлтэй тулгарсан гэр бүлийн гишүүд хүчирхийлэгчтэй ярилцаад ойлголцохгүй, асуудал шийдэгдэхгүй, харин ч улам аюултай нөхцөлд орвол өөр хэн нэгний тусламж авах нь зайлшгүй чухал болохыг тайлбарлаарай. Бэртэж гэмтсэн бол эмнэлэгт очиж, эмчид заавал үзүүлэх хэрэгтэй. Мөн өөрийн итгэлтэй хүнд уг хүчирхийллийн тухай хэлж, холбогдох байгууллага, цагдаад мэдэгдэх шаардлагатай. Иймэрхүү арга хэмжээ авахад хэцүү мэт санагдах ч зүгээр орхивол хүчирхийлэл улам даамжрах болно. Олон хүний хувьд гэр бүлийн хүчирхийллийн тухай бусдад дэлгэх дургүй, ичиж нэрэлхэх боловч хүчирхийллийг зогсоох ганц л арга байдгийг ухамсарлах хэрэгтэй. Ингэхдээ хамгийн гол нь нотлох баримтаа цуглуулж, өөрсдийнх нь гомдлыг баталгаажуулах найдвартай гэрчтэй байх нь чухал. Эрхийг нь зөрчсөн этгээдийг шүүхээр шийтгүүлэх нь хамгаас чухал. Хэрэв гэр бүлийн хүчирхийллийн хохирогч зохих хууль тогтоомжийн талаар мэдлэггүй бол ийм бэрхшээлтэй хүмүүст туслахад бэлэн, тэдний эрхийг хамгаалж, зөвлөгөө өгдөг ТББ-уудад хандах хэрэгтэй. Цагдаа болон эмнэлэг рүү явахдаа аль болох ганцаараа бус, итгэл даах хэн нэгэн хүн, хүмүүстэй, ялангуяа хүчирхийллийн гэрч болсон хүнтэй явах нь дээр байдаг. Ингэснээрээ өөртөө итгэлтэй, хүчтэй байх боломж бүрддэг.

Алхам 6. Дүгнэлт – 5 минут

Дараах санааг онцолж дүгнэлт гаргана:

- Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн аз жаргал, баяр баясгаланг үгүй хийж, гэр бүлийн гишүүдийн амьдралдаа амжилт гаргах боломж, өсөн дэвжих замыг нь хааж байдаг.
- Гэр бүлийн жижиг хэрүүл маргаанаас эхэлсэн шийдэгдэж чадаагүй асуудлууд хуримтлагдсаар цаашид улам гүнзгийрч, ноцтой хүчирхийллийн аргаар шийдэхийг оролдох хүртэл даамжирдаг.
- Гэр бүлийн хэн ч байсан бусад гишүүдийг цохих, зодох эрхгүй
- Гэр бүлдээ тохиолдоод байгаа хүчирхийллийн тухай хэн нэгэн итгэлтэй хүнд хэлж, тусламж хүсэх нь зүйтэй.
- Монгол улсын хуулиар гэр бүл дэх хүчирхийллийн олон хэлбэрийг, түүн дотроо бие махбодын сэтгэл санааны, эдийн засгийн болон бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг хориглож, гэмт үйлдэл хэмээн үздэг.
- Эцэг эх, асран хамгаалагч зэрэг хүүхдийг халамжлах үүрэг бүхий хэн ч байсан хүүхдийн эрхийг зөрчсөн, хүчирхийлсний болон үл хайхарсны улмаас үүдсэн хохирлыг хариуцаж, хуулийн дагуу шийтгэл хүлээх ёстой.
- Хүчирхийллийн талаар мэдээлэхдээ өөрийн итгэлтэй хүн, боломжтой бол үүнийг гэрчлэх хүнтэй хамт явах хэрэгтэй.

Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.2 А: Гэр бүлийн хүчирхийллийн түүхүүд

Зааварчилгаа: Алхам 3-т дараах түүхийг хэрэглэнэ. Зорилтот бүлэгтээ тохирсон 2-3 түүхийг сонгож, зорилтот бүлгийн онцлогт тохируулж гол дүрүүдийн нэр, зарим нэг мэдээллийг нь өөрчилж болно.

Хүүхдэд:	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтийн тухай нэг нэг түүх сонгоно.
Залууст:	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт, томчууд хоорондын хүчирхийллийн тухай нэг нэг түүх сонгоно.
Насанд хүрэгчдэд:	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, томчууд хоорондын болон хүүхдүүд хоорондын хүчирхийллийн тухай нэг нэг түүх сонгоно.
Шилжин суурьшигч:	Шилжин суурьшигчдын эсрэг хүчирхийллийн тухай түүх дор хаяж нэгийг сонгоно



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл. 1-р түүх

Бяцхан Төгсөө сургуульд сурахыг хүсдэг

Нэгэн суманд 5 ам бүлтэй айл (эцэг эх 3 хүүхдийн хамт) амьдардаг байв. 8 настай Төгсөө тэр айлын ганц хүү. Тэрээр олон сайн найзтай тул хөдөөгийнхөө амьдралд дуртай байлаа. Түүний эгч нь сургуульд явдаг. Эгчтэйгээ хамт сургуульд явмаар байдаг ч аав нь түүнийг өөр суманд байх авга ахындаа очиж, морь малаа маллахад нь туслах хэрэгтэй гээд сургуульд явуулсангүй. Уг нь тэднийх хүүгээ сургуульд явуулахад хүрэлцэхээр мөнгө олдог ч аав нь мөнгөөрөө архи ууж, мөрийтэй тоглоом тоглодог. Сургуульд явмаар байна гэж Төгсөөг гуйх тоолонд аав нь уурлан түүнийг зоддог байв. Хамгийн сүүлд Төгсөөг сургуульд явах хүслээ хэлснээс болж хэвтэрт ортол нь зодсон бөгөөд өвдсөндөө уйлахад нь эр хүн уйлдаггүй юм хэмээн улам чанга зодсоор байсан юм. Зодуулснаасаа болоод гэр орны ажилд, мөн дүүгээ харахад тус болсонгүй хэмээн ээж нь бас уурлаж байв. Одоо хүү авга ах зодохгүй л бол сургуульд явахгүй байх нь хамаагүй, тэдний морь малын ажилд тусалсан ч яах вэ гэж бодох болов.



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл. 2-р түүх

Ээжээсээ айдаг Дулмаа

Дулмаа бол 12 настай, аав ээж хоёртойгоо амьдардаг, айлын ганц охин билээ. Гэвч тэр аз жаргалгүй байлаа. Тэр сургуульд явах дуртай, багшдаа их хайртай боловч түүнд олон найз нөхөд байсангүй. Учир нь тэр сургуулиа тараад гэртээ яаран ирэх ёстой. Хэдхэн минут оройтож ирвэл ээж нь үгэнд орохгүй байна хэмээн хашхиран загнаж, үг хэлэх сөхөө өгөлгүй зодож эхэлдэг. Заримдаа түүнийг аяга унагаж хагалсны төлөө загнаж зодно. Дулмааг уйлвал жижигхэн харанхуй өрөөнд хийж түгждэг. Дулмаа ээжийгээ тайван байлгах гэж аль байдгаараа хичээвч өөрийг нь сонсохгүй, дандаа загнах нь ээжийгээ шударга бус байна гэж боддог билээ. Тэрээр ээж нь яагаад түүнд ийм хатуу ханддагийг ердөө ч ойлгодоггүй. Хааяа бүр ээж нь түүнийг үнэн голоосоо үзэн яддаг байх гэж бодохоор санагддаг аж. Ээж нь Дулмааг төрүүлсний дараа дахин хүүхэд төрүүлэх боломжгүй болсноо түүний буруу гэж хэлдэг. Их уурласан үедээ Дулмааг төрөөгүй байсан нь дээр байсан юм, тэгсэн бол би өөр хүүхэдтэй болох байсан гэж хэлдэг байлаа. Дулмаагийн аав хүүтэй болж чадахгүй нь хэмээн хааяа харамсах ба үүнд ээж нь охиныг буруутган мөн л зоддог байв. Аав нь өөрийг нь өрөвддөг байх гэж охин боддог ч тэрээр эхнэрээ ууртай үед чимээгүй, холхон

байхыг хичээж, гараад явчихдаг байв. Дулмааг ганцхан багш нь сонсдог бөгөөд зодуулсан ул мөрийг нь хараад яагаад ийм болсныг нь асуудаг боловч Дулмаа ээжийгээ улам уурлах байх гэж бодоод багшдаа үнэнийг хэлдэггүй.



Хүүхдүүд хоорондын хүчирхийлэл. 1-р түүх

Даш ба Гэрэл

Даш ба Гэрэл нар 4, 5 настай үеэлүүд билээ. Тэд эцэг эх, өвөө эмээ, ах эгч дүүсийн хамт хөдөө амьдардаг. Даш өөрсдийнх нь ганц ач хүү учир өвөө эмээ нь түүнийг илүү хайрлаж, түүний хүссэн бүхнийг биелүүлдэг байв. Тэднийх 3 ач охинтой бөгөөд Гэрэл тэдний хамгийн бага нь юм. Өвөө эмээ нь Гэрэлд мөн хайртай боловч Гэрэл тэдний хувьд тийм ч чухал хүн биш байлаа. Гэрэл, Даш хоёр хамт байх бүрд Даш, Гэрэлээг чимхэх, цохих зэргээр шоглодог. Гэрэлээ өвдсөндөө чангаар уйлахад гэрийнхэн нь тэднийг салгаж, холдуулдаг боловч Дашийн буруу аашилж байгааг нь огт тоолгүй өнгөрөөдөг.



Үе тэнгийнхний дундах хүчирхийлэл. 1-р түүх

Цэцэг Туяа хоёр

Цэцэг, Туяа хоёр сумын сургуульд хамт сурч байсан найзууд билээ. Тэд хотод ирж, хамтдаа гутлын нэгэн үйлдвэрт ажилд орсон. Тэр хоёр өөр 4 охинтой хамтран өрөө хөлсөлж амьдрах болов. Тэдний хувьд эхний жил тун хүнд үе байлаа. Нутгийн аялгаар ярьдаг хэмээн бусад охидод шоглуулахаас гадна хүнсийг нь байнга хулгайлж, хэрэглэдэг охидтой маргалдаж, хэрэлдэж, заримдаа зодолддог байв. Ялангуяа Цэцэгт энэ бүхнийг давахад тун хүнд байв. Өнгөрсөн 7 хоногт Цэцэг уурласандаа нэг охиныг нь алгадсанаас болж нөгөө охин өдөржин ажлаа хийж чадаагүй билээ. Үүнээс хойш охидын хэн нь ч, тэр бүү хэл найз Туяа нь хүртэл Цэцэгтэй ярихыг хүсэхгүй байв. Охид Цэцэгийг байхгүй мэт аашилж, түүний хувцаснуудыг дураараа өмсөх, хэлэхгүй авах болсон. Түүнтэй хэн ч ярихыг хүсэхгүй байгаа учраас Цэцэг одоо сэтгэлээр унаж эхэлсэн. Түүний ажлын бүтээмж буурч, дарга нь түүнд уурлах болсон. Цэцэг гэртээ харихыг хүсэж байгаа ч ар гэрийнхэн нь түүний өгсөн мөнгөөр л амьдардаг учраас тэр явж чадахгүй байна.



Үе тэнгийнхний дундах хүчирхийлэл. 2-р түүх

Дотуур байрны амьдрал

Дугар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд энэ жил орсон, 15 настай хүү юм. Хүүг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд ирэхэд гэнэтийн зүйл угтаж авсан байна. Ахлах ангийн хүүхдүүд шинээр ирж байгаа хүүхдүүдийг дэглэдэг, шинээр ирж байгаа хүүхдүүд янз бүрийн дарамт, дээрэлхэлтийг амсах ёстой болдог. Жишээ нь хүүхдүүдээс мөнгө нэхэж, хоол хүнсийг нь булааж авах асуудал маш их байдаг. Ахлах ангийнхны иймэрхүү үйлдлүүд хүүхдүүдэд үнэхээр дарамттай байдаг ч эцэг, эх багш нарт энэ талаар хэлбэл бүр илүү ихээр зодно гэж сүрдүүлдэг тул яахаа ч мэддэггүй. Хэдийгээр Дугар чадалтай, биерхүү ч тайван зөөлөн хүү билээ. Гэсэн ч тэрээр мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв рүү явахаас халшрах тул хоёр долоо хоног өвдсөн байна.



Гэр бүлийн хүчирхийлэл. 1-р түүх

Хартай Дорж

Бадмаа 28 настай, түүний нөхөр Дорж 32 настай. Тэр хоёр Улаанбаатар хотод амьдардаг. Хүү охин хоёртой. Дорж уурхайн хотхонд ажиллах болжээ. Тэрээр жилийн долоон сард нь уурхайд

ажиллана. Дорж эхнэртээ ихэд хайртай. Уурхайд байхдаа эхнэрээ хардаж, нууц амрагтай болчих вий хэмээн ихэд шанална. Энэ талаар бодох тусам эхнэрээ улам их хардах болов. Саяхнаас эхнэр нь дэлгүүрт ажиллахаар болж, айл бүрээр явж, захиалга авах үүрэгтэй болжээ. Тэрээр заримдаа оройн цагаар ч ажиллана. Харин үүнд нөхөр нь уурлаж, эхнэрээ явуулахгүй гэдэг байв. Эхнэр нь үүнийг ажлынхаа нэг хэсэг, учир нь ихэнх хүмүүс ажлаа тарж, гэртээ ирээд захиалгаа өгдөг гэж тайлбарлаад ч сонсохыг хүсдэггүй байлаа. Нэг өдөр орой 8 цагийн үед ажлаа тараад гэртээ ирэхэд нөхөр нь нууц амрагтайгаа уулзаад ирлээ хэмээн хардаж, хэрүүл өдөж эхлэв. Эхнэр нь харин ядарсан, өлссөн байсан тул уурлав. Ингээд хэрүүл даамжирч, нөхөр нь эхнэрээ зодож, элдвээр харааж зүхэж эхэллээ. Энэ удаа байдал муугаар эргэж, эхнэр нь ноцтой гэмтэл авсан байна. Хүүхдүүд нь айснаасаа болж уйлалдаж байсан тул арай ядан тэднийг аргадаж, тайвшруулсан бүсгүй хэнд хандаж, яахаа мэдэхгүй байна.



Гэр бүлийн хүчирхийлэл. 2-р түүх

Хөөрхий эмээ

Булган эмээ тэтгэвэрт гарснаасаа хойш сэтгэл нэг л дундуур байх болов. Уг нь тэрээр охин, хүргэн, зээ охинтойгоо сүүлийн 2 жил хамт амьдарч байгаа юм. Сүүлийн үед хүргэн нь зээ охиныг нь үе үе зодохыг анзаарах болсон тул болиулахаар шаардаад ч өөрөө зодуулж, элдвээр хараалгуулах болсон тул үнэхээр сэтгэлээр унах болов. Эмээ зээ охиндоо санаа зовох тул хүргэнээ аль болох тэвчихийг хичээх болов. Хүргэн хүүгээ архи ууж ирэх тоолонд зодоон үүсэхээс эмээж, түгшинэ. Эхэндээ охин нь эхийгээ хамгаалдаг байв. Удалгүй гурвууланг нь зодох болсон тул хэсэг хугацааны дараа охин нөхрийнхөө талд орж эмгэнийг мөн л харааж зүхэх болов. Эхийгээ хүн гэж тоохоо больж, тэтгэврээр нь амьдарч байгаагаа ч мартсан мэт байх болов. Нэгэн гайтай өдөр хүргэн нь ахиад л согтуу ирж, охиныг нь зодож, эмнэлэгт хүргэхээс өөр аргагүй болоход нь тэсэлгүй цагдаа дуудаж орхив. Үүнд хорссон хүргэн эмгэнийг гэрээсээ хөөж, эд зүйлсийг нь эвдэн бусниулав.





Нэмэлт мэдээлэл: Гэр бүлийн хүчирхийлэл³

Хүчирхийлэл гэдэг нь хэн нэгэнд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн дарамт үзүүлж, хохирол учруулдаг, яагаад ч хүлээн зөвшөөрч боломгүй төрөл бүрийн үйлдлүүд юм. Хүчирхийллийн хэлбэрүүд:

- **Бие махбодын хүчирхийлэл:** Гэр бүлийн хамаарал бүхий хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ.
- **Сэтгэл санааны хүчирхийлэл:** Гэр бүлийн хамаарал бүхий хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ.
- **Бэлгийн хүчирхийлэл:** Гэр бүлийн хамаарал бүхий этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ.
- **Эдийн засгийн хүчирхийлэл:** Гэр бүлийн хамаарал бүхий хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ.

Хэрэлдэх, маргалдах, хашхирах, дарамтлах зэрэг хүчирхийллийн хэлбэрүүд нь хүчээр бэлгийн хавьталд оруулах, зодох зэргээс арай хөнгөн хэлбэрийн хүчирхийлэл юм. Гэвч хэрүүл маргаан даамжирвал хүмүүс улам их уурлан бухимдаж, бие махбод, хэл ам, сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэж болзошгүй.

Хүчирхийлэлд ихэнхдээ нийгмийн эмзэг бүлгийнхэн, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ядуу зүдүү амьдралтай хүмүүс, үндэсний цөөнх, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, ДОХ-н халдвартай хүмүүс өртдөг.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай тодорхойлолт

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тусгай тайланд гэр бүл дэх хүчирхийллийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Хувийн амьдралын талбарт, ойр дотнын цусан төрлийн эсвэл хуулиар холбогдсон хувь хүмүүсийн хооронд гардаг хүчирхийллийг гэр бүл дэх хүчирхийлэл гэжээ. Гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл гэсэн хэлбэртэй байдаг ба гол төлөв нэгэн дээвэр дор хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдийн дунд, заримдаа тухайн гэр бүлийн үйлчлэгч, ар гэрийн ажлыг нь хариуцдаг хүмүүсийн эсрэг үйлдэгдэх нь ч бий.

Гэр бүлийн хүчирхийлэл нь соёл, газарзүй, нийгэм эдийн засаг, шашин шүтлэгийн хүрээнээс хальж гарсан дэлхий нийтийн асуудал юм. Энэ бол хүний эрхийн зөрчлийн хамгийн түгээмэл хэлбэр юм. Гэр бүл дэх хүчирхийллийн хохирогчид нь ихэнхдээ эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшчүүл байдаг ч эрэгтэйчүүд ч мөн хохирогч болох нь бий. Гэр бүлд хүчирхийлэл үйлдэгдсэнээр хүүхэд эмэгтэйчүүдийн хувьд сурч боловсрох, гэр бүл, нийгэм орчин тойронтойгоо харилцах зэрэгт нь сөргөөр нөлөөлж, нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг нь хязгаарладаг. Гэр бүл дэх хүчирхийлэл нь дан ганц хувь хүний асуудал биш бөгөөд хохирогчийн зүгээс орчин тойронтойгоо, ажлын байранд бусадтай харьцахад нөлөөлдөг тул нийгмийн асуудал хэмээн

³ Эх сурвалж: *A Life Free of Violence, It's Our Right! A Resource Kit on Action to Eliminate Violence Against Women* by UNIFEM (UNIFEM: Bangkok, 2003), Defining VAW and Country Profiles.

үзэж, онцгойлон анхаарах шаардлагатай (Дасгал 8.1.3 “Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл”-г харна уу).

Хүчирхийлэл хувь хүнд хэрхэн нөлөөлдөг вэ?

Хүчирхийллээс болж ичиж зовж, шаналах нь цаашлаад юунд ч идэвх сонирхолгүй болох, өөртөө итгэх итгэлээ алдах, өөрийн үнэлгээ буурахад хүргэдэг. Хүчирхийллийг таслан зогсоохгүй, үр нөлөөг нь бууруулах арга хэмжээ авахгүй өнгөрөөх тусам стресст өртсөн хүмүүсийн адил биеийн байдал нь муудах, сэтгэцийн өөрчлөлт гарах, архи тамхи, мансууруулах бодис хэрэглэхэд хүргэдэг. Энэ бэрхшээлүүд нь хуримтлагдсаар ажлын байранд осолд орох, тахир дутуу болох, амиа хорлох хүртэл байдалд хүргэж болно.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон эхчүүдэд ганцаардах, өөрийгөө бусдаас тусгаарлах, ажиллах чадваргүй болох, цалин нь багасах, өөрийгөө болон үр хүүхдээ халамжлах чадвар нь муудах зэрэг сөрөг нөлөө илэрдэг байна. Харин бага наснаасаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн хувьд өсөж том болоод өөрөө гэр бүлээ хүчирхийлэгч болох магадлал их байдаг.

Монгол дахь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал

Гэр бүлийн хүчирхийлэл бол Монголын нийгмийн тулгамдсан асуудлуудын нэг мөн билээ. Одоо ч гэсэн энэ асуудлыг хувь хүний асуудал мэтээр үзэж, бусадтай хуваалцах дургүй хэвээр байгаа юм. Монголд гэр бүлийн хэн нэгэн гишүүний зүгээс хүчирхийллийн янз бүрийн хэлбэрт өртсөн эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Монголчуудад эцгийн эрхт ёс давамгайлж ирсэн түүхтэй бөгөөд нөхрүүд шийдвэр гаргах ёстой бөгөөд эмэгтэйчүүд санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө үгийг дагах ёстой гэдэгтэй монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь санал нийлдэг байна.

Үндэсний статистикийн газар, НҮБ-ын Хүн амын сангаас хамтран хийсэн судалгаагаар 15-64 насны 7920 эмэгтэйтэй хийсэн ярилцлагын дүнд гэр бүлийн хүчирхийлэл Монголын нийгэмд газар авсан бөгөөд тэр дундаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хүний эрхийн ноцтой зөрчлүүдийн нэг болсныг баталгаажуулсан байна. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн ихэнх нь гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлын талаар мэдээлсэн байна:

- Монгол эмэгтэйчүүд нас, боловсрол, ажил эрхлэлт, газар зүйн байдлаас үл хамааран гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байна.
- Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь (57.9% буюу 500,000 гаруй нь) амьдралынхаа туршид нэг буюу түүнээс олон хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байсан ба ихэнхдээ хамтрагчийнхаа зүгээс бие махбод, сэтгэл санаа, бэлгийн болон эдийн засгийн хүчирхийлэлд өртөж, хатуу хяналт дор нь амьдарч байгаа аж.
- Тэдний 3 хүн тутмын нэг нь (31.2%) бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан байна. Нийслэл хот болон аймгуудын хувьд энэ үзүүлэлт бага зэрэг ялгаатай байх ба хамтрагчийнхаа зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо Дархан-Уул аймагт хамгийн өндөр (41%), дараа нь Өмнөговь аймаг (39.7%) орж байсан бол Говь-Сүмбэр аймаг удаалж (35.7%), Ховд (32.9%), Улаанбаатар (31.7%) шил дарж явна.
- Хамтрагчийнхаа зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртөгчдийн дунд залуу бүсгүйчүүд (15-34 насны) хамгийн их байгаа ба нөхрөөсөө салсан, тусдаа амьдарч байгаа 10 эмэгтэй тутмын 6 нь (64%) ийм төрлийн хүчирхийлэлд өртөж байсан, мөн таван эмэгтэй тутмын нэг нь сүүлийн 12 сарын хугацаанд хамтрагчдаа хүчирхийлүүлсэн гэж мэдэгдсэн байна.
- Өсвөр насны буюу 15-19 насны охидын талаас илүү хувь нь (54.7%) одоогийн эсвэл өмнөх хамтрагчийнхаа хатуу хяналтад байдаг байсан байна.
- Боловсрол багатай эмэгтэйчүүд арай өндөр боловсролтой эмэгтэйчүүдтэй харьцуулахад бие махбодын хүчирхийлэлд илүү өртөж байгаа нь харагдаж байна.

- Нийгэм, эдийн засгийн байдлаасаа үл хамаараад дөрвөн эмэгтэй тутмын нэг нь нөхрийнхөө итгэлийн эвдсэн эмэгтэйг нөхөр нь зодож шийтгэх эрхтэй гэдэгтэй санал нийлж байна.
- Гэр бүл доторх бэлгийн хүчирхийллийн тухай ярих нь ихэнх эмэгтэйчүүдийн хувьд хэцүү байдаг ч хэн нэгэнтэй хамтран амьдарч байсан 10 эмэгтэйн нэг нь (8%) хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байснаа илэрхийлсэн байна.
- Сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийг ч гэсэн анхаарахгүй өнгөрөөж болохгүй. 10 эмэгтэй тутмын 4 нь (40.3%) сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж байсан гэсэн бол таван эмэгтэй тутмын нэг нь (22.4%) одоо ч сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөөр байгаагаа илэрхийлжээ.
- Үүнээс гадна 6 эмэгтэй тутмын нэг нь хөндлөнгийн хэн нэгний зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртөж байснаа, арван эмэгтэй тутмын нэг нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртөж байснаа илэрхийлжээ. Хүчирхийлэгчид нь ихэнхдээ гэр бүлийн гишүүд, тэр дундаа ах дүүс (21.6%), эцэг эх (19.5%), бусад хамаатнууд (15.8%), найзууд болон танилууд (19.2%), огт танихгүй хүмүүс (23.9%) байсан байна. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчид ч мөн адил: ихэнх нь гэр бүлийн гишүүд (41%, төрсөн болон хойд эцэг, төрсөн болон дагавар ах дүүс, гэр бүлийн бусад гишүүд), найз нөхөд болон танил хүмүүс (19%); албан тушаалтнууд (цагдаа, багш, шашны удирдагч) эсвэл огт танихгүй хүмүүс байсан байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хүүхдүүд дунд, ялангуяа 6-12 насны хүүхдүүд нь бусад хүүхэдтэй харьцуулахад биеэ барьсан, айсан эсвэл хэт түрэмгий, хар дарж зүүдэлдэг байдал илэрч байна. Тэдний ихэнх нь улирах эсвэл сургуулиас завсардах хандлагатай байдаг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл⁴

Үндэсний статистикийн газрын 2018 онд хийсэн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнд 1-14 насны хүүхдүүдийн 49% нь “хүч хэрэглэн хүмүүжүүлэх” аргад өртөж байсан байна. Охидтой харьцуулахад хөвгүүдэд бие махбод болон сэтгэл санааны шийтгэл илүү их оноодог байна.

Хүний эрхийн үндэсний комиссын 2016 онд хийсэн “Хүүхдийн эрх ба хамгаалал” сэдэвт мэдлэг, хандлага, хэрэглээг тодорхойлох судалгаагаар 12-18 насны хүүхдүүдийн дунд дараах баримт илэрчээ:

- 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд өртөж байсан
- 5 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн
- 2 хүүхэд тутмын 1 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн
- 4 хүүхэд тутмын 1 нь үл хайхрах байдалд өртсөн
- 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн
- Хүүхдийн эрхийг зөрчиж, хүчирхийлэл үйлдэгч гол этгээдээр дээд ангийн хүүхэд (47.6%), хойд ээж, аав (38.6%), үе тэнгийнхэн (38.4%), багш (15.0%), эцэг эх/асран хамгаалагч (12.4%) нарыг тус тус нэрлэсэн байна.

Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль⁵

Монгол улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд баталж, 2016 онд шинэчлэн найруулсан бөгөөд 2017 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Шинээр орсон өөрчлөлтүүдийн дагуу

⁴ Эх сурвалж: Save the Children, *Child Rights Situation in Mongolia 2018*, pp. 140-141; National Statistical Office, *Mongolia: Social Indicator Sample Survey 2018*, pp. 14, 17.

⁵ Эх сурвалж: The Law Library of Congress, *Mongolia: Domestic Violence Made a Criminal Offence*, <http://www.loc.gov/law/foreign-news/article/mongolia-domestic-violence-made-a-criminal-offense/>; UNFPA Asia and the Pacific, “Mongolian Parliament approves domestic violence law,” 26 May 2016, <https://asiapacific.unfpa.org/en/news/mongolian-parliament-approves-domestic-violence-law>

гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох болсон. Гэр бүлийн хүчирхийлэл анх удаа үйлдэгдсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхгүй ч давтагдсан тохиолдолд хэрэг үүсгэх аж. Тус хуулийн 2-р зүйлд "гэр бүлийн хүчирхийлэл" гэдгийг хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэжээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь дараах асуудлыг хамарна. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл (бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн хүчирхийлэл) үйлдэхийг хориглосон.
- Хохирогчийн эрхийг хангах
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн чиг үүрэг, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, Прокурорын байгууллагын чиг үүрэг зэргээр эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тогтоосон
- Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагуудын үүргийг тодорхойлсон
- Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох
- Нийгмийн ажилтан болон эрүүл мэндийн ажилтнуудын үүргийг тодорхойлсон

Үүнээс гадна Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд аргагүй хамгаалалт хийх, мөн хүүхдийн эрхийг зөрчиж, шийтгэж эсвэл үл хайхарсны улмаас хүүхдийн эрүүл мэндэд хохирол учирсан бол эцэг эх, асран хамгаалагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг заалт тусгагдсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчилд 7-30 хоногийн хугацаагаар баривчлахаас эхлээд 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Аль аль тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч "Зан үйлд нөлөөлөх албадан сургалт"-д хамрагдана.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хэрхэн туслах вэ?

- Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар 107 утас орон даяар үнэ төлбөргүй мэдээлэл хүлээн авч, тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн бүх төрлийн мэдээллийг хүлээн авна.
- Нийслэлийн цагдаагийн газрын дэргэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсвэл хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хохирогч, түүний бага насны хүүхдийг хамгаалах "Түр хамгаалах байр" ажилладаг. НҮБХАС-гийн дэмжлэгтэйгээр нэг цэгийн үйлчилгээний нийт 15 төв 10 аймаг, Улаанбаатар хотод байгуулагдан ажиллаж байна. Улсын хэмжээнд төрийн болон ТББ-ын нийт 14 гаруй хамгаалах байр ажилладаг.
- ГБХ-ийн хохирогчид эрх зүйн туслалцааг Эрх зүйн зөвлөгөө, Өмгөөллийн үйлчилгээний хэлбэрээр авч болохоор заасан байна (ГБХТТХ 39 дугаар зүйл).

Эрх зүйн зөвлөгөө гэдэг нь хууль зүйн асуудлаар амаар, бичгээр, утсаар болон цахим хэлбэрээр лавлагаа мэдээлэл өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулж туслах ажлууд орно.

Өмгөөллийн үйлчилгээ нь хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцохыг хэлнэ.

Дасгал 8.1.3 Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл



Зорилго

- Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, түүний шалтгааныг тодорхойлох
- Ажлын байранд дарамт, хүчирхийлэл үүсэх эрсдэлтэй нөхцөлийг тодорхойлох
- Ажлын байран дахь дарамт, хүчирхийллээс сэргийлэх арга хэмжээг тодорхойлох



Зорилтот бүлэг

Ажилчин залуус, насанд хүрэгчид



Хугацаа

90 минут



Суудал зохион байгуулалт

5 бүлэг болон тойргоор суух



Ашиглах материал

Дүрүүдийн тодорхойлолт гэсэн хуудсыг хувилж олшруулах (Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.3 А)



Сургалтын хэрэглэгдэхүүн

8.1.3 А: Дүрүүдийн тодорхойлолт

Нэмэлт мэдээлэл: Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл гэж юу вэ? – 15 минут
2. Багаар ажиллах – 20 минут
3. Багийн ажлаа танилцуулж, харилцан ярилцах – 45 минут
4. Дүгнэлт – 10 минут

Бэлтгэл

СХ 8.1.3 А-д өгөгдсөн дүрүүдийн жишээг нягталж, оролцогчдын онцлогт тохируулж нэр, нөхцөлийг өөрчилж болно. Нэмэлт мэдээлэл хэсгээс хүчирхийлэл, дарамтын тухай дэлгэрэнгүй уншиж танилцана уу.

Алхам 1. Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл гэж юу вэ? – 15 минут

Энэхүү дасгал нь ажлын байран дахь хүчирхийллийн тухай бөгөөд тодорхойлолт, шалтгаан, эрсдэлт нөхцөл, түүнээс хэрхэн сэргийлэх тухай ярилцана гэдгийг тайлбарлана.

- Оролцогчдоос ‘Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл’-н тодорхойлолтыг хэлж өгөхийг хүснэ. Хэд хэдэн хариулт сонссоны дараа “Нэмэлт мэдээлэл: Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл”-д байгаа тодорхойлолтыг уншиж өгнө.
- Тэгээд оролцогчдоос “Ажлын байран дахь дарамт хүчирхийлэл”-д өртөж байсан эсэхийг нь асууна. Сайн дураараа өөрийн түүхээс хуваалцах хүн байгаа эсэхийг асуух ба уг асуудал хэрхэн шийдэгдсэнийг нь мөн тодруулна.

Алхам 2. Багаар ажиллах – 20 минут

Оролцогчдыг 5-6 багт хуваана.

- Баг бүрд дүрийн тухай мэдээлэл нэг нэгийг өгнө (Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.3 А)
- Баг бүр өөрийн гол дүр ажлын байран дахь хүчирхийлэлд хэрхэн өртөж болох, түүнийг хэрхэн давж болох талаар түүх зохионо.
- Баг бүр өөрсдийн зохиомжийн дүрд тоглох болон бусдад ойлгомжтой, сонирхолтой байдлаар (жүжиглэх, түүх зохиох, өөр бусад бүтээлч хэлбэрээр) түүхээ танилцуулна.

Алхам 3. Багийн ажлаа танилцуулж, харилцан ярилцах – 45 минут

Багуудаас өөрсдийн түүхээ 5 минутад багтаан танилцуулахыг хүснэ. Тэгээд дараах асуултуудын дагуу ярилцлага өрнүүлнэ:

- Энэ түүхийн санааг хэрхэн гаргаж ирсэн бэ?
- Дарамт, хүчирхийллийн шалтгаан юу юу байсан бэ? Яагаад?
- Ажлын байран дахь дарамт, хүчирхийллийн эсрэг ажилчид тэмцэх хэрэгтэй юу?
- Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл ажилчдад ямар сөрөг үр дагавартай байж болох вэ?
- Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл ажил олгогчдод ямар сөрөг үр дагавартай байж болох вэ?
- Ажлын байран дахь дарамт, хүчирхийллийн эсрэг юу хийж болох вэ?



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Ажил эрхэлж байгаа хүн бүр ямар нэгэн аюул осолд өртөх, ажлын байран дахь дарамт, хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрт өртөх эрсдэл өндөртэй нөхцөлд байдаг. Зорилтот бүлгийнхний орон нутагт ажилладаг ажилчид болон хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн ажлын байрандаа тулгардаг дарамт, хүчирхийллийн хэлбэрүүдийг тодруулаарай.

Алхам 4. Дүгнэлт – 10 минут

Дараах санааг онцлон дурдаж дасгалыг дүгнэнэ:

- Ажлын байран дахь хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн гэх мэт хэлбэрээр илэрч болно. Ажлын байранд гардаг хэл амаар доромжилж, дарамтлахаас эхлээд бие махбодын хохирол учруулах хүртэлх бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамтыг ажлын байран дахь хүчирхийлэл гэнэ. Үүнийг үйлдэгчид нь ажил олгогч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгч, ажил эрхлэхтэй холбоотой өөр бусад хэн ч байж болдог.
- Хүүхэд болон залуу ажилчид ажлын байран дахь хүчирхийлэлд илүүтэй өртдөг нь тэд насанд хүрэгчдийг бодвол илүү сул дорой байдагтай нь холбоотой.
- Ажлын байран дахь хүчирхийлэл ажилчид төдийгүй ажил олгогч, нийгэмд бүхэлд нь сөрөг үр дагавар авчирдаг.
- Ажлын байран дахь хүчирхийллийн эсрэг арга хэмжээ авч, гэмтнийг гэсгээж, хохирогчийг хамгаалж тэмцэх нь ажилчид, ажил олгогчдын хамтын ажиллагааг шаардана.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.3 А: Дүрүүдийн тодорхойлолт

Зааварчилгаа: Хуудсыг хувилж тасархай зураасаар хайчилж бэлдэнэ. Баг бүрд нэг нэг дүр өгнө. Нэр болон нөхцөл байдлыг өөрчилж болно.



Дүр 1 Дорж

11 настай хүү

Туслах малчнаар ажилладаг, эзэн нь маш хатуу ширүүн бөгөөд хатуу шийтгэдэг.



Дүр 2 Цэцэг

17 настай охин

Холын аймгаас ирсэн, хотын дундаж орлоготой 7 ам бүлтэй айлд гэрийн үйлчлэгч хийдэг. Ажил олгогчдоосоо өөр нутгийн аялгаар ярьдаг



Дүр 3 Ирмүүн

15 настай хүү

Хотод төрж өссөн, хөдөлгөөнт худалдаа эрхэлдэг.



Дүр 4 Тулгаа

36 настай залуу

Өөр орон нутагт уурхайд ажилладаг, тэндээ амьдардаг



Дүр 5 Билгүүн

16 настай хүү

Өдөр бүр 7-с орой 10 цаг хүртэл ресторанд ажилладаг, архи пивоор үйлчилдэг



Дүр 6 Халиунаа

8 настай охин, 10 настай ахын хамт

УБ хотод хог түүж амьдардаг (аав ээж нь хөдөөнөөс нүүж ирсэн, үндэсний цөөнхөд харьяалагддаг)



Дүр 7 Чимгээ

Эмэгтэй, 26 настай

Нэгэн компанид ажилладаг. Дарга нь гэр бүлтэй, нас тогтсон эр, нууц амрагаа болохыг шаарддаг, байнга мессэж болон порно бичлэг илгээдэг.



Нэмэлт мэдээлэл: Ажлын байран дахь дарамт болон хүчирхийлэл

Хүчирхийлэл болон дарамт⁶

ОУХБ-ын 2019 оны 6-р сард баталсан “Хүчирхийлэл, дарамтын тухай 190-р конвенц” нь ажлын байран дахь дарамт хүчирхийлэл нь тэгш боломжид заналхийлсэн, зохистой хөдөлмөрийн зарчимд нийцэхгүй, хүлээн зөвшөөрөх боломжгүй хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Хүчирхийлэл, дарамт нь төр, хувийн хэвшлийн үйлчилгээний чанарт нөлөөлж, ажилчид, ажил хайгчид, ялангуяа эмэгтэйчүүдэд хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх, үлдэх, албан тушаал дэвшихийг хааж болзошгүй юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамт нь эмэгтэйчүүд, охидыг илүүтэй онилж байдгийг онцолж, хөдөлмөрийн харилцаанд хүчирхийлэл, дарамтыг зогсооход жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхах олон янзын болон давхардсан хэлбэр, эрх мэдлийн жендэрийн тэгш бус харилцаа зэрэг суурь шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг арилгах хүртээмжтэй, цогц, жендэрийн мэдрэмжтэй хандлага зайлшгүй шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Түүнээс гадна гэр бүлийн хүчирхийлэл нь хохирогчийн хөдөлмөр эрхлэлт, бүтээмж, эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болохыг тэмдэглэн, Засгийн газар, ажил олгогч, ажилтны байгууллагууд, хөдөлмөрийн зах зээлийн байгууллагууд хариу арга хэмжээ аван шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж чадна гэдгийг тэмдэглэжээ.

Тодорхойлолт: Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл нь хэн нэгний бие махбод, сэтгэл санаа, бэлгийн болон эдийн засгийн халдашгүй байдалд гэмтэл учруулах гэсэн зорилготой, нэг болон олон удаагийн хүлээн зөвшөөрч боломгүй төрөл бүрийн үйлдлүүд, зан авир үзүүлэхийг хэлнэ. Үүнд бэлгийн дарамт хүчирхийллийг ч мөн оруулна.

Хүчирхийлэл болон дарамт нь дараах хэлбэрээр илэрч болно:

- **Бие махбодын хүчирхийлэл:** зодох цохих, алах, нярайг хөнөөх, хүнс эмчилгээний зүйлээр гачигдуулах, гэмтээх, түлэх, зэвсэг хэрэглэх, хил дамжуулан наймаалах г.м.
- **Сэтгэл санааны хүчирхийлэл:** доромжлолын бүх хэлбэр, нэр хүндийг нь унагах, үл тоомсорлох, мөлжих, үгээр дайрч доромжлох, эрх чөлөө эрхийг нь боогдуулах
- **Бэлгийн хүчирхийлэл:** бэлгийн хүчирхийллийн бүх хэлбэр, гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл, хүчээр биеийг нь үнэлэх, хүчээр бэлгийн хавьталд оруулах
- **Эдийн засгийн хүчирхийлэл:** мөнгө, эдийн засгаар нь боолт хийх, эдийн засгийн хяналт тавих, олж буй мөнгийг нь хураан авах, шийдвэр гаргах эрхийг нь хязгаарлах

Тодорхойлолт: Жендэрт суурилсан хүчирхийлэл болон дарамт гэдэг нь ямар нэгэн хүнийг жендэр болон хүйсээс нь шалтгаалж дарамтлах, хүчирхийлэх үйлдлүүд эсвэл тухайн хүйсэд харьяалагддаг болохоор тэдний эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн хүчирхийлэл зэргийг багтаан ойлгож болно.

Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл гэдэг нь ажлын байр эсвэл ажил гүйцэтгэж байх үед үйлдэгдсэн, хүлээн зөвшөөрөхүйц байдлаас хэтэрсэн, бусдыг айлгасан, дарамталсан, хохироосон, гэмтээсэн үйлдэл, тохиолдол, зан үйлийг хэлнэ.

⁶ Эх сурвалж: https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:C190

Ажлын байран дахь хүчирхийллийн хамгийн ноцтой хэлбэр нь ихэнх улсад Эрүүгийн хуулиар хориглосон бие махбодын болон бэлгийн халдлага болох хүчин, аллага зэрэг гэмт үйлдлүүд байдаг. Өөр бусад түгээмэл хэлбэрүүдээс нь дурдвал, бэлгийн дарамт буюу бэлгийн сонирхлоо хэтэрхий илт илэрхийлэх, бэлгийн хавьталд орохыг тулган шаардах, хэн нэгнийг нийгэмд гадуурхагдах нөхцөлд оруулах, дээрэлхэх, бөөрөлхөх, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зэрэг ордог.

Дээрэлхэх, доромжлох гэдэг нь байнгын давтамжтайгаар тухайн хүнийг/хэсэг бүлэг ажилчдыг хувийн амьдрал болон ажил мэргэжилд нь сөргөөр нөлөөлөхүйц байдлаар дайрч доромжлох үйлдэл байдаг. Ажлын байран дахь хүчирхийлэл нь ажиллах үед тохиолдож болохоос гадна ажилд сонгон шалгаруулах явцад ч тохиолдох боломжтой. Жишээ нь, бэлгийн хавьталд орох нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн үед ажилд авах шийдвэр гаргах г.м.

Ажилтай холбоотой нөхцөлд ажлын байран дахь хүчирхийллийг ажил олгогч, ахлагч, зааварлагч, хамтран ажиллагч, зочин, үйлчлүүлэгч г.м. тухайн ажилчинтай харилцаж байгаа хэн ч үйлдэж болдог. Ихэвчлэн ажлын байран дээр биетээр тохиолдож болох ч ажилтай холбоотой бусад нөхцөлд ч, утсаар харилцах, и-мэйл бичих, ажилчдын байранд, томилолтоор явах үед, ажлын хамт олны зугаалгын үеэр г.м. тохиолдож болдог. Дарамт гэж тооцогдох үйлдлүүдийг дурдвал:

- **Бие махбодын** - бэлгийн хүчирхийлэл, хүсээгүй байхад биед хүрэх г.м.
- **Үгэн** - элдэв шүүмж, таагүй онигоо, шууд доромжлох, бохир үг хэллэгээр харилцах г.м.
- **Үгэн бус** - ширтэх, хялайх, шүгэлдэх, сүрдүүлсэн хандлага, 18+ онигоо ярих, гадуурхалт г.м.

Ялгаварлах (Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай ОУХБ-ын 111-р Конвенцоор (1958 он) тодорхойлсон ялгаварлан гадуурхах үндэслэл болох арьс үндэс, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа буюу нийгмийн гарал, түүнчлэн үндэсний хууль тогтоомжид тусгагдсан бусад үндэслэлийн аль нэгэд суурилж үйлдэгдсэн хүчирхийлэл болон дарамт нь ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болно (Нэмэлт мэдээллийг Сэдэв 11.2-с харна уу). Монгол улс ОУХБ-ын 111-р конвенцыг 1969 оноос хойш мөрдөж байгаа бөгөөд энэ нь суурь конвенц тул хуулийн адил үйлчилдэг билээ.

Хүчирхийлэл, дарамтын тухай ОУХБ-ын 2019 оны 190-р конвенцоор үндсэн ажилтнууд, сургалтад хамрагдаж байгаа хүн, дагалдан, дадлагажигч ажилтан, хөдөлмөр эрхлэлт нь дуусгавар болсон ажиллагчид, сайн дурын ажилтан, ажил хайгч, ажилд орох өргөдөл гаргагч, ажил олгогч зэрэг хөдөлмөрийн ертөнцөд хамаатай ажиллагчид болон бусад хүнийг хамгаална. Энэхүү Конвенц нь албан болон албан бус эдийн засаг, хот, хөдөөд байгаа төр, хувийн хэвшлийн бүхий л салбарт хамааралтай бөгөөд ажил хөдөлмөртэй холбоотой бүхий л нөхцөлийг хамарна:

- (а) ажлын байранд, түүний дотор ажлын байран дахь нийтийн болон хувийн орон зайд
- (б) ажилтан цалинждаг, амралт эсвэл хоолны завсарлага авдаг, ариун цэврийн, угаалгын эсвэл хувцас солих өрөө ашигладаг газарт
- (в) ажилтай холбоотой томилолт, аялал, сургалт, арга хэмжээ эсвэл нийтийн арга хэмжээний үеэр
- (г) ажилтай холбоотой харилцаа холбоогоор, түүнчлэн мэдээлэл, харилцаа холбооны технологиор дамжуулан
- (д) ажил олгогчоос олгосон байранд
- (е) ажил руугаа явах ба буцах үед

Хэн онцгой эрсдэлтэй вэ?

Хүчирхийлэлд ихэнхдээ нийгмийн эмзэг бүлгийнхэн, хүүхэд, эмэгтэйчүүд, залуу ажилчид, түр ажиллагчид, ядуу болон үндэсний цөөнхийн хүмүүс, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, ДОХ-ын халдвартай хүмүүс өртдөг. Олон нийттэй харьцдаг ажил байх тусам ажлын байрандаа хүчирхийлэл, дарамтад өртөх эрсдэл ихтэй. Эдгээр эрсдэл ихтэй ажил мэргэжлийн тоонд дараах мэргэжлүүд орно:

- Сувилагч, эмнэлгийн ажилтнууд
- Гэрийн үйлчлэгч, асрагчид
- Нийтийн тээврийн ажилтнууд
- Зоогийн газар, зочид буудлын ажилтнууд
- Үйлчилгээний газар, амралт цэнгээний газрын ажилтнууд
- Багш нар
- Худалдааны ажилтнууд
- Цагдаа хамгаалалтын ажилтнууд
- Менежер, хүний нөөцийн ажилтнууд

Эрсдэлийг улам нэмэгдүүлдэг нөхцөлүүд:

- Ганцаараа ажиллах, ганцаар тээврийн тэрэг барин аялах г.м.
- Дарамт дор ажиллах
- Олны нүднээс далд ажилладаг (айлд эсвэл загасчны завин дээр эсвэл гадны хүн оруулдаггүй үйлдвэрт)
- Согтуу хүмүүстэй ажилладаг, баар, рестораны зөөгч, онгоцны үйлчлэгч г.м.
- Хэтэрхий хөл ихтэй, хүн үймсэн задгай газар, суух, амрах, утсаар ярих, саатах боломж багатай үйлчилгээний газар ажиллах.
- Тогтсон дүрмийг биелүүлэхгүй зөрчиж байгаа үйлчлүүлэгчтэй харьцах (автобусны билет авахгүй байх г.м.)

Гэмт хэрэгтнүүд нь эмэгтэйчүүд, менежерүүдийг зөөлөн идэш хэмээн олзлох дуртай, ялангуяа хүчирхийлэл бүхий орчин нөхцөлд ажиллаж буй залуу эмэгтэйчүүдэд энэ өнцгөөс хандах нь элбэг.

Ажлын байран дахь хүчирхийллийн үр дагавар юу вэ?

Ажил дээр:

Хүчирхийлэл нь тэр даруйдаа ажлын байранд үл ойлголцол, ажлын зохион байгуулалтын алдагдал, хагаралтай орчныг бүрдүүлдэг ба цаашид ч удаан үргэлжлэх аюултай. Ажил олгогчдын хувьд ажил нь зогсох, түүнээс шалтгаалан аюулгүй байдлыг хангахын тулд нэмэлт зардал гаргах нөхцөлд хүрч болзошгүй. Мөн ажлын бүтээмж буурах, бүтээгдэхүүний чанар муудах, байгууллагын нэр хүнд алдагдах, үйлчлүүлэгчдээ алдах зэрэг дам хохирлыг амсаж болно

Хувь хүнд:

Хүчирхийллээс болж ичиж зовон, шаналах нь сонирхол идэвхгүй болох, өөртөө итгэлгүй болох, өөрийн үнэлгээ буурахад хүргэдэг. Хүчирхийллийн шалтгааныг таслан зогсоохгүй, түүний үр нөлөөг арилгах арга хэмжээ авахгүй бол стресст өртсөний нэгэн адил биеийн байдал муудаж, сэтгэцийн эмгэг бий болох, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис хэрэглэхэд хүргэдэг. Энэ бэрхшээлүүд нь хуримтлагдсаар ажлын байранд осолд орох, тахир дутуу болох, амиа хорлох байдалд хүргэж болно.

Олон нийтэд:

Хүчирхийллийн улмаас хохирогчид учирсан хохирлыг барагдуулах эмнэлгийн зардал, нийгэмшүүлэх зардал, ажил тасалдсаныг нөхөн олгох зардал, тахир дутуу болсон бол нөхөн сэргээх болон эмчлэх, нийгмийн халамжид хамруулах зардлууд олон нийтийн төсвөөс гардаг.

Ажлын байран дахь хүчирхийллийн үед юу хийх хэрэгтэй вэ?

- Өөрийн итгэдэг хэн нэгэнд хандаж ярилцаарай. Учир нь танд чиглэсэн хүчирхийлэлд та буруугүй. Та айж, өөрийгөө буруутгаж, магадгүй хүчирхийлэл үйлдсэн хүнийг “өрөвдөж” эсвэл аюулгүй байдал болон хүндлэлийг зохих түвшинд анхааралдаа авдаггүй байгууллагад ажилладаг байсан ч хүчирхийллийг зогсоох аргыг олох нь чухал. Хүчирхийлэл болон дарамтыг хэрэгсэхгүй байх нь түүнийг улам даамжруулах болно.
- Хамтран ажиллагчид, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийнхэнтэй энэ талаар ярилцаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй.
- Биеэ хамгаалах, аюулд орсноо мэдэгдэх дохио зэргийг ашиглахад суралц. Гэхдээ энэ бүхэн дангаараа хангалттай биш байж болно. Учир нь хүчирхийлэл үйлдэгдэх бодит шалтгаан (хүчирхийлэгчийн онцлог, арьс үндэс болон хүйсээр нь ялгаварлах үзэл, ажлын байран дах аюултай нөхцөл байдал г.м.) хэвээр хадгалагдана.
- Ажилчид аюулгүй нөхцөлд ажиллах эрхтэй. Иймд ажил олгогч нь нөхцөл байдалтай танилцаж, хүчирхийлэл дарамтаас хамгаалах арга хэмжээ авах зохицуулалтыг хийж, менежер, зааварлагч, ахлагч нарт хүчирхийлэл дарамт үүсэхгүй байх нөхцөлийг хангаж ажиллахыг анхааруулах хэрэгтэй.
- Хэрвээ хүчирхийллийн цочролын улмаас хар дарж зүүдлэх, анхаарал төвлөрөхгүй байх, хооллолт, нойр болон хосын харилцаанд тааламжгүй байдал 7 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл мэргэжлийн хүний туслалцаа авах хэрэгтэй.

Дасгал 8.1.4 Бэлгийн хүчирхийлэл



Зорилго

- Бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар мэдэх
- Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой бодит баримт болон ташаа ойлголттой танилцах
- Бэлгийн хүчирхийллийн эсрэг ямар арга хэмжээ авч болохыг мэдэх



Зорилтот бүлэг

- Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид (эцэг эх, багш, асран хамгаалагч, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнууд, цагдаа)



Хугацаа

- Хүүхэд, залуучууд 120 минут
- Насанд хүрэгчдэд 145 минут



Суудал зохион байгуулалт

Өрөөний голд том зай гарган тойрог байдлаар суух



Ашиглах материал

Самбарын цаас, самбарын үзэг, скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.4: Бэлгийн хүчирхийллийн түүхүүд

Нэмэлт мэдээлэл: Бэлгийн хүчирхийлэл



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Түүхүүд – 40 минут
2. Ташаа ойлголт ба бодит баримт – 20 минут
3. Хохирогч болон олон нийтэд учрах сөрөг үр дагавар – 20 минут
4. Юу хийх хэрэгтэй вэ – Хүүхэд залууст 15 минут, насанд хүрэгчдэд 60 минут
5. Дүгнэлт – 5 минут

Бэлтгэл

Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.4-д байгаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай 6 түүхээс оролцогчдын онцлогт тохируулан 2-3-ыг сонгон авна (Хэрэв та Дасгал 8.1.1-г ажиллуулаагүй эсвэл ажиллахаар төлөвлөөгүй бол 6-р түүхийг заавал оруулаарай):

- 1) Өсвөр насандаа хойд эцгийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн Ариунаагийн түүх
- 2) Гэр бүлийн хүрээнд бэлгийн дарамтад өртөж буй Жаргал охины түүх
- 3) Зоогийн газарт ажилладаг Мөнхөөгийн үйлчлүүлэгч нь бэлгийн дарамт учруулж буй түүх
- 4) Гэрийн үйлчлэгч хийдэг Номинг гэрийн эзний хүү бэлгийн хүчирхийлэлд өртүүлж буй түүх
- 5) Барилга дээр ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй Билэгт хүүгийн хамт ажилладаг хүмүүс бэлгийн дарамт үзүүлж буй түүх
- 6) Ресторанд зөөгч хийдэг Нандины үйлчлүүлэгч нь бэлгийн дарамт үзүүлж буй түүх

Алхам 1. Түүхүүд – 40 минут

Энэ сургалт нь бэлгийн хүчирхийлэл, түүний эсрэг юу хийх ёстой тухай өгүүлэх болно гэдгийг оролцогчдод тайлбарлана. Оролцогчдыг эхний түүхийг анхаарч сонсохыг хүснэ.

Дараах асуултуудын дагуу ярилцана:

- Тухайн хүүхэд/хүн ямар асуудалтай тулгарсан бэ?
- Иймэрхүү байдалтай тулгарсан бол юу гэж нэрлэдгийг мэдэх үү?
- Тухайн хүүхэд/хүний гаргасан хариу үйлдлийн тухай юу гэж бодож байна вэ?
- Чи оронд нь байсан бол ямар санагдах байсан бол?
- Чи юу хийх байсан бэ?

Сонгосон бусад түүхээ уншиж өгөөд өмнөх маягаар ярилцлагаа өрнүүлж, дараах асуултыг асууна:

- Эдгээр түүхүүдэд юу давтагдаж байна? (хүүхдүүд/хүмүүс бэлгийн хүчирхийлэлд өртсөн ба хүсээгүй байхдаа бэлгийн дарамтад орж, туулж, хүлцэн өнгөрүүлэх ёстой болсон)

Гэр бүл болон ажлын байран дахь бэлгийн халдлага, дарамт (түүх 1-5) болон ажлын байран дахь бэлгийн дарамтын (түүх 6) янз бүрийн хэлбэрийн ялгааг хэлэлцэж тайлбарлаарай. Самбар эсвэл самбарын цаасан дээр **Бэлгийн халдлага** (хүчин, хүүхдийг хүчирхийлэх), **Бэлгийн дарамт** гэсэн түлхүүр ойлголтууд, тэдний тодорхойлолтыг бичнэ (Нэмэлт мэдээллээс дэлгэрэнгүй тодорхойлолтыг харна уу)

Дүгнэлт

- Бэлгийн хүчирхийлэл нь охид хөвгүүд, эрэгтэй эмэгтэй хэнд ч тохиолдож болох ч ихэнх хохирогчид нь охид, эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг. Ялангуяа хүүхэд, залуу насныхан өөрийгөө хамгаалах чадвар сул байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй бол түүнээс илүү эмзэг, хүчирхийлэлд өртөмтгий байдаг.
- Бага наснаасаа ажил хийж эхэлсэн хүүхдүүд онцгой эрсдэлтэй болдог.
- Өөрөөс нь илүү хүч чадалтай, эрх мэдэлтэй хүмүүсийн (эцэг эх, насанд хүрэгчид, багш, ахлах насны хүүхдүүд г.м.) зүгээс ирдэг хүчирхийллийг сөрж зогсох нь хүүхдүүдийн хувьд маш хэцүү. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд ихэвчлэн гэр бүлийнхээ тавьсан өрнөөс болоод ажил олгогчоосоо холдох эрхгүй байдалд орсон байдаг.

Алхам 2. Ташаа ойлголт ба бодит баримт – 20 минут

Бэлгийн хүчирхийлэл, дарамтын гол хохирогч нь гол төлөв охид, эмэгтэйчүүд байдаг ч эрчүүд, хөвгүүд мөн хохирогч болох тохиолдол гардаг болохыг, мөн хүчирхийлэл үйлдэгчид нь ихэнхдээ эрчүүд байдаг тухай оролцогчдод тайлбарлана.

Нэмэлт мэдээллийн 4-р хэсгээс бэлгийн хүчирхийллийн тухай зарим нэг статистикийг танилцуулна:

- Дэлхий даяар 3 эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа аль нэг үед дор хаяж нэг удаа ойр дотнын хүн эсвэл өөр хэн нэгний зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг.
- Монголд 3 эмэгтэй тутмын нэг нь биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан
- Монгол эмэгтэйчүүдийн 8% нь хамтрагчийнхаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан
- 10 Монгол эмэгтэй тутмын нэг нь 15 наснаасаа өмнө бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан
- 12-18 насны 8 хүүхэд тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан

Оролцогчдоос хос хосоороо хүчирхийллийн шалтгааны талаар ярилцаж, санаагаа тэмдэглэхийг хүснэ (Охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэмшлийн асуудал, түүнчлэн монголын соёл дахь зарим итгэл үнэмшил, жендэрийн хэвшмэл үзэл, хэм хэмжээний тухай яригдана. Тухайлбал, эрэгтэй хүн бол өрхийн тэргүүн, түүнийг хүндлэх, үгэнд нь орох хэрэгтэй. Эмэгтэйчүүд эрэгтэй хүнд захирагдах ёстой, өөрөө хүсээгүй ч эрэгтэй хүний бэлгийн дур хүслийг хангах ёстой. Задгай, секси хувцасласан эмэгтэйчүүд бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртдөг. Эрчүүд бэлгийн дур хүслээ барьж чаддаггүй. Монгол эрэгтэй хүүхдийг хатуу аргаар хүмүүжүүлдэг, охидыг бодвол тэд илүү хатуу шийтгэл хүлээдэг. Тэд өсөж нас бие гүйцэхдээ өөрийн сэтгэл мэдрэмжээ илэрхийлж сураагүй байдаг бөгөөд хүчирхийллийн аргаар аливаа асуудлыг шийдэхийг оролддог). Яагаад зарим эрэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэл үйлддэг тухай, яагаад хүмүүс үүнийг жигшдэг тухай, мөн хүчингийн хэргийн тухай ташаа ойлголтууд болон бодит үнэнийг Нэмэлт мэдээллийн 5, 6, 7-р хэсгүүдээс харна уу.

Хамгийн чухал гэж үзсэн санааг өөр самбар дээр буулган бичээд, дараах асуултын дагуу дүгнэн ярилцана:

- Бэлгийн харилцаанд эрчүүд, хөвгүүдийн гаргадаг түрэмгий үйлдлүүдийг заримдаа нуун дарагдуулж, харин охид эмэгтэйчүүдийг битгий маяглаад бай гэж зэмлэдэг.
- Эрэгтэйчүүд/хөвгүүдийг "байгалиасаа ийм" хэмээн өөгшүүлж, харин эмэгтэйчүүдийг өөрсдөө задгай хувцаслаж, эрчүүдийг өдөөж, хүчирхийлэл үүсгэхэд хүргэдэг хэмээн буруутгадаг.
- Гэхдээ эдгээр ташаа ойлголт нь бодит байдлаас зөрдөг учир буруу юм. Бодит баримт бол:
 - o Зарим эрчүүд л дарамталдаг болохоос бүх эрчүүд ийм биш. Хэн нэгэнд таагүй үйлдэл гаргасныгаа өөрийн бэлгийн дур хүслийн золиос боллоо гэж тайлбарлах нь үнэмшилгүй шалтаг юм. Өөрийн бэлгийн дур хүслээ барьж хянаж чаддаг, охид, эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй ханддаг хөвгүүд, эрчүүд тэдний дунд нэр хүндтэй байдаг.
 - o Тухайн тогтсон заншлыг дагаж, битүү хувцасладаг, даруухан эмэгтэйчүүд ч мөн бэлгийн хүчирхийллийн хохирогч болох тохиолдол байдаг.
 - o Бэлгийн дарамт, хүчирхийлэл нь бэлгийн дур хүсэл гэхээсээ илүүтэй хүч чадлаа буруугаар ашиглахтай холбоотой.
 - o Бэлгийн хүчирхийлэл нь нөгөө тал нь хүссэн хүсээгүй эрчүүд хүссэн үедээ бэлгийн харилцаанд орох эрхтэй гэх буруу ойлголтоос үүдэлтэй ба хүчирхийлэгчдийн ихэнх нь ял шийтгэлгүй өнгөрдөгтэй холбоотой.

Алхам 3. Хохирогч болон олон нийтэд учрах сөрөг үр дагавар – 20 минут

Оролцогчдыг санаа цуглуулах аргыг хэрэглэж хос хосоороо бэлгийн хүчирхийлэл, дарамтаас үүсэх үр дагавар болон түүнээс урьдчилан сэргийлэх аргуудын талаар ярилцахыг хүснэ. Дараах асуултын дагуу ярилцлага өрнүүлнэ:

- Бэлгийн хүчирхийлэл, дарамтын хохирогч юу мэдэрдэг байх гэж бодож байна вэ?
- Бэлгийн хүчирхийлэл, дарамтын хор уршиг нь гэр бүл, хамт олон, ажлын байр, нийгэмд хэрхэн илэрдэг гэж бодож байна вэ?

5 минутын дараа оролцогчдоос өөрсдийн хариултаа хуваалцахыг хүснэ (Нэмэлт мэдээллээс бэлгийн хүчирхийллийн үр дагаврын тухай 8-р хэсгийг харна уу). Санаануудыг жагсааж бичээд дараах байдлаар дүгнэнэ:

- Бэлгийн дарамт, хүчирхийллийн үр дагавар нь хохирогчид бие махбод, сэтгэл санаа, сэтгэл зүйн хувьд маш том цохилт болдог бөгөөд ялангуяа өөрийгөө хамгаалж чадахгүй бага насны хүүхдийг өөрийгөө буруутгах, сул доройд тооцох зэргээр маш хүнд байдалд оруулдаг. Тэдгээр хүүхдүүд эрүүл саруул бие хүн болж төлөвших боломжгүй болтлоо хохирдог. Хохирогчид бүгд л айж сандарсан байдаг тул сэтгэлийн дарамтад мөн ордог. Эрүүл мэндийн хувьд доройтож, гэртээ болон ажил, сургууль дээрээ биеэ авч явж чадахгүйд хүрдэг. Бэлгийн хүчирхийлэл амархан даамжирдаг тул хохирогчид нь ахин бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлал их байдаг.
- Бэлгийн дарамт, хүчирхийллийн үр дагавар гэр бүл, хамт олон, сургууль, ажлын байр, нийгэм зэрэгт бүгдэд нь хор хохирол учруулдаг. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэн газарт хүүхэд, насанд хүрэгчид хэн ч байсан амьдрах, ажиллах хүсэлгүй болдог. Бэлгийн хүчирхийллийг гол төлөв нуун дарагдуулж өнгөрөх нь элбэг байдаг нь орчин тойрондоо итгэлгүй, сэжиглэж хандах байдалд хүргэж, хохирогчдыг хамгаалахад садаа болдог. Хүчирхийлэл үйлдэгчдийг нуун хаацайлж, шийтгэлгүй өнгөрөөх нь тэднийг улам гааруулж, илүү ноцтой хүчирхийлэл үйлдэх нөхцөлийг нь бүрдүүлж, аюултай орчин бий болдог. Хохирогчид байнгын айдас түгшүүртэй, ганцаардмал, итгэл найдваргүй нөхцөлд ордог.

Алхам 4. Юу хийх хэрэгтэй ? Хүүхэд залууст - 15 минут, насанд хүрэгчдэд - 60 минут

Хүүхэд залууст

Оролцогчдыг хос хосоороо дараах асуултуудын дагуу ярилцахыг хүснэ:

- Бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн бол чи юу хийх вэ?
- Бэлгийн дарамт, хүчирхийллийн гэрч болбол чи юу хийх вэ?
- Бэлгийн хүчирхийлэл дахин давтагдахгүй байхын тулд, хохирогчид туслахын тулд чи юу хийх вэ?

5 минутын дараа хариултаудыг сонсоод, түлхүүр үгсийг самбарт бичнэ. Орхигдсон санаануудыг нэмж, дүгнэлт хийнэ (Нэмэлт мэдээллийн 9-р хэсгийг харна уу).

Насанд хүрэгчдэд (эцэг эх, багш, эмнэлгийн ажилтан, нийгмийн ажилтан, цагдаа)

Монгол улсад охид эмэгтэйчүүд болон хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй бэлгийн хүчирхийлэл, дарамтын тохиолдлыг хэлэлцээрэй. Зарим статистик мэдээг танилцуулаарай (Нэмэлт мэдээллийн 4-р хэсгийг харна уу). Хохирогчид, эцэг эх, ажил олгогчид ийм төрлийн хэргийг мэдээлэх дургүй байдаг учраас эдгээр тоо баримт нь мөсөн уулын зөвхөн ил харагдах хэсэг болохыг тайлбарлаарай. Түүнээс гадна бэлгийн хүчирхийллийн (үүний дотор гэр бүлийн хүчирхийлэл) хохирогчдыг дэмжих дэмжлэг сул байдаг.

Оролцогчдыг багуудад хувааж (эцэг эхчүүд нэг баг, адил ажил мэргэжлийн хүмүүс нэг баг), дараах асуудлыг хэлэлцэхийг хүснэ:

- Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсооход манай улс ямар арга хэмжээ авч байна?
- Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалахын тулд цаашид ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?
- Хүүхэд, насанд хүрэгчдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхийн тулд Монгол улсад ямар бэрхшээл, ямар боломжууд байна вэ?

30 минутын дараа багуудаас өөрсдийн гол дүгнэлт болон зөвлөмжийг товч танилцуулахыг хүснэ. Багуудын ажлын үр дүнг нэгтгэж, Нэмэлт мэдээллийн холбогдох мэдээллийг ашиглан орхигдсон санааг нэмж дүгнэлт хийнэ.

Алхам 5. Дүгнэлт – 5 минут

Хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэж, дараах санааг онцолж, дүгнэлт хийгээрэй:

- Бэлгийн дарамт, хүчирхийлэл нь бэлгийн дур хүсэл гэхээсээ илүүтэй хүч чадлаа буруугаар ашиглахтай холбоотой гэмт хэрэг юм.
- Бэлгийн хүчирхийлэл, халдлага, дарамт нь хүлээн зөвшөөрч боломгүй байдлаар бие махбод, сэтгэл санаа, сэтгэл зүй, бэлгийн харилцааны хувьд шаналал, хохирол учруулдаг.
- Бэлгийн дарамт нь бусдыг хүсээгүй байхад нь тухайн хүний нэр хүндэд халдаж, бэлгийн сэдлээ биеэр, үг хэлээр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх үйлдэл юм.
- Бэлгийн хүчирхийлэл нь зөвхөн царайлаг сайхан эмэгтэйчүүдэд төдийгүй хэнд ч тохиолдож болно. Мөн олон нийтийн газар, гэр, сургууль болон ажил гэх мэт ямар ч орчинд үйлдэгдэж болно. Үүний сөрөг ноцтой үр дагавар нь хувь хүн, гэр бүл, нийгэм, ажил болон хамт олон гээд бүхий л хүрээнд илэрдэг.
- Хүчирхийллийн хохирогчид нь ихэнхдээ охид, эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг хэдий ч эрэгтэйчүүд ч мөн хохирогч болох нь бий.
- Ихэнх хүчирхийлэгчид охид, эмэгтэйчүүдийг оролддог бол зарим эрэгтэйчүүд болон хөвгүүд сул дорой эрчүүдийг онилдог.
- Ихэнх тохиолдолд нас бага, ажлын байр нь баталгаагүй эсвэл хөгжлийн бэрхшээл зэргээс хамаарч ажил дээрээ ч, гэртээ ч, гудамжид ч эмзэг нөхцөлд байдаг хүмүүс хохирогч болдог.
- Нийгмийн зарим хэсэг бүлэг хүчирхийлэлд илүү өртөмтгий байх магадлал их ба ялангуяа охид эмэгтэйчүүд, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх хүмүүс үүнд багтдаг. Мөн зарим нэг онцгой нөхцөл болох зэвсэгт мөргөлдөөн, хямралт байдал, мөргөлдөөн дууссаны дараах үед хүчирхийлэл гаарах хандлагатай байдаг.
- Эрэгтэйчүүд бүгд хүчирхийлэл үйлддэггүй хэдий ч бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь хэрвээ эрэгтэй хүн хүсэх л юм бол нөгөө тал хүссэн ч бай хүсээгүй ч бай бэлгийн харилцаанд орох эрхтэй гэж үздэг эрэгтэйчүүд байдаг.
- Бэлгийн хүчирхийллийн ихэнх нь нууцлагдмал үлддэг нь хүчирхийлэгчдийг шийтгэлгүй үлдээн өөгшүүлж, энэ төрлийн хэрэг нэмэгдэх шалтгаан болдог.
- Хэрэв та бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртвөл, аминд чинь халдана гээгүй л бол үүнийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлж, бусдаас тусламж эрж, ганцаар шанахахгүй байх замыг сонгоорой.

- Хэрэв та бэлгийн хүчирхийлэл, дарамтын гэрч болбол үүнийг ноцтойгоор авч үзэж, аль болох хохирогчид туслахыг хичээж, гэр бүл, ажил, өөр ямар ч орчинд байсан холбогдох газруудад нь мэдэгдэж, үүнийг таслан зогсоох арга хэмжээ авах хэрэгтэй.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.4 А: Бэлгийн хүчирхийллийн түүхүүд

Зааварчилгаа: Дараах 6 түүхээс 2-3-г сонгож Алхам 1-т хэрэглэнэ.

Түүх 1. Ариунаагийн түүх (залуу эмэгтэй)

Ариунаа одоо 22 настай бөгөөд хөдөө амьдардаг. Ээж болон хойд эцэгтэйгээ, 4 дүүгийн хамт амьдардаг байхдаа 14 насандаа хойд эцгийнхээ зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн. Тэр даруй цагдаад мэдэгдсэн боловч тэд охины онгон хальс гэмтээгүй учир худал хэлсэн байна хэмээн үзсэн. Үүнээс хойш хойд эцэг нь долоо хоног бүр түүнийг хүчирхийлэх болсон бөгөөд ээждээ хэлсэн ч хойд эцэг нь охиныг худал хэлж байна хэмээн итгүүлж дөнгөдөг байв. Иймээс бэлгийн хүчирхийллийн олон удаагийн энэхүү хэргийг хэн ч зогсоож чадаагүй юм. Одоо тэр эрүүлдээ, согтуудаа, өдөр, шөнө хэзээ ч хамаагүй хүчирхийлж, ээжийг нь зодож, хутга гарган шидэх болов. Охин энэ бүхэнд маш их шархалж, шаналж, сэтгэлээр унаж, уурлаж, ээждээ гомдох болжээ. Үүнээс хойш жилийн дараа энэ бүхнийг цаашид тэвчиж чадахааргүй болж, өвөө эмээдээ энэ тухай хэлсэн байна. Өвөө эмээ нь ирж ээжтэй нь уулзаж ярилцахад ээж нь юу хийхээ мэдэхгүй байдалд орсон аж. Харин нагац ах нь энэ бүхнийг цагдаад хэлж, хэрэг үүсгэсэнд хойд эцгийг нь 15 жил хорих ялаар шийтгэв. Охин ээжийгээ өрөвдөж байсан ч түүнд гомдсондоо ахиж хамт амьдрахыг хүсээгүй байна. Иймд хот руу ажил хайхаар иржээ.

Тэрээр юу туулж өнгөрүүлснээ хэзээ ч мартах боломжгүй бөгөөд тухайн асуудал нь хар дарсан зүүд мэт байнга түүнийг зовоох болов. Энэхүү явдлыг охин мартаж чадаагүй бөгөөд гэр бүл, үр хүүхэдтэй болохыг хүсдэг ч эр хүнээс айдаг болохоор хэн нэгнийг хайрлаж, гэрлэж чадна гэж төсөөлөхгүй байсаар байна. Тэр одоо яавал дээр вэ?

Түүх 2. Хөгжилтэй охин Жаргал дуугаа хураах болов

Жаргал 12 настай, аав ээжтэйгээ амьдардаг айлын ганц хүүхэд. Тэрээр их хөгжилтэй охин байв. Сайн найзтайгаа хамт нэг ангид сурдаг тул сургуульдаа явах дуртай, багш болон ангийнхантайгаа нөхөрсөг харилцдаг байсан ч сүүлийн үед дуугаа хураах болов. Ээж нь үүнийг ажигласан бөгөөд ялангуяа ойрхон амьдардаг 21 настай үеэлийгээ ирэх үед бүр ч их таагүй байгааг нь анзаарчээ. Тэднийх хөдөөнөөс гэр хороололд нүүж ирээд удаагүй бөгөөд хамаатнуудаа бараадан буусан нь энэ билээ. Заримдаа аав ээж нь гадагш явах үедээ охиныг үеэлд нь захиж үлдээдэг байсан бөгөөд тэр үеэл нь ойрхон, машин засварын газар ажилладаг байв. Өнөөдөр тэрхүү үеэлийгээ ирэх үед охин гэрээсээ гүйн гарчээ. Өмнө нь охин энэ хүүд их сайн ханддаг байсан тул ээж нь гайхаж байлаа. Тэгээд явсных нь дараа охиноо хайтал гэрийнхээ ард нуугдан уйлж байхыг олов. Охиноосоо юу болсныг асуухад юу ч хэлсэнгүй. Харин хэсэг хугацааны дараа охиныг ганцаараа байхад нь үеэл нь орж ирээд хачин сонин үйлдэл хийж, охины хөх, өгзөг зэрэг хэсгүүдэд хүрсэн тухай ээждээ хэлэв. Харин дараа нь бэлэг эрхтнээ гарган, түүнийг оролдохыг хүчилж, шаардсан байна. Тэгээд энэ тухай хүнд хэлбэл дэмий шүү гэсэн учир охин түүнийг харахаараа айдаг болсон байна.

Түүх 3. Мөнхөөгийн түүх (эрэгтэй)

Мөнхөө бол 12 настай, хотын нэгэн ресторанд 10 настайгаасаа хойш ажиллаж байгаа хүү юм. Тэрээр саяхнаас байнга ирдэг нэг үйлчлүүлэгчээс айх болсон нь өөрт нь хэтэрхий сайн хандаад байгаагаас болжээ. Тэр үргэлж хүүгээр үйлчлүүлнэ хэмээн шаардаж, бас гар утсан дээрээсээ насанд хүрэгчдэд зориулсан, бэлгийн шинжтэй зураг үзүүлдэг болжээ. Нэг орой тэр үйлчлүүлэгч хүүг харанхуй гудамж руу дагуулан явж, өөрийн бэлэг эрхтнээ гарган харуулсан байна. Эхлээд хүү гайхсан боловч хүүгээс “түүнд хүрээд үз” хэмээн шаардахад нэг л биш зүйл болоод байгааг

мэдэрч, ажил руугаа зугтан иржээ. Харин нөгөө үйлчлүүлэгч хүүд ихээхэн гарын мөнгө өгч, хүнд хэлэхгүй байхыг хүссэн аж. Дараа нь ресторанаас хүргэлтээр хоол авах захиалга өгөхдөө хүүгээр хүргүүлэхийг шаардаж, хоол авчирсан хүүг хамт хооллохыг урьжээ. Тэгээд хоол идэж байх үедээ тэрээр хүүгээс өөрийнх нь бэлэг эрхтнийг барьж, үрэхийг хүсжээ. Хүү үгэнд нь орсон боловч хэчнээн их мөнгө амласан ч ахин тэр хүний гэрт хүргэлт хийхээс татгалзах болов. Харин рестораны эзэн тухайн үйлчлүүлэгчийг “найз маань учир тэр яах ч үгүй, эрэгтэй хүмүүс ингэж тоглож л байдаг” хэмээн хүүг заавал явуулахаар шахаж, шаардах болов. Тэр одоо яавал дээр вэ?

Түүх 4. Номингийн түүх (эмэгтэй)

Номин бол 17 настай охин бөгөөд 14 настайгаасаа гэр бүлийнхээ өрийг төлөхийн тулд нэгэн баян айлд гэрийн үйлчлэгч хийх болжээ. Тэрээр эхэндээ хэчнээн хэцүү байсан ч, цалингаа өөрөө авдаггүй байсан ч ээж аавдаа тусалж, гэрийн ажил хийж байгаадаа сэтгэл хангалуун, баяртай байв. Харин одоо нэг зүйлийг нууж, шаналж явах хэрэгтэй болжээ. Гэрийн эзний хүү болох 25 настай залуу гадаадад сургуулиа төгсөөд эргэн ирж, ээж аавтайгаа амьдрах болсон цагаас хойш охиныг эргүүлдэх болж, охиныг хөөрхөн хэмээн биед нь эрээ цээргүй хүрэх болжээ. Охин энэ бүхэнд дургүйцэвч айж эмээн, аль болох түүнээс зай барихыг хичээх тусам залуу улам их эргүүлдэх болов. Хэдэн долоо хоногийн дараа залуу түүнийг биед нь иллэг хийж, долоо хоногийн хэд хэдэн өдөр бэлгийн харилцаанд орж бай хэмээн тушаажээ. Хэрэв охин үгээр нь байвал түүнд сайн хандах боловч охин дотроо өөрийгөө буруу зүйл хийж байна хэмээн шаналан, унтаж ч чадахаа болив. Харин залуу энэ тухай хэнд ч хэлж болохгүй, хэрэв хэлбэл охин чинь өөрөө намайг оролдсон хэмээн аав ээжид нь итгүүлж, ажлаас нь халж, аймаг руугаа муу нэр зүүн буцах болно хэмээн сүрдүүлжээ. Тэр одоо яавал дээр вэ?

Түүх 5. Билэгтийн түүх (эрэгтэй)

Билэгт 20 настай хүү бөгөөд тэдний гэр бүл Улаанбаатар хотод нүүн ирсэн цагаасаа барилгын талбайд аав, ээжтэйгээ хамт амьдарч ирсэн байна. 8 нас хүрээд л аавынхаа барилгын ажилд тусалж эхэлсэн бөгөөд ойлгоц удаан байна хэмээн багш нь зэмлэсэн тул сургуулиа ч хаяжээ. Гэхдээ тэрээр өсгөлүүн, чадал тэнхээтэй хүү байсан тул хүнд ачааг нааш цааш зөөх гэх мэт өөрийн хэмжээнд таарсан ажил хийх дуртай байлаа. Харин 3 сарын өмнө аав нь осолд орж, ажил хийх чадваргүй болов. Тэгээд тэд аймаг руугаа буцаж, тариалангийн талбайд ажиллах болоход барилгын компани хүүг нь үлдээж, цалинтай ажиллахыг зөвшөөрчээ. Одоо аав, ээж нь түүнд л найдаж, мөнгө олох асуудлыг даатгасан болохыг Билэгт мэдэж байлаа. Гэвч аав, ээжийг нь явангуут л амьдрал нь улам хүнд хэцүү болж эхлэв. Зарим ажилчид түүнийг шоолж, сексийн тухай, түүний биеийн галбирын тухай тоглоом шоглоом хийж эхэлжээ. Мөн шөнөөр тэдний бэлгийн дур хүслийг гүйцэлдүүлэх хэрэгтэй хэмээн тулгах болов. Билэгт харанхуй болохоор л айж эхлэх ба аав, ээж рүүгээ зугтаж очихыг хүсэх болов. Гэвч түүнийг ажилгүй болчихвол тэдэнд хэн туслах билээ дээ. Тэр одоо яавал дээр вэ?

Түүх 6. Нандингийн түүх (эмэгтэй)

Нандин 16 настай охин бөгөөд гэр бүлийн асуудлаас болоод хот руу зугтаж ирсэн байна. Эхлээд ажил олох хэцүү байсан ч нэгэн ресторанд зөөгчийн ажилд орж чаджээ. Тэрээр одоо мөнгө олж, дүү нараа сургуульд сургах боломжтой болсондоо баяртай байлаа. Зөөгчийн ажлын хувцас нь эхэндээ хэт бариу, задгай бас богино мэт санагдаж байсан ч хотын охид бүгд л иймэрхүү хувцасладаг болохоор хувцсандаа дасаж эхэлжээ. Хөдөө бол иймэрхүү хувцаславал муугаар хэлэгдэх ч энэ бол ажлын нэг хэсэг тул, бас ч гэж өөрт нь зохидог болохоор дуртайяа өмсдөг байлаа. Гэтэл нэг удаа тэднийхээр нутгийнх нь нэг эрэгтэй үйлчлүүлэхээр ирээд түүнийг таньжээ.

Байнга үйлчлүүлэх болж, охинд ч их анхаарал хандуулах болов. Удалгүй утаснаасаа бэлгийн шинжтэй зурвас бичиж, янз бүрээр дуудах болов. Охин түүнд энэ үйлдлээ зогсоо гэж хэлсэн ч улам даамжирч, олны өмнө “хөхний даруулгаа томруулж, улаан дотоож өмсөх хэрэгтэй болж” хэмээн хэлж, ичгэвтэр байдалд оруулсан байна. Бүгд охиныг шоолон инээлдэхэд охин энэ тухай менежертээ хэлж гомдол гаргав. Гэвч бэлгийн шинжтэй тоглоом наадам хийхийг хориглосон хууль байхгүйгээс хойш, бас байнгын үйлчлүүлэгч тул яаж ч чадахгүй гэсэн хариу сонсов. Үүнээс хойш ажлынхан нь түүний тухай элдвийн цуурхал тарааж, үйлчлүүлэгчид нь хүртэл түүнийг шоглох болсон тул яахаа мэдэхгүй болжээ. Тэр одоо яавал дээр вэ?



Нэмэлт мэдээлэл: Бэлгийн хүчирхийлэл

1. Бэлгийн хүчирхийлэл гэж юу вэ?

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүлээн зөвшөөрч боломгүй байдлаар бие махбод, сэтгэл санаа, бэлгийн харилцааны хувьд шаналал, хохирол учруулахуйц зан үйл, үйлдлийг хэлнэ. Бэлгийн хүчирхийлэл нь бэлгийн шинжтэй өдөөлт болон үйлдлээр нөгөө хүнийхээ халдашгүй байдлыг эвдэх оролдлого бөгөөд бэлгийн халдлага, хүчин, цус ойртолт, хүчээр биеийг нь үнэлүүлэх, мөн бэлгийн дарамт зэрэг сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрээр ч илэрдэг байна⁷.

Нэр томьёо, тодорхойлолт, журам, бодлого, шүүхийн шийдвэр улс орон бүрд бага зэрэг ялгаатай байж болох ч дараах ерөнхий ойлголтуудыг багтаасан байдаг. Үүнд:

- **Хүчин** гэдэг нь ихэнх улсын хууль тогтоомжид: бие махбодын хүчирхийллээр үйлдэгдсэн бэлгийн харилцаа эсвэл үтрээ, анус руу эр бэлэг эрхтэн, бусад эд зүйлсийг хүчээр оруулсан үйлдлийг хэлнэ хэмээн тусгасан байдаг. Ингэхээр оролдсон үйлдлийг хүчиндэх оролдлого хэмээн үздэг. Хоёроос олон хүчирхийлэгч оролцсон бол бүлэглэн хүчиндсэн хэрэг гэж үзнэ. Дайн тулааны бүс нутагт бэлгийн хүчирхийллийг дайны зэвсэг болгон ашигладаг бөгөөд ихэвчлэн охид, эмэгтэйчүүд хохирогч нь болдог байна.
- **Бэлгийн халдлага** гэдэг нь хохирогчийн хүсээгүй нөхцөлд бие махбодод нь хүрэх, бэлгийн сэдэлтэй үйлдэл хийх зэрэг орно. Гол төлөв хүчээр бэлгийн харилцаанд оруулах, бэлгийн гаж хавьталд хүчээр татан оруулах (шулуун гэдсээр болон амаар), хүүхэд хүчирхийлэх, гэр бүлийнхэнтэйгээ бэлгийн харилцаанд орохыг тулгах, хүчирхийлэхийг оролдох зэргээр илэрдэг.
- **Бэлгийн дарамт** нь хүсээгүй байхад нь тухайн хүний нэр хүндэд халдсан бэлгийн сэдэлтэй үйлдэл гаргах явдал бөгөөд бие махбодоор, үг хэлээр, үгэн бус байдлаар илэрдэг. Үүнээс ажлын байранд тохиолддог хамгийн түгээмэл хоёр төрөл нь:
 - о Сүрдүүлэг: ажлын байранд нь ямар нэгэн хөнгөлөлт үзүүлнэ хэмээн амлаж бэлгийн хавьталд орохыг шаардах (ихэвчлэн дарга, ажил олгогч, ээлжийн ахлагч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгч г.м.)
 - о Дайсагнасан ажлын байр: үг хэлээр, үгэн бус хэлбэрээр, биеийн хэлэмжээр бэлгийн өдөөлт хийж, ажлын байранд дээрэлхэж доромжилсон, дорд үзсэн, хорлонтой нөхцөл байдлыг үүсгэдэг.

Бэлгийн хүчирхийллийн олон хэлбэр бий. Ихэвчлэн жирийн тохиолдлууд мэт эхэлдэг ч ямар нэгэн арга хэмжээ авахгүй өнгөрүүлсээр байвал улам даамжирдаг.

Хэл амаар хүчирхийлэх: бэлгийн шинжтэй онигоо ярих, хүний хувийн амьдрал, гадаад төрх, биеийн галбирын талаар хүлээн зөвшөөрч боломгүй яриа өдөөх, хүйсээр нь доромжлох

Дохио зангаагаар дарамтлах: дохих, нүд ирмэх, гараар зангах, хөл, хуруу, гар, уруулаар бэлгийн сэдэлтэй хөдөлгөөн үзүүлэх

Бичгээр дарамтлах: порно зураг үзүүлэх, э-шуудан явуулах, хүсээгүй байхад нь хайрын захиа илгээх

Сэтгэл зүйн дарамт: ичгүүртэй байдалд оруулах, бусдаас тусгаарлах, хүйсээр нь ялгаварлан гадуурхах

⁷ Эх сурвалж: Another common term for sexual violence is gender-based violence. Other terms include sexual abuse and sexual exploitation.

Бие махбодын хүчирхийлэл: үнсэх, илэх, чимхэх, шалиг байдлаар биед хүрэх, бэлгийн халдлага хийх, хүчиндэх г.м.

Эдийн засгийн дарамт: ямар нэгэн тусламж үзүүлнэ хэмээн бэлгийн харилцаанд орохыг шаардах, эсэргүүцсэн тохиолдолд ажилгүй болгохоор сүрдүүлэх

Бэлгийн хүчирхийлэл нь гэр бүл, хамт олон, ажлын байр, олон нийтийн газар зэргээр хаана ч үйлдэгддэг. Бэлгийн хүчирхийлэл, дарамт үйлдэгч болон хохирогч хоёрын хооронд ихэвчлэн хүчний тэгш бус харьцаа үүсдэг. Иймээс л хохирогчдын ихэнх нь бага насны хүүхэд эсвэл эмэгтэйчүүд байдаг бол хүчирхийлэгчид нь гол төлөв хөвгүүд, эрчүүд байдаг. Хэдийгээр хүчирхийлэгч нь танихгүй гаднын хүн байх тохиолдол гардаг ч ихэнхдээ ойр дотнын гэр бүлийн гишүүн эсвэл таньдаг хүн нь хүчирхийлсэн байдаг.

Нас залуу охид бүсгүйчүүд бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртөх өндөр эрсдэлтэй байдаг нь тухайн нийгэмд тогтсон эрчүүд, хөвгүүдийн түрэмгий байдлыг өөгшүүлэн дэмждэг, охид эмэгтэйчүүдийг дуулгавартай байх хэрэгтэй хэмээн үздэг жендэрийн хэвшмэл үзэлтэй (доорх мэдээллийг харна уу) холбоотой. Ялангуяа цалин багатай, доод түвшний ажил болох гэрийн үйлчлэгч гэх мэт ажил эрхэлдэг эмэгтэйчүүд ажлын гэрээ хийж мэдэхгүй, хийсэн ч шаардлагатай заалтуудыг тусгуулж мэддэггүй тул өндөр эрсдэлтэй байдаг. Алслагдмал газар зөвхөн эрчүүдийн дунд ажилладаг (жишээ нь загасчны завь), хөвгүүдийн мэргэжлийн сургууль, шорон зэрэгт эрэгтэй хүн ч бусад эрчүүдийн хүчирхийллийн хохирогч болох явдал гардаг.

2. Дэлхий даяар гарч байгаа бэлгийн хүчирхийллийн хандлага

Гэр бүл, ажлын байр, олон нийтийн газар үйлдэгддэг бэлгийн хүчирхийлэл, дарамтын тухай найдвартай, хооронд нь харьцуулахуйц тоо баримт олоход хэцүү ч бүс нутаг, олон улс, үндэсний хэмжээнд статистикийн мэдээллийн чанар, найдвартай байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг идэвхтэй авч хэрэгжүүлсээр байна. Сүүлийн жилүүдэд НҮБ-ын харьяа байгууллагууд (тэр дундаа ДЭМБ, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага) олон улс орноос эмэгтэйчүүд, хүүхэд, зарим тохиолдолд эрэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн тухай мэдээллийг цуглуулах оролдлого хийсний дүнд дараах дүр зургийг гаргаж чадсан байна.

- Дэлхий даяар 3 эмэгтэй тутмын нэг нь (35%) амьдралынхаа аль нэг үе шатанд дор хаяж нэг удаа ойр дотнын хүн эсвэл өөр хэн нэгний зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг. Хэдийгээр бэлгийн хүчирхийллийн давтамж нь бие махбодын хүчирхийллийн давтамжаас бага байгаа боловч, дотно харилцааны үед хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд давхар өртдөг байна.
- Дэлхий дээрх хүний наймааны хохирогчдын 72% нь охид, эмэгтэйчүүд байна. Тэдний 5 эмэгтэй тутмын 4 нь, 4 охин тутмын 3 нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалагдсан байдаг.
- Дэлхий дээр 650 сая гаруй эмэгтэй 18 нас хүрээгүй байхдаа гэрлэсэн байна. Тэднээс 3 хүн тутмын нэг нь гэрлэх үедээ 15 нас хүрээгүй байсан байна. Энэ нь тэднийг маш хүнд нөхцөлд оруулдаг бөгөөд бага насны эхнэрүүд хамгаалалттай бэлгийн харилцааны тухай ярилцах боломжгүй байдгаас үүдэн эрт жирэмслэх, БЗДХ, ДОХ-ын халдварт өртөх эрсдэл өндөр болдог.
- Дэлхий дээр (11-15 насны) 3 сурагч тутмын нэг нь сургууль дээрээ үе тэнгийнхнийхээ доромжлолыг сард дор хаяж нэг удаа амсдаг ба энд хүйс огт хамаардаггүй байна.
- Дэлхий нийтээр барагцаалбал 15 сая орчим өсвөр насны охид (15-19 насны) хүчээр бэлгийн харилцаанд орсон байдаг бөгөөд ихэнх улс оронд өсвөр насны охид хамтрагч, найз хөвгүүн, нөхрийнхөө зүгээс бэлгийн халдлагад өртөх эрсдэлтэй байдаг ажээ.


3. Охид эмэгтэйчүүдийн эсрэг ойр дотнын хүрээнд үйлдэгдсэн хүчирхийлэл

Охид эмэгтэйчүүдийн эсрэг бие махбод, бэлгийн хүчирхийлэл үйлдэж буй этгээдүүд нь гол төлөв одоогийн болон өмнөх нөхөр, найз залуу, хамтрагч, гэр бүлийнх нь гишүүн байсан байна. Ингэхдээ ихэвчлэн хохирогчийг зодож, хүчирхийлж, амийг нь хөнөөсөн байна. Дэлхийн хэмжээний статистик тоог харьцуулбал:

- Хамтрагчтай эмэгтэйчүүдийн бараг 30% нь дотно хамтрагчийнхаа зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан.
- 15 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эсрэг ойр дотнын хүмүүс, мөн үл таних хүмүүсийн үйлдсэн хүчирхийллийн үзүүлэлтийн дунджийг бүс нутгаар нь харуулсан ДЭМБ-н газрын зургийг дор оруулсан байгааг үзнэ үү.

Дэлхийн 3 эмэгтэй тутмын 1 нь

дотно хамтрагч болон үл таних хүмүүсийн
зүгээс бие махбод болон бэлгийн
хүчирхийлэлд өртөж байна.



- Дэлхий дээр бусдын гарт амиа алдсан эмэгтэйчүүдийн 38% нь дотно хамтрагчийнхаа гарт хөнөөгдсөн байдаг.
- Дотно хамтрагчийнхаа болон гэр бүлийнхээ гишүүний гарт үрэгдсэн хүмүүсийн 2/3 нь эмэгтэйчүүд байна.
- Дэлхий нийтээр эмэгтэйчүүдийн 7% нь хамтрагчаасаа өөр хүний зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэх ба энэ төрлийн мэдээлэл арай хомс байдаг аж.

4. Монгол дахь хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл ба хохирогчид үзүүлэх тусламж дэмжлэг

Монгол улсад бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийн тоо харьцангуй өндөр байдаг⁸.

- Монгол эмэгтэйчүүдийн 59,7% нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны эсвэл эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байдаг.

⁸ Эх сурвалж: National Human Rights Commission, 2016 Survey “Knowledge, Attitude and Practices regarding Child Rights”; UNFPA and National Statistical Office, *Breaking the Silence for Equality: 2017 National Study on Gender-Based Violence in Mongolia*, Ulaanbaatar, 2018.

- Хамтрагчтай байсан 3 эмэгтэй тутмын нэг нь бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан.
- Эмэгтэйчүүдийн 8% нь хамтрагчийнхаа зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг.
- 10 эмэгтэй тутмын нэг нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан.
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь буюу 41% нь гэр бүлийн гишүүд, тэр дундаа төрсөн болон хойд эцэг, ах дүүс, гэр бүлийн бусад гишүүд байдаг бол найз нөхөд, танилын хүрээний хүмүүс 19%, бусад нь эрх мэдэл бүхий этгээдүүд болох цагдаа, багш, шашны зүтгэлтнүүд зэрэг хүмүүс эсвэл огт танихгүй хүмүүс байдаг байна.
- 12-18 насны 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан.

Монгол улсад бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх хангалттай дэмжлэг үгүйлэгдэж байна. Глобал сан, Эрүүл мэндийн яамны хамтарсан 2018 оны "Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ын халдварт өртөлтийн байдлыг үнэлэх" судалгаагаар:

- Судалгаанд хамрагдсан 5 хүн тутмын 4 нь (81,6%) хүчингийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөний дараа сэтгэлзүйн зохих дэмжлэг, үйлчилгээ байхгүйгээс болж сэтгэлзүйн асуудалтай тулгарсан байна.
- Ихэнх хохирогчид нь сэтгэлзүйн гэмтэл, хямралд орсон: 4 хүний 1 нь (24,3%) амиа хорлох талаар бодож байсан, 13 хүний 1 нь (7,9%) амиа хорлохоор оролдож байсан, 10 хүний 1 нь мансууруулах бодис хэрэглэж эхэлсэн байна.
- 5 хүний 3 нь энгийн амьдралдаа орж чадаагүйн улмаас орон гэргүй болсон.
- 10 хүний 7 нь байнгын эрхлэх ажилгүй болсон байна.⁹

5. Яагаад зарим эрчүүд бэлгийн хүчирхийлэл үйлддэг вэ?

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь эрэгтэйчүүд, өсвөр насны хөвгүүд байдаг. ДЭМБ-н мэдээгээр ойр дотнын хүмүүстээ хүчирхийлүүлсэн тохиолдлуудын хамгийн түгээмэл эрсдэлт хүчин зүйлс нь дараах байдлаар илэрч байна:¹⁰

- Боловсролын түвшин доогуур
- Бага насандаа өөрөө хүчирхийлүүлж, доромжлуулж байсан
- Гэр бүлийн хүчирхийллийн гэрч байсан
- Архи хэтрүүлэн хэрэглэх хорт зуршил
- Бусдаас дөлөх эмгэгтэй
- Бэлгийн олон хамтрагчтай эсвэл хамтрагчийн зүгээс харддаг
- Хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх хандлагатай
- Тухайн нийгмээрээ эрэгтэй хүнийг эмэгтэй хүнээс илүүд үздэг
- Эмэгтэйчүүд нь цалинтай ажил хийх боломж хомс байдаг
- Хоорондоо ойлголцох тал дээр хүндрэлтэй

⁹ ХНХЯ, НҮБХАС (2019) Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй

¹⁰ "Violence against women," WHO, updated November 2016, <http://www.who.int/mediacentre/factsheets/fs239/en/> (accessed 15 February 2017).

Дотно харилцаатай хамтрагчаа хүчирхийлэх тохиолдолд ямар хүчин зүйлс илүүтэй нөлөөлсөн байдаг вэ:

- Өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан
- Гэр бүлийн таагүй уур амьсгал, сэтгэл ханамжгүй байдал
- Хамтрагчид хоорондын үл ойлголцол
- Эрчүүдийн зүгээс хамтрагчаа хянах хандлага

Бэлгийн хүчирхийлэл үйлдэхэд голлон нөлөөлдөг хүчин зүйлсээс дурдвал:

- Бэлгийн харилцаанд ороогүй онгон байх нь гэр бүлийн нэр төрийг өргөдөг тухай ойлголт,
- Эрчүүд бэлгийн харилцаанд хүссэн үедээ орох эрхтэй гэх ойлголт
- Бэлгийн хүчирхийллийн эсрэг хуулийн заалтууд сул байх

Жендэрийн тэгш бус байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрсөн нийгмийн хэм хэмжээ нь эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэх хүчирхийллийн гол шалтгаан болж байдаг.

"НҮБ-Эмэгтэйчүүд" байгууллагын судалгаагаар Ази Номхон далайн бүсийн 6 оронд гарсан хүчирхийллийн үндсэн шалтгаан нь эрэгтэй хүн хүсэх л юм бол нөгөө тал хүссэн хүсээгүй секс хийх эрхтэй гэж үздэг эрэгтэйчүүдийн хандлага байдаг байна. Энэхүү хандлага нь эр хүний онцлог бол хүчтэй, хатуу чанга байдал, эсрэг хүйстнээ давамгайлж амьдрах ёстой гэх итгэл үнэмшлийг дэлгэрүүлж байдаг. Өөр бусад шалтгаанаас дурдвал, уйдсандаа хөгжилдөх гэж эсвэл уур бухимдлаасаа болж шийтгэхийн тулд гэж хариулсан байна. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч эрчүүдийн нийтлэг төрх нь багадаа таагүй нөхцөлд өссөн, сэтгэл санаагаар дарамтлуулж байсан, үл тоогдож байсан (жишээ нь олны өмнө доромжлуулж, шийтгүүлж байсан, эцэг эх нь архи дан согтуурч, үр хүүхдээ хайхардаггүй байсан г.м.), бие махбод, бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан байдаг. Багадаа туулсан эдгээр таагүй дурсамжууд нь тухайн эрэгтэйд сэтгэл гутрал, амьдралаас сэтгэл ханамж авахгүй байх, эрүүл мэндийн хувьд сул дорой байх, гэмт бүлэглэлтэй холбогдох, зодоон цохион хийх, архидах, мансуурах, зэвсэг хэрэглэх, мөнгөөр бэлгийн харилцаанд орох зэрэгт хөтөлдөг байна. Улмаар бэлгийн хүчирхийлэл үйлдэгч эрчүүдийн ихэнх нь ажилтай холбоотой стресс, дарамттай, амиа хорлох хандлагатай байдаг аж.

6. Бэлгийн хүчирхийллийг яагаад шийтгэлгүй өнгөрөөдөг вэ?

Бэлгийн хүчирхийлэл, дарамт бий болоход тухайн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүн, гэр бүл, орчин тойрны хандлага маш том үүрэг гүйцэтгэдэг. Латин Америк, Карибийн орнуудтай харьцуулахад Ази, Африк, Номхон далайн орнуудад энэ төрлийн гэр бүлийн хүчирхийлэл илүү их үйлдэгддэг нь тэнд эхнэрээ зодох явдлыг илүүтэй хүлээн зөвшөөрсөн байдагтай холбоотой. Гэхдээ хүчирхийлэлд хандах хандлага өөрчлөгдсөөр байгаа нь нааштай үзүүлэлт бөгөөд бараг ихэнх улс оронд нэг жилийн дотор энэхүү үзүүлэлт мэдэгдэхүйц өөрчлөгдөж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дунд хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх нь багассан байна.

Гэхдээ л зарим улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өндөр хэвээр байна. Жишээлбэл, 2012 онд Энэтхэгийн Шинэ Делид хэвлэгдсэн судалгааны дүнгээр бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэх эмэгтэйчүүдийн 92% нь олон нийтийн газарт, 88% нь амьдралдаа ямар нэгэн байдлаар үг хэлээр доромжлуулж, дарамтлуулж байжээ. Нэгтгээд үзвэл дараах нөхцөлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл их байх магадлал өндөр аж. Үүнд:

- Бэлгийн харилцааны асуудлыг ярих нь цээртэй
- Гэр бүлийн нэр хүнд нь эмэгтэй хүн хадамд гарахдаа онгон байхтай нягт холбоотой гэх үзэл

- Эрчүүд хүссэн үедээ бэлгийн харилцаанд орох эрхтэй гэх үзэл түгээмэл
- Бэлгийн хүчирхийллийн эсрэг хууль зүйн зохицуулалт сул

Бэлгийн харилцааны асуудал нь хориотой сэвэв байдаг орчин, нийгэмд хүмүүс бэлгийн амьдралын тухай шалиг үгс хэлэлцэх боловч үнэндээ хүүхэд ч, насанд хүрэгчид ч бэлгийн харилцааны талаар ямар ч боловсрол, мэдлэггүй байдаг. Ийм тохиолдолд бэлгийн хүчирхийлэл, дарамт нууцлагдмал байдлаар оршсоор л байдаг байна. Бэлгийн хүчирхийлэл, дарамтын хохирогчдыг эцэг эх, орчин тойрон, нийгмээрээ буруушааж, хүчирхийлэл үйлдэгчдийг харин шийтгэлгүй өнгөрөөдөг. Улмаар хамгийн байж боломгүй хэрэг болох хүүхдийн хүчирхийллийг ч чимээгүй өнгөрүүлэх нь элбэг байдаг. Зарим тохиолдолд хүчирхийллийн хохирогч нь гэр бүлийн нэр хүндээ аварч үлдэхийн тулд хүчирхийлэл үйлдэгчтэй гэрлэх ёстой гэсэн ойлголт байдаг нь түүнийг шийтгэлгүй өнгөрөөхөөр барахгүй гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө шагнаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг. Ийм нийгэмд ажлын байранд бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэн бол хохирогчийн бус тухайн ажил олгогчийн нэр хүнд илүү чухал байдаг тул гэмт хэрэгтэн бус хохирогч ажилгүй болох өндөр эрсдэлтэй.

НҮБ-ын статистик баримтаар¹¹ бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүдийн 40% хүрэхгүй хэсэг нь л бусдаас тусламж хүсдэг бөгөөд тэдний 10% нь цагдаад ханддаг байна. Энэ нь хууль хүчний байгууллагынхан бэлгийн хүчирхийллийн хохирогчдын асуудалд мэдрэмж багатай хандаж байгааг харуулж байна.

7. Хүчингийн хэргийн тухай ташаа ойлголт ба бодит баримт

Хүчингийн гэмт хэргийн тухай олон ташаа ойлголт байдаг ба хамгийн түгээмэл ташаа ойлголтыг доор жагсаалаа. Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн тоог багасгаж, хохирогчдод шаардлагатай дэмжлэг үзүүлэхийн тулд эдгээр ташаа ойлголтыг залруулах хэрэгтэй.

Ташаа ойлголт:	Хүчингийн хэрэг зөвхөн ядуусын хороололд, гэмт хэргийн үүр уурхай болсон газарт тохиолддог.
Бодит баримт:	Хүчингийн хэрэг нь олны хөлийн газар ч, хүний нүднээс ч далд, ядуу, баян ямар ч давхаргад тохиолддог.
Ташаа ойлголт:	Эмэгтэйчүүд хэт задгай хувцасласнаас болж хүчингийн хэргийн хохирогч болдог.
Бодит баримт:	Даруухан хувцасладаг эмэгтэйчүүд ч бас хүчингийн хэрэгт өртдөг. Жишээ нь хөлөөсөө толгой хүртлээ битүү хувцасладаг Мусулман эмэгтэйчүүд ч хүчирхийлүүлдэг.
Ташаа ойлголт:	Зөвхөн залуу, хөөрхөн бүсгүйчүүдийг хүчинддэг.
Бодит баримт:	Хүчингийн хэргийн хохирогч нь ямар ч хүн байж болдог, тэрбайтугай хөгшин буурал, бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч хүчингийн хохирогч болдог.
Ташаа ойлголт:	Ихэнх хүчирхийлэгчид танихгүй хүмүүс байдаг.
Бодит баримт:	Ихэнх тохиолдолд хүчирхийлэгч нь танил, дотно хүмүүс (нөхөр, найз залуу г.м.) нь байдаг.

¹¹ Эх сурвалж: https://unstats.un.org/unsd/gender/downloads/Ch6_VaW_info.pdf (accessed 5 February 2017).

Ташаа ойлголт:	Хэзээ ч бэлгийн хавьталд орж болох тул нөхөр нь эхнэрээ хүчиндэнэ гэж байхгүй.
Бодит баримт:	Гэр бүл дэх хүчин түгээмэл байдаг бөгөөд 50 гаруй оронд гэмт хэрэг хэмээн зүйлчлэгдсэн байдаг. Нөхөр, салсан нөхөр нь хүссэн цагтаа эхнэртэйгээ бэлгийн хавьталд орох эрхгүй. Хэрэв эмэгтэй нь зөвшөөрөөгүй бол нөхөр нь ч байсан хүч хэрэглэсэн бол хүчингийн хэрэгт тооцогдоно.
Ташаа ойлголт:	Хэрэв эмэгтэй нь эсэргүүцсэн бол хүчингийн хэрэг үйлдэгдэхгүй.
Бодит баримт:	Ихэнхдээ хүчирхийлэгч нь эмэгтэйгээ хүчээр давамгайлж, ямар нэгэн зэвсэг хэрэглэж, эрхэндээ оруулдаг. Буу эсвэл хутга тулгасан үед үхэхийг хүсээгүй л бол бууж өгөхөөс өөр аргагүй.
Ташаа ойлголт:	Эрэгтэй хүнийг хүчинддэггүй.
Бодит баримт:	Охид эмэгтэйчүүдэд тохиолддог шиг их биш ч хөвгүүд, эрэгтэйчүүд хүчиндүүлэх нь бий (ихэнхдээ өөр эрэгтэйд хүчиндүүлдэг).
Ташаа ойлголт:	Эрчүүд бэлгийн дур хүсэл ихтэй тул өөрийгөө хянаж чаддаггүй.
Бодит баримт:	Зарим эрчүүд л хүчин хийдэг болохоос ихэнх эрчүүд хүчирхийлэлгүйгээр бэлгийн таашаал авдаг. Хэн нэгэнд таагүй үйлдэл гаргасныгаа өөрийн бэлгийн дур хүслээ барьж чадалгүй хохирогч боллоо гэх нь үнэмшилгүй шалтаг юм. Бэлгийн дарамт, хүчирхийлэл нь бэлгийн дур хүсэл гэхээсээ илүүтэй хүч чадлаа буруугаар ашиглахтай холбоотой гэмт хэрэг юм. Энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биологийн ялгаатай огт хамаагүй, харин ч бэлгийн харилцааны талаарх хүчирхийлэгчийн алдаатай буруу ойлголт, хандлагатай холбоотой юм.

8. Бэлгийн хүчирхийллийн үр дагавар

Бэлгийн хүчирхийлэл, дарамт нь хохирогчийн хувьд ямагт сөрөг үр дагавартай байхын хамт түүний гэр бүл, хамт олон, нийгэмд ч хор хохирол учруулдаг.

Хохирогчийн хувьд:

- Сэтгэл санаа, сэтгэл зүй нь тогтворгүй болж, ичих, гутрах, өөрийгөө дорд үзэх, сэтгэлээр унах, айж эмээх байдалд ордог
- Бие махбодын хувьд гэмтэж бэртэх, БЗДХ, ХДХВ зэрэг өвчний халдвар авах, хүсээгүй жирэмслэх (үр хөндүүлж байгаа эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь хамтрагчийнхаа зүгээс бие махбод, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг ба ХДХВ-ын халдвар авах эрсдэл жирийн эмэгтэйчүүдээс 1.5 дахин өндөр, мөн зулбах, амьгүй төрөх, дутуу төрөх, бага жинтэй нярай төрөх г.м. олон эрсдэл учирдаг)¹²
- Сэтгэцийн эрүүл мэндээрээ хохирч, сэтгэл гутрал, стресст автах, нойргүйдэх, хоолны дуршил өөрчлөгдөх, амиа хорлох оролдлого хийх зэрэг байдалд ордог
- Гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүстэй харилцах харилцаанд асуудал бэрхшээл үүсэх зэргээр хувийн амьдралд нь сөргөөр нөлөөлдөг

¹² Эх сурвалж: World Health Organization, <http://www.who.int/mediacentre/factsheets/fs239/en/> (accessed 5 February 2017).

- Ажлын байран дээрээ бүтээмж нь буурч, ажил таслах, өвчний чөлөө авах, ажилдаа дурсонирхолгүй болох зэрэг асуудал гардаг

Гэр бүл болон бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд:

- Бэлгийн хүчирхийлэлд өртөх нь хүүхдийн сэтгэл зүй, бие махбод, нийгэмшилд маш сөргөөр нөлөөлдөг. Улмаар согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, эрсдэлтэй бэлгийн хавьталд орох, өөрөө ирээдүйд хүчирхийлэл үйлдэгч болох зэрэг эрсдэл учирдаг
- Бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан хөвгүүд том болоод өөрсдөө охид, хүүхдийг хүчирхийлэгч болсон байх нь элбэг. Харин охидын хувьд насанд хүрсэн ч бэлгийн хүчирхийллийн хохирогч болсоор байдаг.
- Хүчирхийлэл байнга гардаг гэр бүлд өссөн хүүхэд зан үйл, сэтгэл зүйн хувьд тогтворгүй болж, насанд хүрээд өөрсдөө хүчирхийлэл үйлдэгчид болох нь элбэг.
- Дотно хүнийхээ хүчирхийлэлд өртөх нь нярай болон бага насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан болох нь түгээмэл (суулгах өвчин, тэжээлийн дутагдал зэргээс болж).

Аж ахуйн нэгжүүдийн хувьд:

- Сэтгэл гутралд орсон ажилчны бүтээмж муудаж, компани алдагдалд орно
- Олон нийтийн дунд компаний нэр хүнд унана, мөнгөн торгууль төлнө, шүүхэд дуудагдана
- Эрүүл бус, найрсаг бус нөхцөлд ажилчид өөриймсөг сэтгэлээсээ хандахгүй

Нийгмийн хувьд:

- Охид хөвгүүд, эрчүүд, бүсгүйчүүдийн хувьд чадварлаг, өөртөө итгэлтэй байдал нь үгүй болно.
- Бэлгийн хүчирхийлэл нь нийгэм дэх итгэлцлийг үгүй хийж, бие биеэ үгүйсгэсэн, хардсан, айсан, хүндэтгэлгүй байдал газар авна
- Нийгэм-соёлын уламжлал, жендэрийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн хувьд сөрөг өөрчлөлт гарна

9. Бэлгийн хүчирхийллийн эсрэг алхмууд

Насанд хүрэгчидтэй харьцуулахад 18 нас хүрээгүй хүүхэд, залуучууд бэлгийн хүчирхийллийн эсрэг өөрсдөө биеэ хамгаалах чадвар сул байдаг тул хүүхэд бүрийг бэлгийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалах хэрэгтэй. Нас бага байх тусам яг юу болоод байгааг ойлгох чадвар хараахан суугаагүй байдаг тул эхэндээ өөрт нь илүү анхаарал тавьж, бэлэг сэлт өгсөн хүнд татагддаг ч ихэнх хүүхэд нэг л биш байгааг мэдэрдэг. Хэрэв энэ байдал олон давтагдвал хүүхэд хүсээгүй зүйлдээ "үгүй" гэж хэлж чадахгүй, хэлснийг нь үг дуугүй дагаж байгаагаасаа болж айж, дотогшоо нуугдаж, сэтгэл гутралд орох нь элбэг. Зарим нь энэ бүхэн өөрийнх нь буруугаас болж байгаа мэт санаж, хувь заяа түүнийг шийтгэж байна хэмээн хүлээн авдаг. Гэр бүлийнх нь орчинд бэлгийн хүчирхийлэл дарамт байгаа тохиолдолд ээжийгээ, дүү нараа хамгаалахыг хүсэж, өөрөө дотроо шаналдаг.

Эдгээр асуудлыг гарган ирж, нээлттэй ярилцах нь хамгийн чухал. Асуудлыг нуун дарагдуулж, өөгшүүлснээр байдлыг бүр дордуулж, хохирогчийн ажил амьдралд улам сөргөөр нөлөөлөх тул түүнийг зоригтойгоор дэлгэн тавьж, эсрэг арга хэмжээ авах хэрэгтэй. Үйлдэж байгаа хэргийнх нь талаар хүн бүр мэдэж байгаа, гэр бүл, сургууль, албан газар, нийгэмд ийм хэргийг хэн ч хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг мэдсэн цагт л бэлгийн хүчирхийлэл дарамт үйлдэгч ахин хүчирхийлэл үйлдэхээ зогсооно. Иймд насанд хүрэгчдийн зүгээс хүүхдүүдийг хохирогч болохоос урьдчилан сэргийлж, хүчирхийлэгчийг зогсоох талаар дорвитой алхам хийж, шаардлагатай бол дараа дараагийн алхмууд байгааг хүчирхийлэгчид сануулах хэрэгтэй.

Хэрэв чи бэлгийн хүчирхийлэлд өртвөл яах вэ:

- Амь насанд чинь аюул заналхийлээгүй бол “Үгүй” хэмээн хэлж, өөрт чинь таалагдахгүй байгааг тодорхой ойлгуул. Хэрэв чи үгүй гэхгүй бол байдал улам хүндрэх болно. Хүлцэн тэвчихэд хэцүү нөхцөл байдлаас аль болох түргэн холдон зугтах хэрэгтэй.
- Энэ бүхэнд өөрийгөө буруутгах хэрэггүй, зөвхөн чиний хувийн асуудал гэж бодож болохгүй.
- Найз нөхөд, эцэг эх, багш, хөрш, хамтран ажиллагч гээд итгэж болох өөр хэн нэгэнтэй зөвлөлдөж, ямар нэгэн арга гарц хайх хэрэгтэй.
- Чамтай адил бэлгийн хүчирхийлэл, дарамтын хохирогч болсон өөр хүн байгаа эсэхийг олж мэд.
- Бэлгийн халдлага, хүчин бол эрүүгийн гэмт хэрэг. Тусламж хүсэж, гомдол гаргаж, буруутанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх хэрэгтэй.

Хэрэв та гэр бүл, ажлын байр, орчин тойронд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэрч болсон бол:

- Хүүхэд залуучууд өөрсдийгөө хамгаалах чадвар сул байдаг учир насанд хүрэгчид тэднийг бэлгийн хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах үүрэгтэй.
- Бэлгийн хүчирхийлэл нь хүний эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа хэрэг бөгөөд хохирогч, түүний гэр бүл, орчин тойрон, сургууль, ажлын байр зэрэг эргэн тойронд бүхэлд нь хор уршиг тарьж байдгийг ойлгох хэрэгтэй.
- Асуудлыг тоохгүй орхиж болохгүй. Орчин тойрон, хамт олонтойгоо нэгдэн мэдлэг мэдээлэл түгээж, бэлгийн хүчирхийллийн эсрэг “Үүнийг бид огт тэвчихгүй” гэх хөдөлгөөн өрнүүлж болно.
- “Үгүй” гэж хэлэх эрхтэйгээ ч мэдэхгүй бага насны хүүхэд бэлгийн хүчирхийлэл, дарамтын хохирогч болсон байвал онцгойлон анхаарч, хамгаалах хэрэгтэй.
- Хүчирхийллийг зогсоох ямар нэгэн арга олж, хэлээд ч үг авахгүй тохиолдолд шударга ёс тогтоох арга зам руу хөтөлж өгөх хэрэгтэй.
- Хохирогчид шаардлагатай үед нь сэтгэл санааны болон материаллаг тусламж үзүүлэх хэрэгтэй.
- Бэлгийн хүчирхийлэл нь гэмт хэргийн чанартай байдаг тул гэмтнийг заавал шийтгэх хэрэгтэй. Хүчирхийлэгчийг зохисгүй үйлдлээ зогсоохыг анхааруулж, шаардах хэрэгтэй. Тэд өөрсдөө ч ямар нэгэн байдлаар хэн нэгнээс зөвлөгөө авах шаардлагатай байж мэдэх юм.

Хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалахын тулд нийгэмд юу хийх шаардлагатай байна вэ?

Иргэншсэн улс бүр өөрсдийн нутаг дэвсгэртээ амьдарч байгаа хүмүүсийг эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу гэж ялгалгүй бүгдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй. Төр засаг нь иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хууль зүйн, бодлогын хүрээнд хүчирхийллийн энэ хэлбэрээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, гэмтнийг шийтгэх бодит алхмуудыг дараах байдлаар авч хэрэгжүүлж болно:

- Гэр бүлийн гишүүн бүрд, хүүхэд, эцэг эхчүүдэд зориулан, мөн ажлын байр, сургуулийн орчинд бэлгийн хүчирхийлэл дарамт үүсэхэд “Үгүй” гэж хэлэх мэдлэг чадвартай болгох нөлөөллийн ажлын идэвхжүүлэх.
- Хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөг, охид эмэгтэйчүүдийг дорд үздэг нийгмийн гаж хандлагыг өөрчлөх. Хүчирхийлэл үйлдэхгүйгээр эр хүн хэмээн хүлээн зөвшөөрөгдөж болдог, хүйсийн тэгш эрх гэж юу байдаг, охид эмэгтэйчүүдийг хүндлэх зэргийг хөвгүүд, эрэгтэйчүүдэд хэлж өгөх хэрэгтэй. Мөн эмэгтэйчүүдийг хүйсийн тэгш эрхийн талаар, харилцааны ур чадвар, хамт

олонд түшиглэсэн амьжиргааны арга барил зэрэг сургалтад хамруулж, нийгэм эдийн засгийн хувьд чадавхжуулах хэрэгтэй.

- Хүүхдийн хүчирхийллийг онцгойлон анхаарч, хүүхэд хүчирхийллээс ангид, эрүүл гэр бүлд өсөж торнихын чухлыг бүгдэд ойлгуулах
- Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалахын тулд гэр бүл, сургуульд хүүхдүүдэд багаас нь бэлгийн боловсрол олгох хэрэгтэй. Эрчүүд, хөвгүүдэд аль болох эртнээс хүчирхийллийн хор уршгийн талаар мэдээлэл өгч, эрэгтэй хүн хүссэн үедээ бэлгийн хавьталд орох эрхтэй гэх буруу үзлийг няцаах хэрэгтэй. Мөн үүний хажуугаар охид эмэгтэйчүүдэд хандсан, эдийн засаг, нийгэм, бэлгийн харилцааны тал дээр тэдний өөртөө итгэлтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлийн ажлууд хэрэгжүүлэх шаардлагатай.
- Бүхий л насны хүмүүст бэлгийн хүчирхийллийг эсэргүүцэх, хохирогчийг хамгаалах шаардлага гардгийг тайлбарлан ойлгуулах арга хэмжээ чухал. Ялангуяа багш нар, цагдаагийн ажилтнууд бэлгийн хүчирхийллийн талаар, өөрсдийн үүрэг хариуцлагын талаар мэдлэг мэдээлэлтэй байж, нөхцөл байдалд тохирсон арга хэмжээг шийдэмгий авч, хохирогчийг хамгаалж, хүчирхийлэгчийг шийтгэх тал дээр тууштай ажиллах хэрэгтэй.
- Шаардлагатай хууль эрхзүйн орчныг бүрдүүлэхдээ бодлого журмуудыг боловсруулан батлахаас гадна хэрэгжүүлэх арга хэмжээнд ач холбогдол өгч, хохирогчдыг хамгаалах газруудыг байгуулж, зөвлөгөө өгөхөд бэлтгэгдсэн боловсон хүчнээр хангаснаар тэсвэрлэшгүй нөхцөлд орсон хохирогчдод тусламж үзүүлэх боломж бүрдэнэ.
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийг өөгшүүлж, давраахаа зогсоох хэрэгтэй. Үйлдсэн хэргийнх нь онцлогт тохирсон шударга шийтгэлийг оноож байх нь хамгаас чухал.

10. Хүчин болон бэлгийн халдлагын эсрэг авах арга хэмжээ¹³

Хүчин болон бэлгийн халдлага нь гол төлөв гэр бүлийн хүрээнд, эхнэр нөхрийн хооронд, өвөө болон ач зээ нарын дунд, ах эгч дүү нар, авга нагац, үеэлүүдийн хооронд болох нь элбэг байдаг. Мөн, хөршүүд, хамт олон, хамтран ажиллагчид, удирдлагууд, үйлчлүүлэгчийн зүгээс ирэх нь ч бий. Ийм тохиолдолд өөрт тохиолдсон зүйлээ бусдад дэлгэх нь мэдээж хэцүү ч зориглож хөдлөх нь чухал. Ихэнх тохиолдолд гэр бүл, ойр орчныхон нь “чиний буруу” гэж хохирогчид ханддаг тул хүчирхийлэлд өртсөн хэн ч бай (заримдаа эрэгтэй хүмүүс ч бас хохирогч болдог) маш хүнд хэцүү байдалд ордог. Гэхдээ энэ нь үнэхээр шударга бус хэрэг. Энэ бүхнээс болоод хохирогч хэнээс ч тусламж эрэх хүсэлгүй, бас чадваргүй болж, сэтгэл санааны хүнд дарамтад ордог. Иймд гэр бүлийнхэн, найз нөхөд, орчин тойрных нь хүмүүс хохирогчийг буруутгаж шүүмжлэхээсээ өмнө хүчирхийлэгчийг шийтгэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Хэрэв ийм зүйл болбол:

- Олон нийтийн газар гардаг хүчингийн хэргүүд ихэнхдээ нэг буюу түүнээс олон эрэгтэй нийлэн хохирогчийг эрхэндээ оруулж, баригдана гэж айлгүй өөрсдийн хүссэнийг хийх боломжтой газарт аваачиж үйлдэгддэг.
- Хэрэв ийм тохиолдол гарвал аль болох эсэргүүцлээ ил тодоор илэрхийлэх хэрэгтэй. Хүчтэй эсэргүүцэл үзүүлэх нь хүчирхийлэгчдийн хувьд айдас төрүүлнэ, эсэргүүцлийг дарахад цаг хүч орох болно гэдгийг ойлгоод хүчирхийлэх санаархлаа орхиж болно. Та тэднийг улам уурлуулж, өөрөө илүү гэмтэж магадгүй хэмээн эмээж болох ч хүчирхийлэгчид чимээгүй хүлцэн тэвчдэг эмэгтэйчүүдийг илүү онилдог. Учир нь дараа нь ямар нэгэн хэл ам гарахгүй гэж найддаг.

¹³ Эх сурвалж:: *WWRGE Manual – Cambodia* by Rosalinda Terhorst et al (ILO: Bangkok, 2004), Exercise: 4.17 Rape, pp. 118-121.

- Гартаа шүхэр эсвэл бие хамгаалах зэвсэг болохуйц ямар нэгэн зүйл барьж яваа эмэгтэйд тэд халддаггүй. Хэрэв хэн нэгэн чам руу ойртож байгааг харвал “Зогс, холд” хэмээн хашхирч, зэвсэг болохуйц зүйл олж барь. Ингэснээрээ өөрийгөө хамгаалах, халдлагыг эсэргүүцэх чадвартайгаа илэрхийлж, халдагчийг буцаах боломжтой.
- Машины зогсоол эсвэл гудамд хэн нэгэн өөрийг чинь дагаж байгаа мэдрэмж төрвөл эсвэл цахилгаан шатан дотор, шатаар өгсөх зуур тааралдвал биеэ хамгаалахын тулд нүүр рүү нь эгцлэн харж асуулт тавих хэрэгтэй. Нэгэнт нүүр царайг нь харсан тул ахин хараад таних болно. Ингэснээр хүчирхийлэх сэдлийг нь унтраах боломжтой.
- Хутга мэс тулган эсвэл бүлэглэн дайрч амь насанд заналхийлж байгаа тохиолдолд эсэргүүцэх нь ухаалаг алхам биш. Ийм тохиолдолд бараг сонголт үлдэхгүй. Эсэргүүцэх тусам хүчирхийлэгчид улам улайрдаг. Иймд аль болох хүлцэнгүй байх нь тэдэнд уйтгартай санагдана. Аль болох чимээгүй, хурдан зугтахыг хичээ.

Хүчиндүүлсний дараа яах вэ:

Хэдийгээр хүчиндэгчийн буруу байдаг ч хүчиндүүлсний дараа хохирогч эмэгтэйг өөрийнхөө буруугаас ийм байдалд орсон гэж буруутгадаг тул бусад хүмүүстэй харилцахад хэцүү байдаг. Иймд олон эмэгтэй буруутгагдахаас эмээж, гэр бүлийнх нь нэр сүр унана гэж боддогоос хүчиндүүлсэн тухайгаа цагдаад болон эрх мэдэл бүхий этгээдэд мэдэгдэх дургүй байдаг. Заримдаа гэрийнхэн нь болсон явдлын хариуд мөнгө авч энэ талаар цагдаад хэлэлгүй өнгөрдөг. Гэвч энэ нь хохирогчийн хувьд бүх л амьдралынхаа туршид тээж явах хүнд ачаа болон үлддэг. Хохирогч цагдаад мэдүүлэлгүй өнгөрөх юм бол хүчиндэгч этгээд айх зүйлгүйгээр дараагийн эмэгтэйг золиос болгон хүчирхийлж, гэмт үйлдлээ давтсаар байх болно. Эмэгтэйчүүд хүчингийн хэргийн талаар мэдэгдэлгүй өнгөрөөх нь ийм хэрэгт ач холбогдол өгөлгүй хүлээн зөвшөөрсөн мэт болно. Иймд хүмүүс хохирогчийг дэмжин тусалж, хүчирхийлэгчийг шийтгэхийг шаардах ёстой.

Хүчиндсэн гэдгийг нотлох нь хамгийн чухал

Даруй цагдаад мэдэгдэн, эмчид үзүүлж, бүрэн шинжилгээ хийлгэх хэрэгтэй. Тусалж дэмжих итгэлтэй нэгнийг дагуулж яваарай. Эмнэлгийн дүгнэлтийн нэг хувийг өөртөө авах хэрэгтэй. Цагдаагийн газар болон эмнэлэгт очихоосоо өмнө биеэ болон хувцсаа угааж болохгүй. Угаавал нотлох баримт алга болно.

Эмнэлэгт үзүүлсний дараа шууд цагдаа руу явах ёстой. Урагдсан хувцас зэрэг нотлох баримтыг устгаж болохгүй. Мэдүүлгийг хэрэгт бүртгэж авахыг хүсэх хэрэгтэй. Учир нь заримдаа хүчингийн хэргийг эрүүгийн хэрэг болгон бүртгэж авахгүй, шийтгэл оноохгүй үлдээх нь тохиолддог. Цагдаагийн газраас өгсөн мэдүүлгийн нэг хувийг авах хэрэгтэй.

Цагдаагийн газар болон эмнэлэг рүү ганцаараа явах нь зөв санаа биш. Найзыгаа эсвэл бүр найз нараа дагуулж очих нь тун чухал, учир нь тэд танд сэтгэлийн дэм өгнө, зоригжуулна, айдсаа дарахад тусална. Хэргийн ул мөр алга болохоос өмнө эмнэлэг, цагдаа руу яаралтай очих хэрэгтэй.

Бэрхшээлүүд

Гэмт хэрэгтнүүд ихэнхдээ өөрсдийн давуу талыг ашиглаж, хүч чадлаар дорой, өөрийнхөө эрхшээлд байдаг хэн нэгнийг хүчинддэг. Нас залуу, доогуур албан тушаалд ажилладаг, баталгаатай ажлын байраар хангагдаагүй, өөрийнхөө эрхийг хамгаалах чадваргүй эмэгтэйчүүд хүчинд өртөх нь элбэг. Тухайлбал олон эмэгтэйчүүд ажил олгогч болон менежертээ, сурагчид багшдаа, хөдөө орон нутгаас ирсэн охид, эмэгтэйчүүд ажил олгодог агентлагийн ажилтанд хүчиндүүлэх нь бий. Хүчирхийлэгч ихэнхдээ хохирогчийн боловсролын түвшин, амьдралын туршлага, нийгмийн байр суурь зэргийг харгалзан дорой буурай байдлыг нь далимдуулдаг.

Хуулийн хүрээнд энэ төрлийн хүчирхийллийг авч үзэхэд дараах бэрхшээл учирдаг. Үүнд:

- Албан тушаалтнууд бэлгийн хүчирхийлэлд нухацтай ханддаггүй
- Албан тушаалтнууд бэлгийн хүчирхийлэлтэй холбогдолтой хэргийг түргэн хаахыг хүсдэг.
- Эмнэлгийн нотолгоо тун чухал боловч заримдаа эмнэлгийн ажилтнууд хэрэг дээр хамтран ажиллахыг, шүүх хурал дээр гэрчээр оролцохыг хүсдэггүй.

Хэдий ийм ч бүх л улс оронд, ямар ч нөхцөлд хохирогчид туслахад бэлэн хүмүүс, байгууллагууд байдаг. Тэдгээр байгууллагуудыг олж, холбоо тогтоон, тусламж авах нь танд хэрэгтэй төдийгүй ирээдүйн хохирогчдыг хамгаалахад маш чухал. Учир нь хүчирхийллийг зогсоох хэрэгтэй.

Дасгал 8.1.5 Бэлгийн хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?



Зорилго

- Бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийг мэдэж авах
- Бэлгийн хүчирхийллийн үр дагаврыг ойлгох
- Бэлгийн хүчирхийллээс сэргийлэх арга замуудтай танилцах
- Хүчингийн гэмт хэрэг болон бэлгийн халдлагыг мэдээлэхдээ юу хийх ёстой тухай мэдэж авах



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

90-105 минут



Суудал зохион байгуулалт

4 баг болон хуваагдан сууна



Ашиглах материал

- Самбарын цаас, самбарын үзэг, 2 скоч
- Самбарын цаасаар 4 том зүрх хайчилна, баг бүрд нэг зүрх.



Сургалтын хэрэглэгдэхүүн

8.1.5 А: Бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлж, хэрхэн даван туулах вэ?

Нэмэлт мэдээлэл: Бэлгийн хүчирхийлэл (8.1.4 Бэлгийн хүчирхийлэл)



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Энэ дасгал Дасгал 8.1.4.-н үргэлжлэл бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй эсвэл өртсөн хүүхэд, залуу бүсгүйчүүд, эрэгтэйчүүдэд бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлэх, өртсөн тохиолдолд хэрхэн тусламж үйчилгээ авахад нь туслах зорилготой дасгал юм. Мөн өөрийгөө хамгаалж чадахгүй хүүхэд залуучуудыг бэлгийн хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй эцэг эх, насанд хүрэгчдэд зориулсан болно.



Сургалт зохион байгуулах алхмууд¹⁴

1. Багийн ажил: Бэлгийн хүчирхийллийн ямар хэлбэрүүд байдаг вэ? – 15-30 минут
2. Бэлгийн хүчирхийллийн үр дагавар – 15 минут
3. Багийн ажил: Бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлэх вэ? – 20 минут
4. Бэлгийн хүчирхийлэлд өртвөл яах вэ? – 15 минут
5. Орон нутаг, олон нийтийн зүгээс бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлж, хохирогчид хэрхэн туслах вэ? – 20 минут
6. Дүгнэлт - 5 минут

Алхам 1. Багийн ажил: Бэлгийн хүчирхийллийн ямар хэлбэрүүд байдаг вэ? – 15-30 минут

Энэхүү дасгалаар бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүд болох хүчин, халдлага, дарамт гэж юу болох тухай, эдгээрээс хэрхэн сэргийлэх тухай тайлбарлана гэдгийг оролцогчдод хэлнэ.

- Оролцогчдыг 4 баг болгон хуваан баг бүрд самбарын цаас, самбарын үзэг өгнө.
- Санаа цуглуулах аргыг ашиглан хүчин, бэлгийн халдлага, дарамтын тодорхойлолтыг гаргахад 3 минут өгнө (Дасгал 8.1.4 - ийн үеэр ярилцсан тухайгаа сануулж, эргэн санахыг зөвлөнө).
- Оролцогчдоос өөрсдийн тодорхойлолтуудаа самбарын цаасан дээр бичиж эсвэл зурахыг хүснэ.
- Бүх багийн тодорхойлолтуудыг ханан дээр наан гаргасан тодорхойлолтуудын талаар ярилцана.
- Хүчин, бэлгийн халдлага, дарамтын талаар тайлбарлаж өгнө.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Энэ дасгалаар багууд өөрсдийн гаргасан тодорхойлолтоо зурах, бичих эсвэл дүрд тоглох зэргээр ямар ч байдлаар илэрхийлж болно. Уян хатан байж, бүтээлч хандлагыг дэмжээрэй.

Алхам 2. Бэлгийн хүчирхийллийн үр дагавар – 15 минут

Оролцогчдод зүрхэн хэлбэртэй цаас харуулна.

- Хүчиндүүлсэн хүний зүрх ямар болдгийг мэдэх үү хэмээн асууна. Энэхүү эмтэрсэн зүрх нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүний зүрхийг төлөөлж байгаа болохыг тайлбарлана.
- Баг бүрд нэг нэг зүрх өгнө. Зүрхийг хэсгүүд болгон ураад зүрхний тасархай бүр дээр хохирогчийн насан туршид хадгалж явах зовлон шаналлыг бичнэ. Дараах санааг чиглэл болгон хэлж өгнө. Үүнд:
 - o Өөрийн үнэлэмж
 - o Эрүүл мэнд
 - o Бусадтай харилцах
 - o Амьдралын зорилго

¹⁴ Friends Tell Friends on the Streets by Greg Carl & Nonthathorn Chaiphech (Thai Red Cross AIDS Research Centre: Bangkok, 2000), Exercises: Hello... Help me and Heart Asunder, p. F-4 & F-10.

Багуудыг эмтэрсэн зүрхээ бэлтгэхэд зориулж 10 минут өгнө. Энэ хооронд сургагч багш самбарын 4 цаасан дээр Өөрийн үнэлэмж, Эрүүл мэнд, Бусадтай харилцах, Амьдралын зорилго гэж тус тус бичээд бүгдэд харагдахаар байрлуулна. Багуудыг бэлэн болмогц эмтэрсэн зүрхний хэсгүүдээ энэ 4 гарчгийн дор харгалзуулан байрлуулахыг хүснэ. Баг бүрийг самбарын нэг цаасан дээрх үр дүнг танилцуулахыг санал болгоно. Багийн ажлын үр дүнд дутуу санааг нэмнэ (Дасгал 8.1.4-н Бэлгийн хүчирхийлэл нэмэлт мэдээллийн 8-р хэсгийг харна уу).

Хариултын зарим хувилбарууд:

- Өөрийн үнэлэмж: ичих, өөрийгөө буруутгах, хамгаалалтгүй, хөөрхийлөлтэй, бузар болсон мэт санагдах
- Эрүүл мэнд: БЗДХ/ХДХВ-ын халдвар авах, жирэмсэн болох, сэтгэл гутрах, амиа хорлох бодол төрөх зэргээр сэтгэцэд өөрчлөлт орох
- Бусадтай харилцах: хүмүүс хохирогчийг буруутгадаг, бусдад хэлэхээс айх, хүнтэй болзоход хүндрэл гарах, гадуурхагдах
- Амьдралын зорилго: сургуульд явахаа болих (жишээлбэл жирэмсэн болсноос), ажил сургуульдаа анхаарал тавьж чадахгүй болох, сэтгэл гутралын улмаас амьдралын хэв маяг өөрчлөгдөх, өөрийгөө доогуур үнэлэх, бусдад болон ирээдүйдээ итгэхээ болих

Алхам 3. Багийн ажил: Бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлэх вэ? – 20 минут

Оролцогчдыг өмнөх 4 багаар ажиллахыг хүснэ.

- “Бусдыг, тэр дундаа хүүхдийг хүчирхийлдэг хүмүүс ямар хүмүүс байдаг вэ?” гэсэн асуултаар хэлэлцүүлгийг эхэлнэ.
- Зарим нэг хариултыг сонссоны дараа хүчирхийлэгч нь танихгүй хүн байж болдог ч, таньдаг мэддэг хүмүүс нь, тэр дундаа гэр бүлийн гишүүд, садан төрлийн хүмүүс, найз, танил хүн нь хүчирхийлэх тохиолдол байдгийг тайлбарлана.
- Хоёр багийг танихгүй хүнд хүчирхийлүүлэхээс хэрхэн сэргийлэх тухай ярилцахыг хүсээд, нөгөө хоёр багаас нь таньдаг хүнийхээ хүчирхийлэл, халдлагад өртөхөөс хэрхэн сэргийлэх талаар ярилцахыг хүснэ. Асуултаа хэлэлцэж, хариултаа тэмдэглэхэд 10 минутын хугацаа өгнө.
- Хоёр самбарын цаас бэлдээд, нэг дээр нь “Танихгүй хүнд хүчирхийлүүлэхээс хэрхэн сэргийлэх вэ”, нөгөө дээр нь “Таньдаг хүндээ хүчирхийлүүлэхээс хэрхэн сэргийлэх вэ” хэмээн бичнэ.
- Багууд тус тусын хариултуудаа самбарын цаасан дээр жагсаан бичээд, дүгнэн ярилцана.
- Шаардлагатай бол холбогдох мэдээллийг нэмж болно (Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.5-аас нэмэлт мэдээлэл авна уу)
- Эмэгтэйн өмссөн хувцас, биеэ авч явах байдал үүнд хамаагүй болохыг анхааруулна.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Зарим багаас эмэгтэйчүүдийн хувцаслалтыг (тодорхой арга хэмжээ эсвэл тухайн нөхцөл байдалдаа тохируулан хувцаслах) бэлгийн хүчирхийллээс сэргийлэх нэг арга гэж үзэж болно. Ихэнх соёлд тодорхой арга хэмжээ эсвэл тухайн нөхцөл байдалдаа тохируулан хувцаслах нь түгээмэл болохыг тайлбарлаарай. Гэхдээ даруухан хувцасласнаараа бэлгийн хүчирхийллээс сэргийлэх боломжгүй. Тэр ч бүү хэл хөгшин эмээ, нялх хүүхэд, нүдээ далдартал битүү хувцасласан лалын шашинт эмэгтэйчүүд ч

хүчирхийлэлд өртдөг учир эрэгтэй хүн хувцаслалтаас нь болж хүчиндэх сэдэл төрсөн гэж шалтаглаж болохгүй, хүний эрхэд бүдүүлгээр халдах, хэн нэгнийг хүчирхийлэх эрх хэнд ч байхгүй (Дасгал 8.1.4 Нэмэлт мэдээлэл: Бэлгийн хүчирхийлэл, 4, 5, 6, 7-р хэсгүүдийг харна уу).

Алхам 4. Бэлгийн хүчирхийлэлд өртвөл яах вэ? – 15 минут

Бүгд хамтдаа дараах асуултын дагуу ярилцана:

- Хэн нэгэн бэлгийн хүчирхийлэлд өртөх гол хүчин зүйлс юу байж болох вэ?
- Хүчиндүүлсэн хүн бэлгийн хүчирхийллийг өөрөө хүссэн байж болох уу? Яагаад?
- Чи өөрийгөө ийм зүйл тохиолдох эрсдэлд байна гэж боддог уу? Яагаад?
- Бэлгийн хүчирхийллээс сэргийлэхийн тулд юу хийж чадах вэ?
- Хэрэв чамд ийм зүйл тохиолдвол чи яах вэ?
- Хэрэв ойр дотнын нэгэнд чинь ийм зүйл тохиолдвол чи яах вэ?
- Гуравдах самбарын цаасан дээр "Бэлгийн хүчирхийлэлд өртвөл яах вэ?" хэмээн бичнэ.
- Оролцогчдыг санаа бодлоо хуваалцахыг хүснэ.
- Оролцогчдын санааг бичиж, товч тайлбар өгнө (Дасгал 8.1.5 А, мөн Дасгал 8.1.4-т байх Нэмэлт мэдээлэл: Бэлгийн хүчирхийлэл, 7, 9-р хэсгүүдийг харна уу).

Алхам 5. Орон нутаг, олон нийтийн зүгээс бэлгийн хүчирхийллээс хэрхэн сэргийлж, хохирогчид хэрхэн туслах вэ? – 20 минут

Бүгд хамтдаа дараах асуултын дагуу ярилцана:

- Хэн нэгнийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай сонсоод хүмүүс ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ?
- Ийм хариу үйлдэлтэй та санал нийлэх үү? Яагаад?
- Хэрэв танд ийм зүйл тохиолдсон бол ямар санагдах бол?
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүнд гэр бүл, найз нөхдийн зүгээс туслахын тулд юу хийх хэрэгтэй вэ?
- Хохирогчид туслах, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд орон нутаг, олон нийтийн зүгээс ямар арга хэмжээ авах ёстой вэ?
- Дөрөв дэх самбарын цаасан дээр: "Эцэг эх, багш, орчин тойрных нь хүмүүс хүүхэд, залуучуудыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс хэрхэн хамгаалах вэ?" хэмээн бичнэ.
- Оролцогчдыг санал бодлоо хуваалцахыг хүснэ.
- Бүх санааг самбарт жагсааж бичээд товч тайлбарлана (Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.4, мөн Дасгал 8.1.4.-н Нэмэлт мэдээллийг ашиглана)

Алхам 6. Дүгнэлт – 5 минут

Дараах санааг дурдан дүгнэнэ:

- Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүсээгүй байхад нь хэн нэгэнтэй хүчээр бэлгийн хавьтал үйлдэхийг хэлнэ.

- Бэлгийн хүчирхийлэлд хохирогчийн буруу огт биш. Харин бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн хүч чадлаа буруу ашиглаж, хүчээр бэлгийн хавьталд орох эрхтэй хэмээх буруу хандлагаас шалтгаалдаг.
- Бэлгийн хүчирхийлэл нь бэлгийн дур хүсэл гэхээсээ илүүтэй хүч чадлаа буруугаар ашиглахтай холбоотой гэмт хэрэг юм.
- Бэлгийн хүчирхийлэл нь хэнд ч тохиолдож болно. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нь таньдаг, танихгүй хэн ч байж болно. Бүр гэр бүлийнх нь гишүүн ч байж болно.
- Насанд хүрэгчид нь хүүхэд, залуучуудыг бэлгийн хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах үүрэгтэй.
- Бэлгийн хүчирхийлэл, дарамт, халдлага үйлдэгдсэн тохиолдлыг мэдэгдэх нь маш чухал. Учир нь энэ бол гэмт хэрэг бөгөөд буруутан нь шийтгэл хүлээх ёстой.
- Хохирогчийг буруутгах нь шударга биш. Харин ч хохирогчид дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- Эрчүүд, хөвгүүдийг багаас нь охид эмэгтэйчүүдийг хүндэлж, үнэлж, сексийн хэрэглээ гэж үзэх хандлагаас татгалзаж сургах нь чухал.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.1.5 А: Бэлгийн хүчирхийлэлээс хэрхэн сэргийлж, хэрхэн даван туулах вэ?

Зааварчилгаа: Таних, танихгүй хүнд хүчирхийлүүлэхээс сэргийлж, мөн өртсөн тохиолдолд яах ёстой тухай дараах зөвлөмжөөс хэрэглээрэй.

Самбарын цаас 1: Танихгүй хүнд хүчирхийлүүлэхээс хэрхэн сэргийлэх вэ

- Танихгүй, таагүй санагдсан хүмүүст нэр хаяг, утасны дугаар зэрэг хувийн мэдээллээ бүү өгөөрэй.
- Цахимаар танилцсан хүндээ хэчнээн татагдсан ч хүнгүй газар эсвэл санал болгосон газарт нь уулзахаас татгалз. Уулзахаар бол олон хүнтэй газар, найзтайгаа хамт очих хэрэгтэй.
- Гэртээ ганцаараа байгаа тухайгаа хүнд бүү хэлээрэй.
- Харанхуйд хүнгүй газраар явахаас зайлсхийгээрэй.
- Хүнгүй газар ганцаар явах үедээ орчин тойрноо байнга ажиглаж бай. Танихгүй хүнд хэт ойр явж болохгүй. Шаардлагатай үед буюу хэн нэгэн дайрсан үед яаж зугтаж болох талаар бодож, ажиглаж явах хэрэгтэй.
- Шүхэр, таяг, цацлага зэрэг биеэ хамгаалахад хэрэг болохуйц зүйлс биедээ авч явж байх
- Өөртөө итгэлтэй байж, биеэ хамгаалахын тулд бие хамгаалах техникт суралцаарай
- Шүгэл зэрэг хүний анхаарал татахуйц чимээ гаргах зүйл авч явж байх
- Аль болох чангаар “Боль, холдооч, туслаарай” хэмээн хашхирч, тусламж хүсээрэй.
- Аюулгүй, хүн ихтэй газар руу зугтаж, тусламж хүсэхэд бэлэн яваарай.

Самбарын цаас 2: Таньдаг хүндээ хүчирхийлүүлэхээс хэрхэн сэргийлэх вэ

- Бусадтай харилцахдаа сексийн сэдэв рүү халтирахгүй байхаар тодорхой хязгаар тогтоож байх
- Энэхүү хязгаараа бүгдэд илэрхийлж, хүсээгүй зүйлдээ өөртөө итгэлтэйгээр “үгүй” гэж хэлэх
- “Үгүй” гэсэн хэрнээ бэлгийн сэдэлтэй үйлдлийг хүлээн зөвшөөрөх мэтийн холимог үйлдэл гаргаж болохгүй
- Эсэргүүцлийг чинь тоохгүй байвал хашхирч, тусламж гуйгаарай.
- Таагүй санагддаг хүнтэйгээ хоёулхнаа үлдэхээс зайлсхийгээрэй.
- Бэлгийн хүчирхийлэл өмнө нь үйлдэж байсан, хэт дээрэнгүй түрэмгий хүнтэй уулзахаас, хамт байхаас зайлсхийгээрэй.
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүстэй хамт байхаас зайлсхийгээрэй.
- Өөрийгөө хянах чадварт нөлөөлдөг тул өөрөө согтууруулах ундаа, мансууруулах бодис бүү хэрэглээрэй.
- Чамайг хэн ч сонсохгүй, тусламж авах ямар ч боломжгүй газруудаас зайлсхийгээрэй.
- Аюулгүй, хүн ихтэй газар руу зугтаж, тусламж хүсэхэд бэлэн яваарай.

Самбарын цаас 3: Бэлгийн хүчирхийлэлд өртвөл яах вэ

Хүчиндүүлэх нөхцөлд орсон үедээ:

- Аль болохоор зугтахыг хичээгээрэй.
- Хэрэв хүчинд автвал эсвэл олон хүн дайрсан тохиолдолд үхсэн мэт хамаг булчингаа суллаарай.

Эсэргүүцэх тусам хүчирхийлэгчид улам улайрч, бие махбодод илүү гэмтэл учруулах болно.

- Ийм үед гол төлөв цочролд орсон байдаг ч хэн яасныг аль болох сайн тогтоож авахыг хичээгээрэй (халдагчдын нүүр царай, онцлогийг тогтоох г.м.). Мөн тэднийг улам гааруулахгүй байхыг хичээгээрэй. Мэдээж үүнийг хийх амаргүй ч сүүлд нь чамд хэрэг болно.
- Хүчиндүүлсний дараа итгэж болох хүмүүс рүүгээ хурдан очоорой.

Хүчиндүүлсний дараа:

- Эмнэлэгт очихоосоо өмнө усанд орж, цэвэрлэгээ хийж болохгүй. Учир нь хүчиндүүлсний ул мөрийг арилгаж магад.
- Тусалж чадах хүн эсвэл хохирогчдыг хамгаалах байгууллагад хандаарай.
- Эмнэлэг, цагдаагийн газар руу итгэлтэй хүнтэйгээ хамт очоорой.
- Аль болох даруйхан эмнэлэгт үзүүлээрэй.
- Эмнэлгийн болон цагдаагийн тодорхойлолтыг хувилж аваарай.

Самбарын цаас 4: Эцэг эх, багш, орчин тойрных нь хүмүүс хүүхэд залуучуудыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс хэрхэн хамгаалж чадах вэ?

- Насанд хүрэгчид бүгд л хүүхэд залуусыг бэлгийн хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах үүрэгтэй. Иймд бэлгийн хүчирхийллийн гэрч болсон эсвэл энэ талаар сэжиг авсан даруйдаа тоолгүй орхиж болохгүй, ямар нэгэн арга хэмжээ авах хэрэгтэй.
- “Үгүй” гэж хэлэх эрхтэйгээ ч мэдэхгүй бага насны хүүхэд бэлгийн хүчирхийлэл, дарамтын хохирогч болсон байвал онцгойлон анхаарч, хамгаалах хэрэгтэй
- Орчин тойрон, ажлын байранд бэлгийн хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Орчин тойрон, хамт олонтойгоо нэгдэн, мэдлэг мэдээлэл түгээж, бэлгийн хүчирхийллийн эсрэг “Үүнийг бид тэвчихгүй” хөдөлгөөн өрнүүлж болно.
- Хүүхдийг багаас нь бусдыг хүндэлж, асуудал, зөрчлийг хүч хэрэглэлгүй шийдэж сургах хэрэгтэй:
 - o Хүүхэд залуучуудад асуудал гараад, шийдэх аргаа олохгүй байвал тусламж хүсэж байхыг ойлгуулаарай.
 - o Багаас нь бэлгийн боловсрол олгоход анхаарч, бэлгийн харилцаанд ороход талууд харилцан зөвшөөрсөн байх учиртайг тайлбарлаарай
 - o Хүйсийн тэгш эрхийн тухай, хүний болон хүүхдийн эрхийн тухай боловсролыг аль болох багаас нь өгөх
 - o Хүч хэрэглэж байгаа хүүхдүүдийг шийтгэх
- Хүчирхийллийг зогсоох ямар нэгэн арга олж, хэрэгтэнд хэлээд ч үг авахгүй тохиолдолд шударга ёс тогтоох арга зам руу хөтөлж өгөх хэрэгтэй.
- Хохирогчид шаардлагатай үед нь сэтгэл санааны болон материаллаг дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- Бэлгийн хүчирхийлэл нь гэмт хэргийн чанартай байдаг тул гэмтнийг заавал шийтгэх хэрэгтэй. Хүчирхийлэгчийг зохисгүй үйлдлээ зогсоохыг анхааруулж, шаардах хэрэгтэй.

Сэдэв 8.2 Согтууруулах ундаа болон мансууруулах бодисод хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?



Агуулга

Энэ сэдэвт мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээнээс үүсэх үр дагаврын талаар онцгойлон авч үзэх ба мансууруулах бодис, согтууруулах ундааны талаар үнэн зөв ойлголттой байх нь чухал болохыг оролцогчдод ойлгуулна. Ингэснээр оролцогчид ташаа ойлголт болон бодит баримтыг ялгаж, мансууруулах бодисоос татгалзах зөв үндэслэл, нотолгоо гаргаж сурна. Мөн үе тэнгийнхний зүгээс ирэх мансууруулах бодис хэрэглэх дарамтыг няцааж сурах нь сул доройн шинж биш, харин ч хүч чадалтай хүний шинж гэдгийг мэддэг болно.



Үндсэн мэдээлэл

- Архи, мансууруулах бодис хэрэглэх нь хүмүүсийн бодол санаа, бие махбодод маш муу нөлөөтэй төдийгүй осол, БЗДХ, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн хүчирхийлэл зэрэг туйлын аюултай үр дагаварт хүргэж болно.
- Архи, мансууруулах бодисын үзүүлдэг нөлөө нь хүн бүрд харилцан адилгүй байдаг ба жирэмсэн эмэгтэйчүүдэд болон урагт илүү хор хөнөөлтэй.
- Тамхи нь тухайн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, ойр тойрных нь хүмүүс, ялангуяа бага насны хүүхдэд илүү хортой нөлөөлдөг.
- Мансууруулах бодис, согтууруулах ундааны талаар ташаа ойлголтууд их түгээмэл байдаг. Бодит баримт, үнэн зөв мэдээлэлд суурилсан зөв шийдвэр гаргаж сурахад анхаараарай.
- Мэдээлэл сайтай бол өөрт таалагдаагүй саналыг няцааж, хүсээгүй зүйлээ хийхээс татгалзахад хялбар болно.
- Мансууруулах бодис хэрэглэхээс татгалзах нь сул доройн шинж биш, харин ч өөрийн биед хортой зүйлээс татгалзана гэдэг нь таныг хүчтэй болохыг харуулж байгаа юм. Бусдын зүгээс ирэх дарамт шахалтыг эсэргүүцэн, өөрийн байр сууриа хамгаалах нь сэтгэлийн тэнхээ, хувь хүний төлөвшлийн илрэл билээ.



Дасгалууд

- 8.2.1 Тойрог эргэлт: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөө
- 8.2.2 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний талаар шийдвэр гаргах
- 8.2.3 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын эсрэг нөлөөллийн ажил



Холбоотой сэдвүүд

- 5.4 Нийгмийн болон харилцааны ур чадварууд
- 7.3 БЗДХ, ХДХВ болон ДОХ гэж юу вэ?
- 8.1 Хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ?

Дасгал 8.2.1 Тойрог эргэлт: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөө



Зорилго

- Тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хүний бие болон ухаанд ямар сөрөг нөлөө үзүүлдгийг ойлгох
- Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний талаарх ташаа ойлголт болон бодит баримтыг ялгаж сурах
- Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хэрэглээтэй холбогдон гардаг аюултай бэлгийн харилцаа, бэлгийн мөлжлөг болон хүчирхийллийн эрсдэлийг ойлгох



Зорилтот бүлэг

Залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

Тоглоом тоглоход хүрэлцэхүйц зай гарган том талбайд сууна



Ашиглах материал

"ҮНЭН" болон "ХУДАЛ" гэсэн тэмдэглэгээ бэлдэх (өрөөний хаанаас ч харагдахуйц бичих)

Тоглоом 1:

- Ойролцоогоор 3 метр урттай олс буюу уяа 2 ш.

Тоглоом 2:

- Дунд нь тасархай зураасан тэмдэглэгээ хийсэн 2 ширхэг самбарын цаас
- 2 ш. самбарын үзэг эсвэл зүү



Сургалтын хэрэглэгдэхүүн

8.2.1 А: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын үйлчилгээ

8.2.1 Б: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын тухай өгөгдлүүд

8.2.1 В: Хариултын хуудас: Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Тойрог эргэлт тоглоом тоглох – 15 минут
2. Хэлэлцүүлэг – 20 минут
3. Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын тухай ташаа ойлголтууд ба бодит баримт – 20 минут
4. Дүгнэлт – 5 минут

Бэлтгэл

Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 Б-д байгаа өгөгдлүүдийг хайчлан авч, хуйлаад, том хайрцаг эсвэл шилэн саванд хийж, Алхам 2-т хэрэглэнэ.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Энэ дасгал нь согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний үр дагаврын талаар ярилцах эхлэл юм. Оролцогчдын мэдлэгийн түвшин, сонирхлоос хамааран, мөн зорилтот бүлгийн эргэн тойронд ямар төрлийн мансууруулах бодис элбэг байдаг зэргээс шалтгаалан хэр зэрэг дэлгэрэнгүй ярилцахыг сургагч багш шийднэ. Оролцогчид энэ талаар илүү их мэддэг байх тусам тэдгээрийн үр дагаврын талаар илүү нарийвчлан хэлэлцэх хэрэгтэй.

Алхам 1. Тойрог эргэлт тоглоом тоглох – 15 минут

Энэ дасгалаар согтууруулах ундаа, мансууруулах бодис нь хүний биед ямар нөлөө үзүүлдгийг мэдэх болно гэдгийг тайлбарлана. Дараах тоглоомоос аль нэгийг нь сонгож тоглоно.

Тоглоом 1:

Хоёр олсыг шалан дээр 3 метрийн өргөнтэй гудамж болгон байрлуулна. Оролцогчдыг хоёр багт хуваан хоёр олсны өмнө цуваа болгон зогсооно. Багийн гишүүдийн тоо ижил байхад анхаараарай. Хоёр багийн гишүүдийн тоо тэнцүү биш байвал сургагч багш нараас оролцон тоог тэнцүүлж болно. Хүн бүрд хувийн дугаар өгч, цувааны эхэнд зогсож байгаа хүмүүс багийн ахлагч болно.

Тоглоомын дүрмийг тайлбарла:

- Хоёр багийн гишүүд олсны дагуу явж олсны нөгөө үзүүрт очиж зогсоно.
- Эхлээд багийн ахлагч олсны нөгөө үзүүрт алхаж очно. 1 гэсэн дугаартай тоглогч олсны нөгөө үзүүрт алхаж очихоосоо өмнө дороо нэг эргэнэ. 2 гэсэн дугаартай тоглогч дороо хоёр удаа, 3 гэсэн дугаартай тоглогч гурван удаа, 4 гэсэн дугаартай тоглогч дороо дөрвөн удаа эргэх зэргээр багийн гишүүд өөрийн дугаарын тоогоор дороо эргэж, дараа нь олсны нөгөө үзүүрт очно.
- Багийн гишүүд явахаасаа өмнө хэдэн удаа эргэж байгаа, эргэж байгаа тоо нь зөв эсэхэд багийн ахлагч хяналт тавина.
- Эргэлдэж дуусмагц, толгойн эргээгээ гарахыг хүлээлгүй шууд явж эхлэх ёстой.
- Оролцогч олсны үзүүрт очсоны дараа дараагийн хүн эргэлдэж эхэлнэ. Түрүүчийн хүн зохих газраа очоогүй байхад дараагийн хүн эргэлдэж эхлэхгүй.
- Бүх гишүүд нь түрүүлж бариандаа очсон баг түрүүлнэ.

Тоглоом 2:

Хоёр самбарын цаасыг бие биеэс нь 3 метрийн зайтай хананд байрлуулаад цаасны голд самбарын үзгээр цэг зурна. Цэг нь 2 см-ийн хэмжээтэй байвал зохино. Оролцогчдыг хоёр багт хуваан цаасны өмнө цуваа болгон зогсооно. Багийн гишүүдийн тоо хоорондоо тэнцүү байх ёстойг анхаар. Хоёр багийн гишүүдийн тоо тэнцүү биш байвал сургагч багш нараас оролцон тоон тэнцүүлж болно. Цувааны эхэнд зогсож байгаа хүмүүс багийн ахлагч болж, хүн бүрд хувийн дугаар (1, 2, 3, 4 г.м) өгнө.

Тоглоомын дүрмийг тайлбарла:

- Энэ тоглоомын явцад оролцогчид цаасан дээрх цэг дээр өөр өнгийн үзгээр цэг зурна (Эсвэл цэгийн дээр зүү хатгаж болно).
- Багийн ахлагч самбарын цаасан дээр цэг зурж, үзгээ 1 дугаартай багийн гишүүнд дамжуулна.
- 1 дугаартай багийн гишүүн цэг зурахын өмнө дороо нэг эргэж, цэгээ зурсны дараа 2 дугаартай багийн гишүүнд үзгээ шилжүүлнэ. 2 дугаартай багийн гишүүн дороо хоёр удаа эргэж, цэгээ зураад 3 дугаартай багийн гишүүнд үзгээ дамжуулах маягаар тоглоом үргэлжилнэ.
- Оролцогч эргэлдэж дуусмагц толгой эргэхээ намдахыг хүлээлгүй шууд цэг зурна.
- Багийн ахлагч оролцогчдын хэдэн удаа эргэлдэж байгааг хянаана.
- Түрүүчийн хүн үзгээ өгмөгц дараагийн хүн эргэлдэж эхэлнэ.
- Бүх гишүүд нь түрүүлж цэг тавьж дууссан баг түрүүлнэ.

Алхам 2. Архи, мансууруулах бодисын нөлөөллийн талаар хэлэлцэх – 20 минут

Дараах асуултуудын дагуу бүгдийг хамарсан хэлэлцүүлэг хийнэ (Хариултуудыг сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 А-с үзнэ үү):

- Эргэлдэж байхад танд ямар мэдрэмж төрсөн бэ?
- Эргэлдэх нь хүн бүрд адил нөлөө үзүүлж байна уу?
- Та өмнө нь ийм зүйлийг мэдэрч байсан уу? Танд ямар мэдрэмж төрж байсан бэ?
- Согтууруулах ундаа эсвэл мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэсний дараа юу тохиолддогийг та мэдэх үү?
- Архи, мансууруулах бодис хэрэглэх нь хүн бүрд адил нөлөө үзүүлдэг үү?
- Ямар нөхцөлд архи, мансууруулах бодис хэрэглэх нь аюултай вэ? Яагаад?

Архи, мансууруулах бодисын сөрөг нөлөөллийн талаар ерөнхий ойлголттой болсны дараа дараах зүйлсийг тайлбарлаж өгнө:

Бидний өдөр тутмын амьдралд янз бүрийн хорт бодисыг санаатай болон санаандгүйгээр хэрэглэж байдаг. Хуулиар зөвшөөрсөн, хорьсон аль ч төрлийн мансууруулах бодис, архи тамхи нь тэдгээрийг хэрэглэсэн хүний бие махбод, сэтгэл зүйн эрүүл мэндэд янз бүрээр нөлөөлж байдаг химийн бодис агуулдаг. Зарим бодисыг бие махбод, сэтгэцийг эмчлэх зорилгоор хэрэглэдэг ч холбогдох эрсдэлүүдийг нь нарийн тооцож, урьдчилан сэргийлэх хэрэгтэй байдаг. Тийм төрлийн бодисуудыг хор хөнөөл багатай, эмчилгээнд хэрэглэх боломжтой тул эмчийн заавраар хэрэглэхийг хуулиар зөвшөөрсөн байдаг. Харин хууль бус гэгдэх мансууруулах бодис хэрэглэгчийн эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулж дасал болгох аюултай тул зах зээлд нийлүүлэхийг зөвшөөрдөггүй.

Алхам 3. Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын тухай ташаа ойлголтууд ба бодит баримт – 20 минут

Оролцогчдоос зайлсхийх, сэргийлэх хэрэгтэй ямар нэгэн бодисын талаар сонсож байсан эсэхийг асууна.

Бид мансууруулах бодисын тухай олон зүйл сонссон ч зарим нь үнэн, зарим нь худал байдаг гэж хэлнэ. Иймд бүгдээрээ аль нь үнэн, аль нь худал болохыг хамтдаа олж мэдэцгээе.

- Оролцогчдыг сандлаа өрөөний голоос холдуулж, хана дагуулж тавихыг хүснэ.
- Өрөөний нэг хананд “ҮНЭН” гэсэн тэмдэглэгээг, эсрэг хананд “ХУДАЛ” тэмдэглэгээг байрлуулна.
- Хайрцагт хийсэн Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 Б-с өгөгдлүүдийг гаргана.
- Оролцогчдыг бүгд өрөөний голд цуглахыг хүснэ.
- Хамгийн доод тал нь 10 өгөгдөл унших ба өгөгдөл тус бүрийг уншсаны дараа түүнтэй санал нийлж байгаа эсэхээ илэрхийлж, хананд байрлуулсан хоёр тэмдгийн аль нэгийн доор, аль болох хурдан очиж зогсохыг хүснэ. Сонголт хийж чадахгүй байгаа тохиолдолд таамаглал дэвшүүлж эсвэл хажуу талд зогсож болно.

Хэн нэгнийг сайн дураараа нэг өгөгдөл сугалж чангаар уншихыг хүснэ.

- Оролцогчид өөрийн хариултаа сонгосны дараа яагаад энэ хариултыг сонгосноо тайлбарлахыг хоёр талаас хүснэ.
- Хариултыг хэлэлцээд, залруулга шаардлагатай бол хэлж өгнө (Зөв хариултыг, тайлбарын хамт Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 В-с харна уу)
- Хариултыг сонсоод өөрийн саналаа өөрчилж болно гэдгийг оролцогчдод анхааруулна.
- Өөр хэн нэгэн оролцогчийг сайн дураараа дараагийн өгөгдлийг сугалж, уншихыг хүснэ. Энэ маягаар бүх өгөгдлийг уншиж дуустал эсвэл 20 минут дасгалыг үргэлжлүүлнэ.

Алхам 4. Дүгнэлт – 5 минут

Асуулт: Мансууруулах нөлөөтэй бодис болох хар тамхи, согтууруулах ундааны сөрөг нөлөө нь тэдгээрийг хэрэглэж байгаа хүмүүст хэрхэн илэрдэг вэ? (Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 В: Архи, мансууруулах бодисын нөлөө хэсгийг харна уу)

Хариулт: Сөрөг үр дагавар нь хүний амьдралын янз бүрийн талбар дээр, тэр дундаа гэр бүл, нийгмийн харилцаанд нь илэрдэг

- o Бие махбод: биеийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд
- o Оюун ухаан: сэтгэл зүй болон сэтгэл санааны эрүүл мэнд, оюун ухаан, аливааг шүүн тунгаах чадвар
- o Ажил болон сургууль: оролцоо, ажлын үзүүлэлт, сурлагын амжилт
- o Зан үйл: хувь хүний, гэр бүлийн, нийгмийн түвшинд

Дараах санааг тусгаж дүгнэлт хийнэ:

- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх нь эрүүл мэндэд хортой.
- Мансуурсан, согтсон үедээ ихэнх хүмүүс өөрийгөө удирдаж, эрүүл саруул шүүн тунгаах чадвараа алддаг.

- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх нь хүн бүрд өөр өөр үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал, архи огт уудаггүй хүмүүс эсвэл хүүхдэд бага хэмжээний архи хүчтэй үйлчилж амархан согтоож болно. Архи уудаг хүмүүсийн хувьд бага согтолт өгч болно.
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисыг хэрэглэх нь жирэмсэн эмэгтэйчүүд, урагт маш хор хөнөөлтэй. Ургийн хувьд тэдгээр бодист дасал болж, төрснийхөө дараа эрүүл мэнд нь маш аюултай хэмжээнд хүртэл хордсон байдаг.
- Жирэмсэн үедээ мансууруулах бодис хэрэглэх нь дутуу төрөлт, зулбалт, төрөлхийн гажиг, амьгүй төрөх, дутуу жинтэй төрөх зэрэгт хүргэх болно.
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний тухай бодит үнэнийг сайтар мэдэж авсныхаа дараа хэрэглэх үгүйгээ шийдэх нь зүйтэй.
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ нь осол аваар гаргах, БЗДХ авах, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн дарамт хүчирхийлэлд өртөх зэрэг хүсээгүй таагүй нөхцөл рүү хөтлөх нь бий
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисыг удаан хугацаагаар хэрэглэсэн хүний нөхөн үржихүйн чадвар сулардаг.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 А: Согтууруулах ундаа, мансууруулах бодисын үйлчилгээ

Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний үр дагавар¹⁵:

Биеийн эрүүл мэнд: • Тархины эд эсийг гэмтээнэ • Биеийн тэнцвэр, гүйцэтгэл алдагдана • Зохицуулалт алдагдаж, гэмтэл авах эрсдэл нэмэгдэнэ • Мартамхай болно • Биеийн мэдрэмж алдагдана • Зүрхний цохилт түргэсэж, цусны даралт нэмэгдэнэ • Хооллох дуршил буурна • Витаминь шимэгдэлт буурна Урт хугацаанд илрэх нөлөө • Зүрхний өвчин тусна • Элэг, уушигны хорт хавдар тусах өндөр эрсдэлтэй • Бөөрний дутагдалд орох өндөр эрсдэл	Сэтгэцийн эрүүл мэнд: • Сурлагын амжилт, ажлын бүтээмж буурна • Сэтгэл санаа, ааш зан огцом өөрчлөгдөнө • Зөв шийдвэр гаргах чадвараа алдана • Стресст орно • Сэтгэл гутрал • Амиа хорлох бодол төрнө Ажил, амьдралд үзүүлэх нөлөө: • Харилцааны бэрхшээл үүснэ • Хүчирхийлэх төлөв байдал давамгайлна • Сургууль, ажлаа тасална • Алдагдсан эрүүл мэндийг нөхөн сэргээхэд зардал их гарна • Нийгэмд зардал их гардаг
Нөхөн үржихүйн эрүүл мэнд: • Үргүйдэлд хүрэх (эр эсийн тоо, хөдөлгөөн багасаж, бэлгийн дур хүсэл буурч, сарын тэмдгийн мөчлөг тогтворгүй болж, эрт цэвэрших г.м.) • Нөхөн үржихүйн тогтолцоо гэмтэх Жирэмсэн эхчүүдэд: • Ургийн хөгжилд сөрөг нөлөөлөх • Дутуу төрөх, зулбах, амьгүй төрөх, жин багатай төрөх, нярайн гэнэтийн үхэл тохиолдох эрсдэл их • Нярай нь ээжийнхээ хэрэглэж байсан бодист дасал болох Урт хугацаанд илрэх нөлөө: • Савны, өндгөвчний, түрүү булчирхайн, хөхний хорт хавдар тусах эрсдэлтэй	Санаандгүй үр нөлөө – өндөр эрсдэл • Осол гэмтлийн улмаас бэртэх, амь насаа алдах • Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл г.м. ноцтой гэмт хэрэг үйлдэх • Хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орох • Өсвөр насныхны хувьд хүсээгүй бэлгийн харилцаанд орох • Бэлгийн олон хамтрагчтай болох • ДОХ, БЗДХ-н эрсдэл нэмэгдэх • Хүсээгүй жирэмслэлт

¹⁵ Эх сурвалж: *Friends Tell Friends on the Streets* by Greg Carl & Nonthathorn Chaiphech (Thai Red Cross AIDS Research Centre: Bangkok, 2000), Exercise High-Low, p. B-7.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 Б: Согтууруулах ундаа, тамхи болон мансууруулах бодисын тухай өгөгдлүүд

Зааварчилгаа: Баг бүрд нэг нэг хувь байхаар хувилж тараана. Өгөгдлүүдийг тус тусад нь хайчилж, багц болгоод баг бүрд нэг нэг багц өгнө.

----- ✂ -----

1. Зөвхөн удаан хугацаанд хэрэглэсэн тохиолдолд л архи асуудал үүсгэдэг.

----- ✂ -----

2. Тамхи хааяа татах нь хортой биш.

----- ✂ -----

3. Архи зарим хүнд илүү хүчтэй үйлчилгээ үзүүлдэг.

----- ✂ -----

4. Өсвөр насны хүүхэд архинд орох нь ховор үзэгдэл.

----- ✂ -----

5. Шар айраг уух нь хүндрэлтэй асуудал үүсгэхгүй.

----- ✂ -----

6. Марихуан татсаны дараа жолоо барих нь согтуугаар жолоо барихаас аюул багатай.

----- ✂ -----

7. Та согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жирэмслэх эсвэл БЗДХ, ДОХ/ХДХВ-ын халдвар авах ямар нэгэн эрсдэл байхгүй.



8. Согтууруулах ундаа, мансууруулах бодис үргүйдэлд нөлөөлдөг.



9. Жирэмсэн эхийн хэрэглэж байсан согтууруулах ундаа, мансууруулах бодист ураг дасал болдог.



10. Архи хэрэглэвэл та сексийг илүү сайхан мэдрэх болно.



11. Та олон жил тамхи татсан ч тамхинаас гарахад оройтохгүй.



12. Кофе, цай, амтлаг ундаанууд мансууруулах бодис агуулдаг.



13. Та өөртөө хяналт тавьж чаддаг бол архинд орохоос сэргийлж чадна.





Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.1 В: Хариултын хуудас: Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис¹⁶

Зааварчилгаа: Дээрх өгөгдлүүдийн зөв хариултууд өгөгдсөн болно. 2-р үе шатын хэлэлцүүлгийн үед дэлгэрэнгүй тайлбарлан ярилцана уу.

1. *Зөвхөн удаан хугацаанд хэрэглэсэн тохиолдолд л архи асуудал үүсгэдэг.*

Худал: Согтууруулах ундаа хэрэглэхэд хариу үйлдлийн хурд удааширч, зохицуулалт алдагддаг. Согтуу хүн ноцтой ослын шалтгаан болж болно.

2. *Тамхи хааяа татах нь хортой биш.*

Худал: Нэг тамхи татвал дахин татах хүсэл төрдөг. Учир нь никотин бол донтуулагч бодис юм. Иймд ямар ч хэмжээгээр тамхи татсан эрүүл мэндэд хортой бөгөөд уушгины хорт хавдар, уушги зүрхний өвчлөлд хүргэдэг. Мөн эргэн тойронд чинь байгаа хүмүүст, ялангуяа жирэмсэн эхчүүд болон бага насны хүүхдэд хортой.

3. *Архи зарим хүнд илүү хүчтэй үйлчилгээ үзүүлдэг.*

Үнэн: Тухайн хүний биеийн жин, уусан хэмжээ, мансууруулах бусад бодисын хэрэглээ, эрүүл мэндийн ерөнхий байдлаас хамааран хувь хүн бүрд өөр өөр үйлчилдэг.

4. *Өсвөр насны хүүхэд архинд орох нь ховор үзэгдэл.*

Худал: Дэлхий даяар архинд орсон хүмүүс бага наснаасаа ууж эхэлсэн байдаг.

5. *Шар айраг уух нь хүндрэлтэй асуудал үүсгэхгүй.*

Худал: Шар айраг нь согтууруулах бусад ундааны адил этилийн спирт агуулсан байдаг тул хүмүүсийг согтоодог. Шар айраг уух нь согтууруулах бусад ундааны нэгэн адил хүний биед хортой.

6. *Марихуан татсаны дараа жолоо барих нь согтуугаар жолоо барихаас аюул багатай.*

Худал: Аль аль нь зохицуулалтыг алдагдуулдаг. Хариу үйлдлийн хурд удааширч, осолд орох магадлал өснө.

7. *Та архи ууж, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жирэмслэх эсвэл БЗДХ, ДОХ/ХДХВ-ын халдвар авах ямар нэгэн эрсдэл байхгүй.*

Худал: Архи болон мансууруулах бодисын нөлөөн дор хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орох магадлал нэмэгдэж, ингэснээр хүсээгүй жирэмслэлт болон БЗДХ, ДОХ/ХДХВ-ын халдвар авах эрсдэл нэмэгдэнэ.

8. *Согтууруулах ундаа, мансууруулах бодис үргүйдэлд нөлөөлдөг.*

Үнэн: Урт хугацаагаар хэрэглэсний дараа эр эсийн тоо, хөдөлгөөн багасаж, бэлгийн дур хүсэл буурч, сарын тэмдгийн мөчлөг тогтворгүй болж, эрт цэвэрших зэргээр үргүйдэлд хүргэдэг.

9. *Жирэмсэн эхийн хэрэглэж байсан согтууруулах ундаа, мансууруулах бодист ураг дасал болдог.*

Үнэн: Жирэмсэн үед хэрэглэсэн согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөгөөр ураг тэдгээрт донтдог. Жирэмсэн үедээ метамфетамин, кокаин зэрэг мансууруулах бодис хэрэглэх

¹⁶ Эх сурвалж: *Friends Tell Friends on the Streets* by Greg Carl & Nonthathorn Chaiphech (Thai Red Cross AIDS Research Centre: Bangkok, 2000), Exercise: Myths and Facts about Drugs, p. B-28.

нь зулбах, ургийн зарим төрлийн гажиг үүсэх, дутуу төрөх, амьгүй төрөх, жин багатай хүүхэд төрөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

10. *Архи хэрэглэвэл та сексийг илүү сайхан мэдрэх болно.*

Худал: Архи мэдрэмжийг бууруулж, дур ханах явцыг удаашруулна. Удаан хугацаагаар согтууруулах ундаа хэрэглэх нь бэлгийн дур хүслийг бууруулж болно.

11. *Та олон жил тамхи татсан ч тамхинаас гарахад оройтохгүй.*

Үнэн: Тамхинаас гарахад хэзээ ч оройтохгүй. Хэрвээ таны уушги, зүрхийг ноцтой өвчлүүлж амжаагүй бол биеийн байдал амархан хэвийн байдалд эргэн орох боломжтой. Хэдийгээр тамхи татсанаас үүдэн бие тань ноцтой өвчилсөн ч тамхийг хаяснаар өвчний явц удааширч эхэлнэ

12. *Кофе, цай, амтлаг ундаанууд мансууруулах бодис агуулдаг.*

Үнэн: Кофе, цай болон олон төрлийн амтат ундааны найрлагад кофеин ордог бөгөөд сэргээх үйлчилгээ үзүүлдэг. Мөн энергийн ундаанд агуулагддаг кофеин нь хүнийг дасал болгодог. Хэрэглээгүй үед толгой өвддөг.

13. *Та өөртөө хяналт тавьж чаддаг бол архинд орохоос сэргийлж чадна.*

Худал: Архи нь донтуулдаг бөгөөд донтуулагч аль ч бодисын адил ухаан санаа, бие махбодод нөлөөлдөг.

Дасгал 8.2.2 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний тухай шийдвэр гаргах нь



Зорилго

- Нөхцөл байдалд шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх, ухаалаг шийдвэр гаргах, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой үе тэнгийнхний дарамтыг зохистой давж гарах
- Үндэслэлтэйгээр татгалзах чадварыг эзэмших дасгал хийх
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисоос татгалзах нь сул доройн шинж бус, харин хүч чадалтайн шинж болохыг ойлгох



Зорилтот бүлэг

Залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

6 баг болон сууна



Ашиглах материал

- 8.2.2-т өгсөн Сургалтын хэрэглэгдэхүүнээс баг бүрд нэгийг тарааж өгнө.
- Самбарын цаас, 1-2 самбарын үзэг, скочийг баг бүрд тарааж өгнө.



Сургалтын хэрэглэгдэхүүн

8.2.2 А: Үзүүлбэрийн өгөгдөл

8.2.2 Б: Жишиг түүхүүд

Бэлтгэл

Сургалт эхлэхээс 10 минутын өмнө 3 оролцогчийг, Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.2 А-т байх Үзүүлбэрийн өгөгдөлтэй танилцуулж, давуулна. Тэд зохиомж болон харилцан яриаг тод томруун илэрхийлж байгаа эсэхийг анхаараарай.



Сургалт зохион байгуулах алхмууд


1. Алтан Бадмаа хоёр – 20 минут
2. Багийн ажил: Жишээн дээр ажиллах – 20 минут
3. Багуудын танилцуулга – 15 минут
4. Дүгнэлт – 5 минут

Алхам 1. Алтан Бадмаа хоёр – 20 минут

Оролцогчдыг одоо тоглож үзүүлэх гэж байгаа үзүүлбэрт анхаарлаа хандуулахыг хүсээд 3 оролцогчоос үзүүлбэрээ үзүүлэхийг хүснэ (энэ нь цөөхөн минут үргэлжилнэ). Тоглолт дууссаны дараа үзүүлбэр үзүүлсэн оролцогчдод талархаж, хэлэлцүүлгийг дараах асуултаас эхэлнэ:

- Энэ юуны тухай түүх байсан бэ?
- Алтан болон Бадмаа нарын шийдвэрийн талаар юу гэж бодож байна?
- Бодит амьдралд ийм зүйл болдог уу? Яагаад?
- Хэрэв Алтан, Бадмаа нар өөр шийдвэр гаргасан бол энэ түүх хэрхэн өрнөх байсан бол?

Шийдвэр гаргах модыг дараах байдлаар танилцуулна:




- Энэ бол шийдвэр гаргах мод болохыг тайлбарлана. Энэ модон дээр Алтан болон Бадмаа нарын түүхийг зурж харцгаая.
- Алтан болон Бадмаа нарын нөхцөлийг алхам алхмаар авч үзье.
 - о Өмнөх хэлэлцүүлэгт үндэслээд модыг дүүргэн зурахыг оролцогчдоос хүснэ.
 - Асуудал юунд байсан бэ? (Алтан Бадмааг өөртэй нь хамт шар айраг уугаасай гэж хүссэн ч Бадмаа өөрөө уухыг, мөн Алтанг нэмж уугаасай гэж хүссэнгүй. Учир нь тэд мотоциклоор харих байв).

- о Асуудлыг “Асуудал” гэсэн нүдэнд бичнэ (хаалтад бичнэ) Тэгээд дараах асуултыг асууна.
 - Алтанд ямар сонголтууд байсан бэ? (Сонголт 1: Шар айраг уух. Сонголт 2: Шар айраг уухгүй)
- о Сонголт 1 нүдэнд “Шар айраг ууна” гэж бичнэ. Сонголт 2 нүдэнд “Шар айраг уухгүй” гэж бичнэ. Тэгээд дараах асуултыг тавина.
 - Сонголтуудын үр дагавар юу юу байх вэ?

Сонголт 1: Бадмаа Алтантай хамт мотоциклоор явахгүй.

Сонголт 2: Бадмаа үлдээд, хосууд хамтдаа Пепси ууна.)
- о Сонголт 1 болон Сонголт 2-н үр дагаврыг Үр дагавар 1 нүдэнд бичнэ.
- Алтан, Бадмаа хоёрын шийдвэрийн мод дараах байдлаар харагдана.



- Оролцогчдоос хоёр сонголтын аль алиных нь гарах үр дагаврууд өөр юу юу байж болох талаар эргэцүүлэхийг хүснэ. Жишээ нь, “1. Пиво уух” сонголтын нэг үр дагавар нь Алтан согтож, харих замдаа осолд орох эрсдэл.
- Дараах асуултыг тавьж, шийдвэр гаргах модны зураглалаа хийж дуусгана.
 - Алтангийн шийдвэр юу байсан бэ? (Шар айргийн оронд, пепси захиалах)
 - Яагаад тэр ийм шийдвэр гаргасан бэ? (Учир нь Бадмаа түүнтэй хамт шар айраг уухгүй байсан, мөн найзынхаа ослын түүхийг ярьсан. Алтан Бадмааг гэрт нь хүргэж өгөхийг хүссэн)
- Оролцогчид шийдвэрийн модны тухай ойлгосон эсэхийг асууна.

Алхам 2. Багийн ажил: Жишээн дээр ажиллах – 20 минут

Энэ алхмаараа оролцогчид багуудад хуваагдан, өмнөх түүхтэй төстэй түүхэн дээр ажиллана гэдгийг тайлбарлана.

- Оролцогчдыг 6 багт хуваана.
- Баг бүрд Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.2 Б-с нэг нэг түүх өгнө (Хоёр багт ижил түүх оногдоно) Түүх бүрийг багийн хэлэлцүүлгийг чиглүүлэх хэд хэдэн асуулт дагалдана.

- Баг бүр тус тусдаа түүхүүдтэй танилцаж, өмнөх жишээний дагуу түүхэд дүн шинжилгээ хийнэ.
- Баг бүрд самбарын цаас, 1-2 самбарын үзэг өгч, өөр өөрийн шийдвэрийн модыг зурахыг хүснэ.
- Багуудад ажлаа дуусгахад зориулж 15 минут өгнө.

Алхам 3. Багуудын танилцуулга – 15 минут

Түүх 1, Түүх 2, Түүх 3-аар зурсан өөр өөрсдийн шийдвэрийн модоо танилцуулахыг хүснэ (Цаг хэмнэх үүднээс нэг баг түүхээ танилцуулж, нөгөө баг шийдвэрийн модоо танилцуулж болно).

- Баг бүр танилцуулгаа дууссаны дараа ангиас түүх болон шийдвэрийн модны талаар саналаа хэлэхийг хүснэ.

Гурван түүхийг танилцуулж дууссаны дараа дараах асуултуудаар дүгнэлт хийнэ:

- Олонх залуу хүмүүст найзынхаа саналаас татгалзахад хэцүү байдаг. Танд ч бас ийм явдал тохиолдож байсан уу?
- Найз нарынхаа санал болгосон зүйлээс татгалзахгүй байх нь сул дорой зан мөн үү? Яагаад?
- Найз нөхдийнхээ саналыг ямар шалтгаанаар зөвшөөрч, ямар шалтгаанаар татгалздаг вэ?
- Найзынхаа хүсэлтэд татгалзаж байсан туршлагаа хуваалцана уу?
- Найзынхаа санал болгосон зүйлийг хийхийг хүсээгүй үедээ яах нь хамгийн зөв зам бол?

Алхам 4. Дүгнэлт – 5 минут

Дараах санааг онцолж, дасгалаа дүгнэнэ:

- Ямар ч шийд гаргасан байсан өөр өөрийн үр дагавартай. Зарим шийдвэр сайныг, зарим нь саарыг дагуулдаг эрсдэлтэй. Иймд ямар нэгэн алхам хийхээсээ өмнө үр дагаврыг нь сайтар бодолцох хэрэгтэй.
- Заримдаа хүмүүс чиний хүсээгүй зүйлийг, чамд сайн зүйл авчрахааргүй зүйлийг чамаар хийлгэх гэдэг. Ийм тохиолдолд татгалзах маш хэцүү байдаг.
- Хийхийг хүсээгүй зүйлээсээ татгалзаж байгаа нь чамайг сул дорой болгодоггүй. Харин ч энэ нь эсрэгээрээ чиний хүчирхэг болохыг илтгэж байгаа хэрэг. Бусдын дарамтыг сөрөн зогсоход оюуны маш их хүч, тэвчээр шаардагддаг.
- Найзын чинь чамд санал болгосон үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг мэдэж байх нь чухал. Ингэснээр эрсдэлийг тооцолгүйгээр үе тэнгийнхний дарамт шахалтад автахын оронд зөв шийдвэр гаргаж сурна.
- Өөрөө бүрэн итгэлтэй бус эсвэл ямар нэгэн зүйлийг хиймээргүй санагдсан үедээ хэн нэгний үгэнд шууд орж болохгүй. Чамайг хулчгар гэж дарамталсан ч үгэнд нь орох шаардлагагүй. Хэрэв чамайг хулчгар гэж хэлж л байгаа бол жинхэнэ найз биш гэсэн үг.
- Эрүүл мэндээ эрсдэлд оруулж, хэрэг төвөгт хутгалдах нь яавч ухаалаг, сайхан зүйл биш билээ. Өөртөө сөрөг үр дагавар авчрах зүйлд үгүй гэж хэлж сурах нь бие даасан, чадварлаг хүн болохыг чинь илтгэнэ.



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.2 А: Үзүүлбэрийн өгөгдөл

Зааварчилгаа: Доорх өгөгдлийг 3 оролцогчид өгч, давтаад хичээлийн эхэнд тоглож үзүүлэхийг хүснэ.

Алтан: “Бадмаа, хонгор минь. Хурдлаарай, бид оройтох нь”

Бадмаа: Би очлоо. Одоохон хамгаалалтын малгайгаа аваад очлоо”
(*Хоёул мотоциклоор хотын төв явав. Алтан Бадмааг ресторанд урив*)

Алтан: “Хонгор минь, энэ бол эндхийн хамгийн сайн ресторан”

Бадмаа: “Их сайхан юмаа”
(*Зөөгч ирэв*)

Алтан: Хоёр шил шар айраг авъя”

Бадмаа: “Би шар айраг уухгүй. Баярлалаа. Харин нэг шил пепси авъя”.
(*Алтан зөөгчийг хэсэг хугацааны дараа ир хэмээн дохио өгөв*)

Алтан: “Чи уур амьсгалыг эвдэх хэрэггүй шүү. Жаахан тайвшир Бадмаа. Аав ээж чинь угаасаа гэртээ байхгүй байгаа биз дээ. Надтай ганц уучих!”

Бадмаа: “Би шар айраг уумааргүй байна. Чи ч гэсэн уугаад хэрэггүй. Чи нэгээс хэтрүүлбэл би чамтай хамт мотоциклоор явахгүй”

Алтан: “Чи тэгээд надгүйгээр яаж харих болж байна? Санаа зоволтгүй дээ. Хэдэн шил шар айраг уучихаад зөндөө л жолоо барьж байлаа”

Бадмаа: “Алтан, би чиний ярихыг сонсоод гайхаж байна. Нэгээс илүү шил шар айраг уусан бол жолоо барьж огт болохгүй. Одоохон намайг гэрт хүргээд өг!”

Алтан: “Чи үнэнээсээ ярьж байна уу?”

Бадмаа: “Тэгэлгүй яах вэ! Би үнэнээсээ хэлж байна. Найз маань түрүүчийн долоо хоногт мотоциклтэй осолд орсон юм. Би аз туршмааргүй байна. Аав ээж маань ч намайг шар айраг уухыг сайшаахгүй. Намайг хүргээд өг, гуйж байна.”

Алтан: “Уучлаарай, Бадмаа. Би найзын чинь тухай мэдээгүй юм байна. Би өнөө орой ганцхан шар айраг уухаа амлая. Тэгээд чамайг гэрт чинь хүргэж өгнө”
(*Алтан зөөгчийг дуудав*)

Алтан: “Уучлаарай, би 2 шар айргаа болиод, найз охинтойгоо хамт пепси ууя”
(*Бадмаа инээмсэглээд, царай нь улайв*)

Алтан: “Чи яагаад инээсэн юм бэ?”

Бадмаа: “Чи намайг сая найз охин гэлээ. Чи өмнө нь хэзээ ч ингэж хэлж байгаагүй...”



Сургалтын хэрэглэгдэхүүн 8.2.2 Б: Жишиг түүхүүд

Зааварчилгаа: Тус бүр 2 хувь олшруулна. Алхам 2-н үед багуудад тарааж өгнө.



Түүх 1: Сүхээ, Хадаа хоёр багаасаа найзалсан билээ. Хадаа сахилгагүй, адал явдалд дуртай, байнга өөрийгөө сорьж явдаг. Харин Сүхээ яг эсрэгээрээ, дуу багатай, тайван, даруухан хүү байв. Өсвөр насандаа Хадаа гадуур гарах дуртай, архи пиво, тамхинаас буцахгүй, наргиан цэнгээн хөөх дуртай нэгэн болов. Тэгээд Сүхээтэй тааралдах болгондоо хамт явж пиво ууя гэдэг байлаа. Харин Сүхээ дандаа татгалздаг байв. Хадаа энэ бүхнээс залхсандаа Сүхээгээс зайгаа барьж эхэлсэн бөгөөд Сүхээ үүнд нь гуниглах болжээ.

Асуултууд:

1. Энэ түүхийн гол санаа нь юу вэ?
2. Сүхээд ямар сонголтууд байна вэ?
3. Сонголт бүрийн үр дагавар юу байж болох вэ?
4. Хэрэв чи Сүхээгийн оронд байсан ямар сонголт хийх байсан бэ? Яагаад?



Түүх 2: Цэлмэг, Сүрэн хоёр коллежийн 1-р курсээсээ хойш бие биеэ мэднэ. Цэлмэг ангийнхаа шилдэг оюутан бөгөөд харин Сүрэн жирийн нэгэн оюутан байсан ч сурлага нь улам муудах болов. Одоо тэд 3-р курс бөгөөд Сүрэн хичээлээ улам их таслах болж, Цэлмэгийн мэдэхгүй хүүхдүүдтэй найзлах болжээ. Сураг нь тэд нэгэн төрлийн мансууруулах бодис хэрэглэдэг бололтой. Цэлмэг сүүлийн үед Сүрэнтэй уулзалдаагүй удсан болохоор нэг өдөр гэрт нь очив. Турж эцээд, царай нь цонхийж цайсан Сүрэнг хараад Цэлмэг цочирдож, маш их санаа зовов. Хэсэг ярилцсаны дараа Сүрэн Цэлмэгт нэгэн улаан шахмал үзүүлээд, “Тархинд чинь сайн учир уучих. Чи хичээлдээ улам сайжрах болно” гэв. “Энэ чинь яг яадаг эд вэ?” хэмээн Цэлмэг асуухад “Чи шөнөжин унтахгүй байсан ч нойр чинь хүрэхгүй. Тэгэхээр шөнөжин хичээлээ хийж болно. Залгичих. Би чамд бэлэглээ” гэжээ. Цэлмэг яг яахаа сайн мэдэхгүй байлаа.

Асуултууд:

1. Энэ түүхийн гол санаа нь юу вэ?
2. Цэлмэгт ямар сонголтууд байна вэ?
3. Сонголт бүрийн үр дагавар юу байж болох вэ?
4. Хэрэв чи Цэлмэгийн оронд байсан ямар сонголт хийх байсан бэ? Яагаад?





Түүх 3: Батаа Цэцгээ хоёр үерхээд 3 сар болж байна. Цэцгээ нэгэн ресторанд зөөгчөөр ажилладаг. Харин Батаа засварын нэгэн газар ажилладаг. Нэг өдөр Батаа Цэцгээг дуудан, хөдөө хамт явахыг хүсэв. Батаа Цэцгээг шинэ машинаар авав. Тэрээр замдаа ээж аавдаа шинэ гэр худалдаж авах гэж байгаа, харин энэ бол миний машин хэмээн ярьж явлаа. Энэ бүхэн Цэцгээд сайхан санагдаж байв. “Засварын газрын ажил ийм цалин сайтай гэдгийг би мэдээгүй юм байна” гэхэд нь Батаа инээж, “Үгүй дээ, цалин тийм сайтай биш, амаргүй ажил болохоор би цалингаараа баяжиж чадахгүй. Гэхдээ хажуугаар нь орлого олох боломж байдаг юм” гэхэд нь Цэцгээ их гайхав. Сонирхож асуухаас нь өмнө Батаагийн утас дуугарч, яриа нь сонсогдов. Цаад хүн нь 20 сая төгрөгийн “юм” авах тухай ярих. 10 минутын дараа тэд замын хажуугийн рестораны дэргэд зогсов. Нөгөө хүн нь ч ирж, Батаатай хуучин найзууд шиг уулзсан бөгөөд Батаа түүнд нэгэн жижиг цүнх өгөхөд нөгөөх нь хариуд нь өнөөх 20 сая төгрөгийг өгөхийг харав. Тэгээд өнөөх хүн яваад өгөв. “Энэ чинь миний бизнес дээ. Чи ч гэсэн амархан баян болмооргүй байна уу?” гэж Батаа асуув.

Асуулт:

1. Энэ түүхийн гол санаа нь юу вэ?
2. Цэцгээд ямар сонголтууд байна вэ?
3. Сонголт бүрийн үр дагавар юу байж болох вэ?
4. Хэрэв чи Цэцгээгийн оронд байсан ямар сонголт хийх байсан бэ? Яагаад?



Дасгал 8.2.3 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын эсрэг нөлөөллийн ажил



Зорилго

Согтууруулах ундаа, мансууруулах бодисын эсрэг нөлөөлөгч байх



Зорилтот бүлэг

Залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

45 минут



Ашиглах материал

- Самбарын цаас
- 5-6 хайч
- Өнгө бүрийн самбарын үзэг
- Цавуу эсвэл скоч
- Баг бүрд хуучин сэтгүүл



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Багийн ажил: Нөлөөллийн ажлын зурагт хуудас бүтээх – 30 минут
2. Зурагт хуудсуудыг байрлуулж, үндсэн санааг нягтлах – 15 минут



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Энэ дасгалыг согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын нөлөөллийн талаар оролцогчид тодорхой мэдээлэл авсан Дасгал 8.2.1 “Тойрог эргэлт: Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөө” болон Дасгал 8.2.2 “Согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хэрэглээний талаар шийдвэр гаргах нь”-ын дараа ажиллаж болно. Энэхүү дасгалыг өмнөх дасгалаас олж авсан мэдээллийг оролцогчид ойлгосон эсэхийг хянахад хэрэглэж болно. Мөн оролцогчдод үе тэнгийнхний дарамт, ятгалгын эсрэг өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, үндэслэл нотолгоо гаргах, чухал гэж үзсэн мэдээллийг түгээх замаар өөрийгөө бүтээлчээр илэрхийлэхэд нь туслах юм. Энэ дасгалаар яригдсан асуудлыг нарийвчлан хэлэлцэх шаардлагагүй, зөвхөн алдааг засан хэлж өгөхөд хангалттай. Энэ дасгалын үед хийсэн бүтээлийг анги, сургууль, ажлын байранд, олон нийтэд үзүүлж болно.

Алхам 1. Багийн ажил: Нөлөөллийн зурагт хуудас бүтээх – 30 минут

Оролцогчдыг тус бүр 4 хүнтэй багуудад хувааж, тус бүрд нь самбарын цаас, өнгө өнгийн самбарын үзэг, хайч, цавуу, скоч, хуучин сэтгүүл өгнө.

Баг бүр олон нийтэд зориулан архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний эсрэг ямар уриалга, мэдээлэл хүргэж болох талаар эргэцүүлнэ. Зөвхөн нэг сэдвийг сонгож болно, хэд хэдэн сэдэв сонгосон ч болно, бүх сэдвийг ч сонгож болно. Ажлын байрандаа юм уу, амьдран суудаг орчныхоо хүмүүст зориулан зурагт хуудас хийнэ. Зурагт хуудсыг ямар ч загвараар хийж болно. Тухайлбал, самбарын цаасан дээр ямар нэгэн уриа бичээд зураг, текст, фотогоор чимэглэж болно. Сэтгүүлийн зураг ашиглаж болохын зэрэгцээ өөрсдөө зурсан ч болно.

Алхам 2. Зурагт хуудсуудыг харуулж, үндсэн санааг нягтлах – 15 минут

Зурагт хуудсуудыг оролцогчдод харуулна. Зурагт хуудас тус бүрийн бүтээгчдийг товч тайлбар өгөхийг хүснэ. Нарийвчилсан хэлэлцүүлэг хийх шаардлагагүй. Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний хор нөлөөг товч тайлбарлаж дасгалаа дуусгаарай.

- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх нь тухайн хүний бодож сэтгэх, өөрийгөө хянах чадварт сөргөөр нөлөөлж, маш аюултай нөхцөлд хүргэх эрсдэлтэй.
- Тамхи татах нь тухайн хүнийхээ төдийгүй эргэн тойронд нь байгаа хүмүүс, ялангуяа бага насны хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.
- Согтууруулах ундаа, мансууруулах бодисын тухай ташаа ойлголтууд маш түгээмэл байдаг. Иймд аль болох бодит баримтад тулгуурласан үнэн зөв мэдээлэл авч, түүндээ тулгуурлан шийдвэр гаргаж сурах хэрэгтэй.
- Мэдээлэл сайтай байхад хүсээгүй зүйлийг чинь хийлгэх гэсэн бусдын ятгалгад автахгүй, өөрийн үндэслэлээ хэлж эсэргүүцэхэд илүү хялбар байдаг.
- Мансууруулах бодисоос татгалзах нь сул дорой байгаагийн шинж биш юм. Харин ч танд тулгаж буй таагүй зүйлийг эсэргүүцэж чадаж байгаа нь таныг тэднээс илүү хүчирхэг болохыг харуулж байна.

УНШИХ МАТЕРИАЛ

Carl, Greg & Chaiphech, Nonthathorn, *Friends Tell Friends on the Streets*, Thai Red Cross AIDS Research Centre: Bangkok, 2000.

Haspels, Nelien, Kasim, Zaitun Mohamed, Thomas, Constance & McCann, Deirdre, *Action against Sexual Harassment at Work in Asia and the Pacific*, ILO: Bangkok, 2001.

ILO, International Programme on the Elimination of Child Labour (IPEC), *A Legal Review of National Laws and Regulations Related to Child Labour in Myanmar in Light of International Laws and Standards*, ILO: Geneva: 2015, (full report, Executive Summary):

http://www.ilo.org/ipecc/Informationresources/WCMS_IPEC_PUB_27436/lang--en/index.htm,
http://www.ilo.org/ipecc/Informationresources/WCMS_IPEC_PUB_27437/lang--en/index.htm.

ILO, *Meeting of Experts on Хүчирхийлэл against Women and Men in the World of Work*, Background paper for discussion at the Meeting of Experts on Хүчирхийлэл against Women and Men in the World of Work (Geneva, 3-6 October 2016), ILO: Geneva, 2016, http://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---gender/documents/meetingdocument/wcms_522932.pdf.

ILO, *Report of the Director-General, Fifth Supplementary Report: Outcome of the Meeting of Experts on Хүчирхийлэл against Women and Men in the World of Work*, Governing Body, 328th Session, Geneva, 27 October-10 November 2016 (GB.328/INS/17/5), ILO: Geneva, 25 October 2016,

http://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/---relconf/documents/meetingdocument/wcms_533534.pdf.

ILO, *Gender Equality in Migration Law, Policy and Management: GEM Toolkit*, ILO: Bangkok, 2016.

ILO Hanoi, Ministry of Labour, Invalids and Social Affairs (MOLISA), Coordinating Centre of Poverty Reduction (CCPR) of National Centre for Social Science and Humanities (NCSSH) of Viet Nam, *Gender Equality and Life Skills, Training Package for Young Women and Men in Viet Nam*, ILO: Hanoi and Geneva, 2004.

Ministry of Labour, Immigration and Population (MOLIP), Central Statistical Organization (CSO) and ILO, *Myanmar Labour Force, Child Labour and School to Work Transition Survey 2015 – Executive Summary Report*, ILO: Yangon, 2016,

http://www.ilo.org/yangon/whatwedo/publications/WCMS_516117/lang--en/index.htm.

Terhorst, Rosalinda, Haspels, Nelien, Gender and Development for Cambodia (GAD/C) & Expansion of Employment Opportunities for Women (EEOW), *Women Workers' Rights and Gender Equality: Easy Алхамs for Workers in Cambodia (WWRGE Manual - Cambodia)*, ILO: Bangkok, 2004.

United Nations Department of Economic and Social Affairs, *The World's Women 2015, Trends and Statistics*, 2015.

UNIFEM, *A Life Free of Хүчирхийлэл, It's Our Right! A Resource Kit on Action to Eliminate Хүчирхийлэл against Women*, UNIFEM: Bangkok, 2003.

World Health Organization, Department of Reproductive Health and Research, London School of Hygiene and Tropical Medicine, South African Medical Research Council, *Global and Regional Estimates of Хүчирхийлэл against Women: Prevalence and Health Үр дагавар of Intimate Partner Хүчирхийлэл and Non-partner Бэлгийн хүчирхийлэл*, 2013.

Frontier Myanmar: "Lifting the lid on child sex abuse," 16 October 2016,

<http://frontiermyanmar.net/en/lifting-the-lid-on-child-sex-abuse>.

Global New Light of Myanmar: "A silent emergency: Хүчирхийлэл against women and girls," 25 November 2016, https://www.unodc.org/documents/southeastasiaandpacific//myanmar/news-2016/25_Nov_16_gnlm.pdf.

Myanmar Now: "Abused at home, Myanmar women failed by law and traditions," 8 August 2016, <http://www.myanmar-now.org/news/i/?id=8cf2bacc-e043-4304-9a01-27ae8222a0e5>.

Myanmar Times: "More than half of rape cases involve children," 20 August 2015, <http://www.mmtimes.com/index.php/national-news/yangon/16063-more-than-half-of-rape-cases-involve-children.html>.

United Nations: "Хүчирхийлэл against women," https://unstats.un.org/unsd/gender/downloads/Ch6_VaW_info.pdf.

UN Women: "Бодит байдал and figures: Ending Хүчирхийлэл against women," <http://www.unwomen.org/en/what-we-do/ending-Хүчирхийлэл-against-women/facts-and-figures>.

World Health Organization: "Хүчирхийлэл against women," <http://www.who.int/mediacentre/factsheets/fs239/en/>.

Амьдрах ухааны сургалт

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо

Модуль 8. Хүчирхийлэл болон мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх

Энэхүү сургалтын багцыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат”-ны хүрээнд гаргав. Сургалтын багцад тусгагдсан үзэл бодол нь Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ilo.org/mongolia хаягаар авах боломжтой.